

STUDIA LINGUAE
INSTITUTI LINGUAE ET LITTERARUM ACADEMIAE
SCIENTIARUM REPUBLICAE POPULI MONGOLICI

Tom. I (XXIII)

Fasc 1—15

МОНГОЛ ХЭЛ ШИНЖЛЭЛ

ШИНЖЛЭХ УХААНЫ НОМ ХЭВЛЭЛИЙН
«ЭРДЭМ» ПҮҮС

1992

Олон улсын монголч эрдэмтний
VI их хуралд зориулав.

МОНГОЛ ХЭЛ ШИНЖЛЭЛ

Ерөнхий редактор: Хэл бичгийн ухааны
доктор, профессор
Д. Ёндон

Ботийн редактор: Хэл бичгийн ухааны
дэд эрдэмтэн
Ж. Сэржээ

ӨМНӨХ ҮГ

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн 1959 оноос «Хэл зохиол судлал» цуврал бичгийг гаргаж эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд нийт 23 ботийг хэвлүүлэн хэл бичгийн мэргэжилтэн, эрдэмтэд, гадаадын монгол судлаачдад барив.

Сүүлийн үед ном хэвлэлийн үнэ нэмэгдэж, цаас хомсдож байгаатай уялдан уг цуврал бичгийг энэ жилээс эхлэн «Монгол хэл шинжлэл», «Утга зохиол судлал» гэсэн 2 жижиг цуврал болгон салгаж байгаа юм. Энэ нь шинжлэх ухааны салбарууд улам нарийсан гүнзгийрч, хоорондын зааг ялгаа тодорч байгаатай ч бас холбоотой билээ.

«Монгол хэл шинжлэл»-ийн энэ дугаарыг, үсэг өрж хэвлэх болсон хэвлэлийн техникийн боломжоос шалтгаалсан зарим зүйлийг уншигчдад тайлбарлан уучлал гуйя. Үүнд:

1. Галигийн нэмэлт тэмдэг хэрэглэдэг авиан зүйн болон нутгийн алгууны судалгааны өгүүлэл бараг орсогүй.

2. Хэд хэдэн хүний өгүүлэлд байсан нилээд хятад үсгийг латин, кирилл үсгээр дуудлагыг нь тэмдэглэн оруулав.

3. Латин галигийн зарим тэмдэгтийг өрөх машины боломжид тохируулан хялбарчлав.

Цаашид манай цуврал бичгийг офсетээр хэвлэх боломжтой болсон үед энэ мэт арга ядсан зүйл арилна гэж итгэж байна.

Редактор

Л. Балдан

ТОДОТГОН ХОЛБОХ НӨХЦӨЛИЙН БАЙРЛАЛЫН ТОГТОЛЦОО, НАЙРУУЛГЫН ҮҮРЭГ

Монгол хэлний тодотгон холбох нөхцөлийг эрдэмтэд эртнээс нааш нэлээд судалсан боловч өөр өөр саналтай байдаг билээ. Монголч эрдэмтэн О. Ковалевский (1. 105—106) «-гч», «-сан (-сэн)», А. Бобровников (2. 136—139) «-гч», «-даг (дэг)», «-сан (-сэн)», «-га (-гэ)», «-ху (-хү)» Н. Н. Поппе (3. 121—123) «-гч», «-даг (-дэг)», «-ху (-хү)», «-хуй (-хүй)», «-хун (-хүн)», «-га (-гэ)», «-сан (-сэн)» Г. Д. Санжеев (4. 67—76) «-ха, -хэ», «-нхай, -нхой», «-han, -hen» «-aa⁴», «-даг⁴», «-гша», «-мал⁴», «-маар⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийг причастие, Ш. Лувсанвандан «Монгол хэлний зүй» (1939) гэдэг сурах бичигтээ «Нэр тэмдгийг үзүүлэх төлөв», «Орчин цагийн монгол хэлзүй» (1966)-д үйлт нэр гэж нэрлээд үйл үгэнд багтаажээ. Гэтэл А. Лувсандэндэв (7. 24-33) «Үйлт нэрийн үйлийн шинж чанарыг хадгалсан нь нэрийн шинж чанарыг агуулснаас илүү бус тул европын хэлний зүйн заншлыг дагаж, үйлт нэр гэдэг эдгээр үгсийг үйлийн айд оруулан үзэх үндэсгүй байна» гээд тусгай аймаг үг болгох санал тавьсан байна. Ш. Лувсанвандан (8. 26) цагийг зааж, тийн ялгалаар хувилдаг шинжээр нь цагт нэр гэж нэрлээд, нэрийн айд оруулсан бөгөөд П. Бямбасан (9. 79) цагаар тодотгон холбох үг гэж үзсэн нь уг нөхцөлөөр хэлбэржсэн үгийг юу гэж нэрлэх, ямар нөхцөлүүдийг хамааруулах, үгсийн аль айд оруулах талаар нэгдсэн саналгүй байгаа нь тодорхой байна. П. Бямбасангийн саналыг тусгаж, уг нөхцөлийг илэрхийлэх утга, дотоод мөн чанараар нь тодотгон холбох гэж нэрлээд, дотор нь өнгөрсөн, одоо, ирээдүй цагаар тодотгон холбох «-сан⁴, -aa⁴, -х», үйлийг эрхлэх, байнга үйлдэх, боломж заах үйлээр тодотгон холбох «-гч, -даг⁴, -маар⁴» гэж ангилав. Эрдэмтэд энэ нөхцөлийг судлахдаа төдийлөн анхаараагүй өнгөрсөн харьцааны утга, найруулгынх нь олон өнгө хувилбарыг илрүүлэн, цаашид бичиг зохиолд хэрхэн

яаж хэрэглэх боломжийг гаргах зорилт тавьж байна. Иймээс юуны өмнө тодотгон холбох нөхцөлийг албан бичиг, яриа, сонин, эрдэм шинжилгээний өгүүлэл, уран зохиолд хэр хэмжээтэй хэрэглэж байгааг бодит жишээгээр гаргах нь чухал байна. Энэ зорилгоор Ш. Лувсанвандан (10), Д. Нацагдорж (11), Л. Ванган (12) нарын түүвэр зохиол, албан бичиг, сонины эх хэрэглэгдэхүүн (13) зэргээс үйлийн нөхцөлөөр хэлбэржсэн 5000 үйл үгийг дэс дараалан түүвэрлэж хооронд нь харьцуулснаа хүснэгтээр харуулъя.

Үйлийн нөхцөлийн нэр	Нөхцөл	Албан бичиг	Яриа (жижиг)	Сонины өгүүлэл	Э/ш-ний өгүүлэл	Уран зохиол	Бүгд
ТОДОТГОН ХОЛБОХ НӨХЦӨЛ							
Өнгөрсөн цаг	- сан ⁴	134	123	136	251	94	738
Одоо цаг	- аа ⁴	14	44	55	10	15	138
Ирээдүй цаг	- х	399	178	232	208	186	1203
Үйлийг эрхлэх	- гч	1	—	3	—	7	11
Байнга үйлдэх	- даг ⁴	4	53	11	42	8	118
Боломж заах	- маар ⁴	—	4	—	—	—	4
Цаг заах нөхцөл	- на ⁴ - в - лаа ⁴ - жээ - чээ	87	196	152	154	143	732
Захирах хүсэх нөхцөл	- тэг хэл- бэр, - я, - е, - ё - аарай ⁴ - аач ⁴ , - г, - гтун ² - аасай ⁴ - тугай ² - уузай ² - сугай ²	29	59	1	76	19	184
Нөхцөлдүүлэн холбох нөхцөл	- ж - ч - аад ⁴ - н - саар ⁴ - вч - бал ⁴ - вал ⁴ - магц ⁴ - тал ⁴ - хлаар ⁴ - нгуут ² - нгаа ² - (х) - аа ⁴	332	343	410	259	528	1872

Хүснэгтээс үзэхэд тодотгон холбох нөхцөл «-сан⁴» 738, «-х» 1203 удаа тохиолдож албан бичиг, сонины өгүүлэлд «-х», эрдэм шинжилгээний өгүүлэлд «-сан⁴» нөхцөл зонхилох үүрэгтэй орсон байна. Үүнийг цааш нь гүнзгийрүүлэн үйлийн бусад нөхцөлүүдтэй харьцуулахад албан бичиг, яриа, сонин, эрдэм шинжилгээний өгүүлэл, уран зохиолд тодотгон холбох 2212, нөхцөлдүүлэн холбох 1872, цаг заах 732, захирах хүсэх нөхцөл 184 удаа орж, эдгээрийн дотроос тодотгон холбох нь төрөл бүрийн найруулгад их хэмжээтэй тааралдаж байгаа нь харагдлаа. Энэ бол хэлний хэрэгцээ юм. Үүнтэй уялдаж ийм өргөн хэрэгцээтэй нөхцөлөөр хэлбэржсэн үг, өгүүлбэрт ямар байрлалаар орж байна вэ? гэдэг асуудал урган гарч байна. Үгийн байрлалыг тогтооно гэдэг нь түүний тогтолцооны дэс дарааг гаргана гэсэн үг юм. Жишээлбэл: 1. Хүн малын УН-**ДАА болСОН ТОЙРОМ** бүрд уснууд (Д.Н) 2. Бүх дэлхийн ард түмэнд бүрэн **ЭРХИЙГ олгоГЧ ИНТЕРНАЦИОНАЛ** (С.Б) гэсэн хоёр өгүүлбэрийн тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн «**болСОН, олгоГЧ**» гэдэг үгс, ойролцоох үгтэйгээ хэлзүйн холбоосоор шүтэн барилдаж, өмнөхийгөө захиран, хойдох үгээ тодотгосон байна.

1. Таван хошуу мал маань бэлч**СЭН** (Н.Н). 2. Хүү минь ертөнцөд мэндлээд арван сар болж байг**АА** (Ц.Г) 3. Бид үеийнхээ нөхдийн итгэлийг хүлээ**ДЭГ** (Д.С) 4. Айл гэрийн маань түшиг чамайгаа наран дор хайрлаж яв**МААР** (Б.Я) 5. Дорж, Дулмаад хэлээгүй... үгээ өөр хүнд хэлэх бай**Х** (Ч.Л) гэсэн өгүүлбэрүүд тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн «бэлчсэн, байгаа, хүлээдэг явмаар байх» гэдэг үгсээр төгсжээ. Ажиглалт хийсэн эх хэрэглэгдэхүүнээс харахад тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үг «холхи газр**ААС** гялалз**САН** цаст өндөр хайрханууд» (Д.Н) «Монгол хүн бидний сэтгэл**ИЙГ** сор**СОН** орон» (Д.Н), «Энэ бол мин**ИЙ** төр**СӨН** нутаг» (Д.Н), «Хорин нэгэн он**Д** хий**СЭН** хувьсгал**ТАЙ** тэнц**ЭХ** хоёр дахь их нэгдэлжих хөдөлгөөний хувьсгал хийлээ» (Ц.Г), «Дуу хөгжмөөр нийт**ЭЭР** цэнгэ**Х** сайхан» (С.Б) гэх зэргээр өгүүлбэрийн дунд орохдоо өмнөх нэрээ «харъяалах, өгөх орших, заах, гарах, хамтрахын тийн ялгалаар, бас «өгүүл**Ж** байг**АА**» (С.Б), «хар**ААД** бай**МААР**» (Ж.Бя), «хүнгэнэ**Н** дуугара**ГЧ**» (С.Б), «чиглэ**СЭЭР** ирд**ЭГ**» (Д.Н), «оч**ВОЛ** зүгээр**СЭН** (Д.Б), «хар**МАГЦ** тань**ДАГ**» (Д.Н) «налай**ТАЛ** бэлч**СЭН**» (Ц.Г), «гэмши**ВЧ** бара**Хгүй**» (Д.Н), «хэлэ**ХЛЭЭР** бичи**Х**» (Ц.Д), «авах**АА** мартчих**ДАГ**» (Л.В) гэх мэтээр өмнөх үйл үгээ зэрэгцэх, урьдчилах, хам үргэлжлэх, болзох,

бэлтгэх, угтах, дутагдах нөхцөлөөр голдуу захирсан байна. Үүнээс үндэслэн тодотгон холбох нөхцөлийн байрлалын дэс дарааны ерөнхий бүдүүвчийг гаргая.

1. Өгүүлбэрийн дунд

НЭР	Т. Х. Н. Х. Ү	НЭР
-----+-----+-----		
Хүлэг (МОРИН уралдСАН ХӨНДИЙ) сайхан хоолойнууд (Д. Н)		

НЭР	Т. Х. Н. Х. Ү	ҮЙЛ
-----+-----+-----		
Энэ ертөнцөд (ЭНХ АМГАЛАН байДАГ БОЛООСОЙ) (С. Э)		
ҮЙЛ	Т. Х. Н. Х. Ү	ҮЙЛ
-----+-----+-----		

Ардын сайхан дууг (АЯЛАН дуулМААР САНАГДААД)		
	дандаа би дуулдаг (Ж. Ш)	
ҮЙЛ	Т. Х. Н. Х. Ү	НЭР
-----+-----+-----		

(ЦЭЛЭЛЗЭН урсах МӨРӨН)-ий хөвөөнд цэлгэр их тариа-лангийн талбай байна (Ц. Г) гэж тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үг, өгүүлбэрийн дунд хоёр нэр, үйл эсвэл үйл, нэр үгийн хооронд орж, хойдох нэр, үйл үгийнхээ шинж байдал, хэрхэн ямар байдлаар болж байгаагий нь тодотгож байна.

2. Өгүүлбэрийн эцэст

ҮЙЛ	Т. Х. Н. Х. Ү
-----+-----	
Ардын зоригийг (БАДРУУЛЖ явСАН.) Аз хийморийг (МАН-ДУУЛЖ явСАН) (Ц. Д)	
НЭР	Т. Х. Н. Х. Ү
-----+-----	

Ардын сургуульд хүү минь (ОНЦСАЙН сурДАГ) (Ц. Г) гэх мэтээр «-сан⁴, -даг⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үг, өгүүлбэрийн эцэст нэлээд, «-аа⁴, -маар⁴, -х» нөхцөлийнх цөөн, харин туслах үгтэй хамжиж «Дөрвөн морь идэж байгАА ХАРАГДАВ (Ч. Л), «Амьтны үр, ангирын зулзага эхээсээ ТӨРДӨГ юм. (Ч. Ч), гэх мэтээр орох нь их хэмжээтэй байна. Энэ байрлал дээр тулгуурлан тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үг, бусад үгтэй шүтэн барилдах боломжийг үлгэрлэн гаргая.

1

НЭР	-ын, -ийн, -н	ҮЙЛ
-----	-д, -т	-----
ҮНДЭС	-ыг, -ийг, -г + -тайз	-сан ⁴ , -аа ⁴ , -х + НЭР (ҮЙЛ) ҮГ
ҮНДЭС	-аас ⁴ , -аар ⁴ ,	ҮНДЭС -гч, -даг ⁴ , -маар ⁴

гэж тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үг, өмнөх нэрээ захиран хойдох нэр, үйл үгтэйгээ хамжих аргаар шүтэн барилдах хэлзүйн боломж харагдаж байна. (Жишээг 1-р хавсралтаас харна уу)

2

ҮЙЛ	- ж, - ч, - аад ⁴ , - н	ҮЙЛ	- сан ⁴
_____	- саар ⁴ , - бал ⁴ , (- вал ⁴)	_____	- аа ⁴
ҮНДЭС	- вч, - магц ⁴ , - тал ⁴ , +	_____	- х - гч + НЭР
_____	- хлаар ⁴ , - нгуут ² ,	ҮНДЭС	- даг ⁴ (ҮЙЛ) ҮГ
_____	- нгаа ² , - (х) - аа ⁴	_____	- маар ⁴

гэж тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үг, өмнөх үйл үгээ захиран хойдох нэр, үйл үгтэйгээ хамжих аргаар шүтэн барилдах хэлзүйн боломж байна. (2-р хавсралт)

3

ҮЙЛ	- сан ⁴ , - аа ⁴ ,	ҮЙЛ	- на ⁴ , - в,
_____	- х, - гч	_____	- лаа ⁴ ,
ҮНДЭС	- даг ⁴ , - маар ⁴	ҮНДЭС	- жээ, - чээ

гэх мэтээр тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үйл үгийг цаг заахын «- на⁴, - в, - лаа⁴, - жээ, - чээ» нөхцөлөөр хэлбэржсэн үгтэй хамжуулан _____ явСАН байНА (байВ, байЛАА, байЖЭЭ) гэсэн нийлмэл өгүүлэхүүн цөм болгож болно. (3-р хавсралт)

4

ҮЙЛ	- сан ⁴ , - аа ⁴ ,	ҮЙЛ	- я, - е, - ё, аарай ⁴ ,
_____	- х, - гч,	_____	- аач ⁴ , - гтун ² , - г,
ҮНДЭС	- даг ⁴ , - маар ⁴	ҮНДЭС	- уузай ² , - сугай ² ,
			- аасай ⁴

гэх зэргээр тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үйл үгийг захирах хүсэхийн «- я, - е, - ё, - аарай⁴, - аач⁴, - гтун², - г, - аасай⁴, - уузай², - сугай²» нөхцөлөөр хэлбэржсэн үгтэй хамжуулан _____ ирдЭГ байЯ (байгААРАЙ, байгААЧ) гэсэн нийлмэл өгүүлэхүүн цөм болгож болох хэлзүйн боломжтой гэж үзэж байна. (4-р хавсралт)-ыг харна уу. Энэ боломж нь хэлний хосолсон тогтолцоон дээр тулгуурлаж байгаа юм. Тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үг, өгүүлбэрийн дотор орохдоо өмнөх үгээ захирах, хойдох үгэндээ захирагдах дохио болдог. Ингэж тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үгийн ил харагдах байрлалыг нэгэнт тогтоосон учраас одоо далд байгаа харагдахгүй харьцааны утга, найруулгын өнгө аясыг илрүүлэх бололцоог олж байгаа билээ. Жишээлбэл:

Дөрвөн цагийн улиралд дурААРаа нүүх нутагтай. (Д.Н) Нэг л аятайхан харагдААД байДАГ болчихлоо. (Ц.Г) гэсэн хоёр өгүүлбэрийн тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн «нүүх, байдаг» гэдэг үгс урдах хойдох үгтэйгээ хэлзүйн холбоосоор шүтэн барилдахдаа 1. «Ирээдүй цагт болохыг заасан» 2. «Урьдчилан, байнга үйлдэж байсан» утгын харьцааг илэрхийлж байна. Тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үг, өгүүлбэрт орохдоо урдах хойдох үгтэйгээ хамтран «ирээдүй цагт зэрэгцэж болох», «өнгөрсөн, одоо, ирээдүй цагт болсон, болж байгаа, болох үйлийг нэрлэн заасан», «өнгөрсөн цагт болж өнгөрсөн», «одоо цагт хам болж байгаа» зэргийн олон янзын утгын харьцааг илэрхийлдэг билээ.

Тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үгийн илэрхийлэх харьцааны утгаас нь үндэслэн найруулгынх нь үүргийг гаргая. Үүнд:

1. «-сан⁴» нөхцөл

«-сан⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үг, өгүүлбэрийн дотор нэрийн өмнө орж, уг нэрийнхээ шинж байдлы нь тодотгох найруулгын үүрэг гүйцэтгэнэ. Жишээлбэл: Уралын баруун зүүн этгээдийг гэнэт улаан туг бүрхээд дарлагдСАН АРДЫН сэтгэлийг хөдөлгөв. (Д.Н)

«-сан⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийн ард «минь, чинь, нь», «мэт, шиг», «уу, үү» зэргийг дагуулбал үйлэнд өртөж байгаа юмыг хамаатуулах, адилтгах, асуух утга найруулгын өнгө аястай болгоно. Жишээлбэл: Та нарын ирСЭН ЧИНЬ маш сайн (Д.С), Энхрийлж өсгөсөн ээжээ ирСЭН ШИГ энгүй их баярлав (Н.Т), Нийгэм журмын байдал чам дээр тогтСОН УУ? Үгүй юу (Д.Н).

«-сан⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийн ард «л, ч», «шуу²», «даа⁴», «даг⁴» зэргийг дагуулж, болсон үйлийг улам лавшруулан батлах утга найруулгыг илэрхийлнэ. Жишээлбэл: Дөчин жилийн өмнө бичСЭН Ч эртдэхгүй. Түмэн жилийн дараа бичСЭН Ч оройтохгүй (Ч.Лх), Энэ зэргийн зүс царайтай хүүхэн... зэргэлдээ хошуунд байх л байСАН ШҮҮ ДЭЭ (М.А.А.З.Д.Б), Зун л тэгж сонстСОН ДОГ (М.А.А.З.Д.Б),

«-сан⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийн өмнө «үл, эс», ард нь «гүй» -г оруулж, болсон үйл явдлыг үгүйсгэх утга найруулгатай болгоно. Жишээлбэл: Тос хуруудыг ЭС идүүлСЭН Торго булгыг ҮЛ эдлүүлсэн (А.А.З), Араг шээзгий үүрмээ нь аргал түүхийг сурСАН ГҮЙ (М.А.А.З.Д.Б)

2. «-аа⁴» нөхцөл

«-аа⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийг нэрийн өмнө хамжуулан хэрэглэвэл уг нэрийн ямар шинж байдалтай, яаж бай-

гаагий нь тодотгох найруулгын үүрэг гүйцэтгэнэ. Жишээлбэл: Дээшилж явАА Монголын өсөж явАА Ро-гийн үс нь хархан бөгөөд борхон (Ц. Д), Ард чинь явАА бүсгүй хариутүй л гүйцэх нь байна шүү (Ц. Г).

«-аа⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийн ард «минь, чинь, нь», «даа²», «л», «бэ, вэ» зэргийг дагуулж, хамаатах, батлан эрчимжүүлэх, асуух найруулгаар хэрэглэж болно. Жишээлбэл: Нөгөө Дэжид... зүтгэж явАА НЬ тэр билээ (Ч. Л), Хүсэл мөрөөдөл намайг үүрч явАА ДАА Л би урамтай ахиж явна (Д. Со), Бурхны лам гуай байтлаа бүсгүйг юундаа хөөГӨӨ ВЭ? (М. А. А. З. Д. Б).

«-аа⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийн ард «гүй»-г дагуулж «Тагтаанд бүргэдийн хүч байгААГҮЙ. Тагтаанд шонхорын зориг байгААГҮЙ» (Д. С) гэж жирийн үгүйсгэхийн зэрэгцээ «Гэндэн гуай... явАА ГҮЙ Ч газаргүй, уулзАА ГҮЙ Ч хүнгүй шахам болжээ» (Ц. Д) гэж үгүйсгэн батлах найруулгын өнгө аястай болгоно.

3. «-х» нөхцөл

«-х» нөхцөлөөр хэлбэржсэн үгийг нэрийн өмнө бичвэл уг нэрийн ямар байдалтай болохыг тодотгох найруулгын үүрэг гүйцэтгэнэ. Жишээлбэл: Алсын улирлыг авцгааХ БАГАЧУУД мөн өө бид бэлхэн ээ (Д. Н), Чиний тормолзоХ НҮД, инээмсэглэХ ААШ миний сэтгэлийг баярлуулав (Ц. Д).

«-х» нөхцөлөөр хэлбэржсэн үгийн ард «минь, чинь, нь», «уу²», «шиг» зэргийг дагуулж хамаатуулах, асуух, адилтгах утга найруулгатай болгоно. Жишээлбэл: Уул ус тэгш бол жигүүртэн донгодоХ НЬ ЯРУУ (Д. Н). Шаналсан зүрх нь тайвшраХ ШИГ болдог байжээ (Д. С), Үүл өөд нисэХ ҮҮ? Уул өөд харайХ УУ? гэх шиг хүлэг минь тогтож, ядан дүүхэлзэнэ (Д. С).

«-х» нөхцөлөөр хэлбэржсэн үгийн ард «гүй» өмнө нь «үл, эс»-ийг оруулж, үгүйсгэх эсвэл үгүйсгэн батлах найруулгатай болгож болно. Жишээлбэл: Энэ хүлэг минь өтлөХ ГҮЙ ЭЭ. ЭНЭ хүлэг минь эцэХ ГҮЙ ЭЭ (Жан. Ш). Хоёр нүдээр үзсэнээ ЭС алдах вэ (М. А. А. З. Д. Б).

«-х» нөхцөлөөр хэлбэржсэн үгийг өгүүлбэрийн эцэст туслах үгтэй хамжуулан, батлан илэрхийлэх найруулгаар хэрэглэнэ. Жишээлбэл: Болор шил шиг тунгалаг усан байХ ЮМ (С. Д).

4. «-гч» нөхцөл

«-гч» нөхцөлөөр хэлбэржсэн үгийг аливаа нэг үйлийг голлон гүйцэтгэж байгаа хүн гэсэн утга найруулгын үүргээр

ихэнх тохиолдолд хэрэглэнэ. Жишээлбэл: АмьдраГЧ БҮХЭН чамд мянга мянган баярыг хүргэнэ (Д.Н).

«-гч» нөхцөлөөр хэлбэржсэн үгийг нэрийн өмнө бичиж, уг нэрийн ямар байдалтай болохы нь тодотгох найруулгын үүргээр хэрэглэдэг. Жишээлбэл: Удирдан жолоодоГЧ НАМ УЛС-ДАА цогт баярын үгээ уламжлан дээшээ дэвшүүлье (Ч.Ж).

5. «-даг⁴» нөхцөл

«-даг⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийг нэрийн өмнө бичвэл үйл явдлын байнга эсвэл дахин давтан болж байгааг тодотгох утга найруулгын үүргийг гүйцэтгэнэ. Жишээлбэл: ХэлДЭГ ГУРАВ, хийДЭГ ГАНЦ гэж байжээ (Ц.Д).

«-даг⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийн ард «шиг», «л, ч», «минь, чинь, нь», «шуу²», «даа²» зэргийг дагуулан, үйл явдлыг адилтгах, эрчимжүүлэх, хамаатуулах, асуух, батлах найруулгын өнгө аястай болгоно. Жишээлбэл: Уран шувуу шамдаж үүр юүгээн барьДАГ ШИГ урьд хэзээ ч байгаагүй үйлдвэр завод босгов (Ж.Бя), Жигүүртэн шувуу дуу дуулДАГ Л юм байна шүү дээ (Д.Д), Тасалгаанаасаа гараад, хөдөөгийн амьдралтай танилцДАГ Ч болоосой (Ц.Г), Сорилж идДЭГ НЬ чи юм уу (Д.Ж), Аяны урт замыг бид алс гэж ярьДАГ ШҮҮ ДЭЭ (Л.Х).

«-даг⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийн ард «гүй»-г дагуулан, дахин давтан болж байгаа үйл явдлыг үгүйсгэх утга найруулгатай болгоно. Жишээлбэл: Тивээр бид ялгаДАГ ГҮЙ. Эвээр бид ярьдаг (Ч.Ч). Үгүйсгэсэн үгийнхээ ард батлах, хамаатуулах үг оруулж, улам үгүйсгэн батлах эсвэл хамаатуулах утга найруулга илэрхийлж болно. Жишээлбэл: Уулнаас өндөр улиас байДАГ ГҮЙ ДЭЭ ХӨӨ (М.А.А.З.Д.Б), Сардаа эргээд ирдЭГ ГҮЙ ЧИНЬ санаагүйн хэрэг шүү дээ (М.А.А.З.Д.Б),

6. «-маар⁴» нөхцөл

«-маар⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийг нэрийн өмнө бичвэл уг нэрийг ямар янз байдалтай болохыг тодотгох найруулгын үүрэг гүйцэтгэнэ. Жишээлбэл: Ууланд унасан жавар нь бол уурга алдМААР жавар юм аа хө хө хө хө (А.А.З).

«-маар⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийн ард «гүй», «л» зэргийг дагуулж, үгүйсгэн батлах найруулгын өнгө аястай болгоно. Жишээлбэл: Малаа дагасан малчин ч тэсМЭЭР ГҮЙ Л шуурга болжээ (Ш.Ц).

«-маар⁴» нөхцөлөөр хэлбэржсэн үгийг давтан хоршиж, үйл явдал ямар байдалтай болж өнгөрснийг заасан утга найруулгын үүргээр хэрэглэнэ. Жишээлбэл: Миний хэнз хурга... өвөр дээр минь гараад өхөөрдМӨӨР өхөөрдМӨӨР эрхэлдэг (Д.Н)

гэх зэргээр орчин цагийн монгол хэлний тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үгийн байрлал, бусад үгтэй шүтэн барилдаж болох боломж, найруулгынх нь үүргийг гаргаснаараа хэлний үзэгдлүүд бол хоорондоо шүтэлцсэн холбоотой, нэг нь нөгөөгүйгээр байж болохгүй шаталсан олон тогтолцоо болохыг батлан харуулж байна.

ТОВЧИЛСОН НЭРИЙН ХЭЛХЭЭ

а. Зохиолчийн нэр

Б. Я. — Б. Явуухулан	Ж. Ш. — Ж. Шагдар
Д. Б. — Д. Батбаяр	Жан. Ш. — Жан. Шагдар
Д. Д. — Д. Даржаа	Л. В. — Л. Ванган
Д. Ж. — Д. Жамъян	Л. Л. — Л. Хуушаан
Д. Н. — Д. Нацагдорж	Н. Н. — Н. Наваан-Юндэн
Д. С. — Д. Сэнгээ	Н. Т. — Н. Тэрбиш
Д. Со. — Д. Содномдорж	С. Б. — С. Буяннэмэх
Ж. Бя. — Ж. Бямбаа	С. Д. — С. Дашдооров
С. Э. — С. Эрдэнэ	Ч. Л. — Ч. Лодойдамба
Ц. Г. — Ц. Гайтав	Ч. Лх. — Ч. Лхамсүрэн
Ц. Д. — Ц. Дамдинсүрэн	Ч. Ч. — Ч. Чимид
Ч. Ж. — Ч. Жигмид	Ш. Ц. — Ш. Цогт

б. Хэлзүйн нэр томъёо, номын нэр

- А. А. З. — Ардын аман зохиол
 М. А. А. З. Д. Б. — Монгол ардын аман зохиолын дээж бичиг
 Т. Х. Н. Х. Ү. — Тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үг

НОМ ЗҮЙ

1. О. Ковалевский., «Краткая грамматика монгольского книжного языка» Казань. 1835.
2. А. Бобровников «Грамматика монгольско-калмыцкого языка» Казань., 1849.
3. И. Н. Поппе «Грамматика письменно- монгольского языка» М—Л., 1937.
4. Г. Д. Санжеев «Грамматика бурят монгольского языка» М-Л., 1941.
5. Ш. Лувсанвандан «Монгол хэлний зүй» 1939
6. «Орчин цагийн монгол хэлзүй» УБ., 1966.

7. А. Лувсандэндэв «Монгол хэлний үгсийн аймгийг ангилах тухай асуудалд» (Монгол бичгийн асуудлууд) 1956
8. Ш. Лувсанвандан «Орчин цагийн монгол хэлний бүтэц» Монгол хэлний үг нөхцөл хоёр нь. УБ., 1968.
9. «Хэл зохиол судлал» УБ., 1982. том XV.
10. Ш. Лувсанвандан «Монгол хэл шинжлэлийн асуудлууд» УБ., 1981.
11. Д. Нацагдорж «Зохиолууд» УБ., 1961.
12. Л. Ванган «Хэн хэлсэн юм бэ? (Жүжиг, кино, тууж, өгүүллэг) УБ. 1971.
13. «Социалист уралдааныг удирдах сайжруулах тухай» тогтоол, «Шинийг салаачлагчдын нэгдсэн бүтээлч бригадын заавар, дүрэм», «Тариалагчийн үйлдвэрлэл ардын хяналт», Цувааны дүн гарав. «Үнэн» сонин. 1983. № 103 (15439)

ХАВСРАЛТУУД

I Хавсралт

аавЫН→	— авСАН — аваХ — авДАГ ---→ ном; — авМААР	орСОН явАА очиХ (залуу) (байх) ирДЭГ орМООР
ээжИЙГ→ дага	— САН — АА — Х ---→хүүхэд — ГЧ (байх) — ДАГ — МААР	ижлЭЭС хоцорсон унага (байх) хотООС явАА хүн (байх) хөдөөнӨӨС ирЭХ авгай (байх) алсААС хараГЧ дуран (байх) гадаадААС ирДЭГ бараа (байх) эндЭЭС харагдМААР газар (байх)
ахаАР өгүүлСЭН ном (байх) уулААР явАА хүн (байх) мориОР очих хүүхэд (байх) хэвлЭЭР яваГЧ амьтан (байх) талаАР давхиДАГ гөрөөс (байх) машинААР хийМЭЭР эдлэл (байх)	— ирсЭН — явАА — уулзаХ ахТАЙ — ярилцаГЧ ---→хүн — мэндэлДЭГ (байх) — уулзүүлМААР	

II Хавсралт

1	2
явЖ байСАН (байх) (хүн) ирЖ явАА (байх) (хүн) орЖ ирЭХ (байх) (хүн) гарЧ яваГЧ (байх) (хүн) орЖ ирДЭГ (байх) (хүн) өгсөЖ гарМААР (байх) (хүн)	ирЭЭД байСАН (байх) (ээж) харААД суугАА (байх) (ээж) орООД ирЭХ (байх) (ээж) харААД суугЧ (байх) (хүн) гарААД явМААР (байх) (хүн)
3	4
угтАН ирСЭН (байх) (хүн) тосоН очОО (байх) (хүн) угтАН очих (байх) (хүн)	сууСААР байСАН (байх) (хүн) сууСААР байГАА (байх) (хүн) нүүСЭЭР байХ (байж) (айл)

угтаII очигЧ (байх) (хүн)
 тосол очДОГ (байх) (хүн)
 угтаII очМООР (байх) (хүн)

5

очВОЛ байСАН байх
 очВОЛ байГАА байх
 очВОЛ аваХ байж
 очВОЛ аваГЧ (байх)
 эрВЭЛ олДОГ (байх)
 оролдВОЛ сурМААР (байж)

7

явМАГЦ очСОН (байх) (хүн)
 хэлМЭГЦ ойлГОО (байх) -"
 хүрМЭГЦ унаХ (байх) (сав)
 харМАГЦ санаачлагЧ (байх)
 (хүн)
 очМОГЦ угтДАГ (байх) (хүн)
 хэлМЭГЦ бичМЭЭР (байж) (хүн)

9

очиХЛООР очСОН (байх) (хүн)
 суулгаХЛААР босОО (болох)
 (мод)
 яваХЛААР үдэх (байх) (хүн)
 очиХЛООР угтДАГ (байх) (хүн)
 яваХЛААР дагаМААР (байж)
 (хүн)
 зочлоХЛООР үйлчлэгЧ (байж)
 (хүн)

11

яваНГАА харСАН (байх) (хүн)
 унаНГАА бэртЭЭ байх -"
 яваНГАА очих (байх) (хүн)
 сонссоНГОО бичигЧ байж (хүн)
 үзэНГЭЭ хэлДЭГ (байж) (хүн)
 хараНГАА хийМЭЭР (байж)
 (хүн)

III Хавсралт

явСАН —
 хэвтЭЭ —
 ирэх — байнА
 үзэгЧ — → байВ
 очДОГ — байЛАА
 очМӨӨР — байжЭЭ

нүүСЭЭР байГЧ (байх) (айл)
 явСААР байДАГ (байж) (хүн)
 үзСЭЭР байМААР (байж) (хүн)

6

уншиВЧ ойлгоСОН (гүй) байж
 өгөВЧ аваХ гүй (байх) (хүн)
 өгөВЧ авАА гүй (байх) (хүн)
 өгөВЧ авДАГ гүй (байх) (хүн)
 өгөВЧ авМААР гүй (байж) (хүн)

8

нртЭЛ хүлээСЭН (байх) (хүн)
 унаТАЛ босОО (байх) (хүн)
 явТАЛ хүлээХ (байж) (хүн)
 цочТОЛ хашгираГЧ (байж) (хүн)
 харТАЛ инээДЭГ (байж) (хүн)
 дуудТАЛ очМООР (байж) (хүн)

10

очиНГУУТ тосСОН (байх) (хүн)
 хэлэНГҮҮТ угтаА (байх) -"
 хэлэНГҮҮТ ойлгоХ (байх) (хүн)
 дуулаНГУУТ дамжуулагЧ байж -"
 шидэНГҮҮТ барьДАГ (байх) (хүн)
 эрэнГҮҮТ олМООР (байж) (хүн)

12

ява (х) АА больСОН байх (хүн)
 хара (х) АА болиО (байх) (хүн)
 өгө (х) өӨ болиХ (байх) (хүн)
 ява (х) АА болиГЧ (байж) (хүн)
 үзэ (х) эЭ явДАГ (байх) (хүн)
 ява (х) АА больМООР (байж) (хүн)

IV хавсралт

— очСОН	— я
— босоо	— аарай
— үзэх	бай (г) → — аач
— очигЧ	— гтун
— өгДӨГ	— г
— олМООР	— аасай
	— тугай
	— уузай
	— сугай

Л. Болд

ҮГСИЙН АЙМГИЙН СИСТЕМД ТӨЛӨӨНИЙ ҮГИЙН ЭЗЛЭХ БАЙР

Монгол, түрэг хэлний хэлзүйн байгууллыг судалсан бүтээлүүдээс үзвэл уг салбар ухааны нэгэн гол судлагдахуун нь тухайн хэлнүүдийн үгсийг аймаглах тухай асуудал гэдэг нь тодорхой. Энэ нь уг хэлнүүдийн бүтэц, тогтолцоог гаргахад үгсийн аймгийн асуудал чухал байртай байгаагаас шалтгаалсан хэрэг бөгөөд тиймээс ч «...үгсийн аймгийн асуудал бол өгүүлбэрийн гишүүдийн тухай асуудлын адил хэлзүйн чухал бөгөөд зангилаа асуудал (Лувсандэндэв 1, 24)» гэж эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Тухайн хэлнүүдийн өөрөөр хэлбэл түрэг, монгол (цаашилбал залгамал) хэлний хэлзүйг хам болон цуваа цагийн үүднээс нарийвчлан судалсан бүтээлүүдэд эдгээр хэлний үгсийг аймаглах талаар олон зөрүүтэй санал гарч байгаагаас үзсэн ч үгсийг аймаглах гэдэг нь хичнээн нарийн түвэгтэй асуудал болох нь тодорхой. Энд түрэг хэлний үгсийг аймаглах тухай тэр бүр ярилгүйгээр дан ганц монгол хэлний үгсийг аймаглах талаар гарсан бүтээлүүдийг тоймлон үзсэнээс ч ойлгомжтой. Гэвч эдгээр санал дүгнэлтийг бүгдийг энд шүүн ярилцах боломжгүй учир монгол хэлний үгсийг аймаглах талаар гарсан зарчмын чанартай бүтээлүүдийг голлон авч үзэж, улмаар монгол хэлний үгсийн аймаглалд төлөөний үг ямар байр эзлэх талаар өөрийн саналыг хэлэхийг хүссэн билээ.

Өнөөдрийг хүртэл эрдэм шинжилгээний эргэлтэд ороод байгаа монгол хэлний хэлзүйн бүтээлүүдэд монгол хэлний үгсийг аймаглахдаа «нэг бол энэтхэг төвдийн хэл шинжлэлийн уламжлалыг баримтлан ангилж, эсвэл ром европын хэл шинжлэлийн ангиллыг баримталсаар ирсэн (Лувсанвандан 2. 225)» бөгөөд харин сүүлийн үед монгол хэлний үгсийг бүтэц хэл шинжлэлийн аргаар ангилах талаар нэлээд амжилт олж байна.

1. Энэтхэг төвд хэл шинжлэлийн үүднээс монгол хэлний үгсийг аймаглаж байсан уламжлалыг бид монгол хэлзүйн

бичгүүдээс тодорхой мэдэж болно. Хэрэг дээрээ бандида Чойж-Одсэрээс эхтэй, энэтхэг төвдийн хэл шинжлэлийн дээр монгол хэлний хэлзүйг судалсан, цаг хугацааны хувьд авч үзвэл арай хожуу үед хамаарагдах бүтээлүүдэд «...үсгүйн хурийажу нер-е болоху, нер-е-ий хурийажу үге болоху үсгүйер удха-ий үзегүлкү тер чаг-тур нөкүчел керегтей болай (Балданжапов 3. 46)» гэж дурдсан байна. Энэ хэсэгт дурдсан үсэг, нэр, үг нөхцөл гэсэн нэр томъёог орчин цагийн монгол хэл шинжлэлийн нэр томъёотой онолдуулан буулгавал үсэг гэдэг нь авиалбар, нэр гэдэг нь үг, үг гэдэг нь өгүүлбэр, нөхцөл гэдэг нь үг хувилгах бүтээвэр гэсэн үг болох бөгөөд дээр иш татсан хэсгийг орчин цагийн монгол хэлээр буулгавал авиалбар хурж үг болох, үг хурж өгүүлбэр болох, өгүүлбэр бүтэх тэр цагт үг хувилгах бүтээвэр хэрэгтэй гэсэн санаа гарч байна. Үүнээс үзвэл энэтхэг төвдийн хэл шинжлэлийн аргаар монгол хэлийг судлаачид «...монгол хэлний үгсийг аймаглах биш, хэрэг дээрээ өгүүлбэрийг бүтсэн материалаар нь ангилах зарчим баримталсан болж байна (Лувсанвандан 2. 248)».

2. Ром европын хэл шинжлэлийн аргыг баримтлан монгол хэлийг судалсан бүтээлүүдэд уг хэлний үгсийг аймаглахдаа үгзүй, утгазүй, өгүүлбэрзүй гэсэн холимог зарчимд тулгуурласан байдаг. Монгол хэл шинжлэлийн хүрээнд ийм зарчмаар бичсэн бүтээлүүдэд бидний сонирхож байгаа төлөөний үгийг, үгсийн аймгийн нийт системд хамруулан өгүүлэхдээ дор дурдсан хоёр зарчмыг баримталсаар иржээ.

а) Үүний нэг дэх чиглэлийг нэрт монголч эрдэмтэн А. Бобровников өөрийн алдарт хэлзүйдээ дэвшүүлжээ. Тэрээр монгол хэлний үгсийг нэр үг, үйл үг, сул үг гэсэн гурван том аймаг болгоод бидний энд сонирхож байгаа төлөөний үгийг тооны нэр, тэмдэг нэрийн адил нэр үгийн нэгэн дэд ай болгон улмаар төлөөний үгийн бүтцийг судлахад илүү анхаарсан байна. Ингээд төлөөний үгийг утгазүйн талаас нь-биеийн төлөөний үг (би, чи, бид, та г.м.), -заах төлөөний үг (энэ тэр, эд, эдгээр, тэд, тэдгээр г.м.), -асуух төлөөний нэр (хэн, хэд, аль, ямар, юу г.м.), гэж ангилан үзсэн байна (Бобровников 4. 77—82). Монгол хэлний үгийг аймаглах талаар нэрт монголч эрдэмтний гаргасан энэ зарчим нь нэлээд хугацаанд монгол хэлний үгзүйн байгууллыг судлахад аргазүйн ач холбогдолтой байсныг энд тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал нэрт монголч эрдэмтэн Н.Поппе монгол бичгийн хэлний зүйг судалсан бүтээлдээ энэ зарчмыг баримтлан монгол хэлний үгсийг

нэр үг, үйл үг, үл хувирах үг гэж ангилсан байх бөгөөд төлөөний үгийг Бобровниковын адил нэр үгийн дэд ай болгон авч үзсэн ажээ (Поппе 5. 56—57).

Уламжлалт хэлзүйн арга буюу ром европын хэл шинжлэлийн арга монгол газар урган төлжихийн эхлэл болсон 1930-аад оны үеийн хэлзүй тухайлбал Ишдорж багшийн бичсэн «Монгол хэлний дүрэм»-д монгол хэлний үгсийг энэ зарчмаар ангилан төлөөний үгийг нэр үгийн дэд ай болгосон байна. Харин төлөөний үгээ-биеийн төлөөний нэр (би, чи, та, г.м.), -заах төлөөний нэр (хэн?, юу?, аль?, ямар? г.м.), харъяалахын төлөөний нэр (манай, миний, таны г.м.), хамаатуулагчийн төлөөний үг (хамаг, бүхэл, нийт, бүгд), -үгүйг үзүүлсэн (хэн ч, хэн боловч, юу боловч), -битүүлэг төлөөлөгч (энэхүү, мөнхүү, аливаа, аль бус) гэж ангилжээ (Ишдорж 6.44).

Эх орны хэл судлалын түүхэнд төдийгүй дэлхийн монголын судлалд ул мөрөө гүн үзүүлсэн «Лу багшийн цагаан ном»-д энэ зарчмыг баримталсан байна (Лувсанвандан 7.).

б) Дээр дурдсан ангиллаас ялгаатай хоёр дахь чиглэл нь нэрт монголч эрдэмтэн Я.Шмидтээс эхтэй байна. Энэ чиглэлийнхэн монгол хэлний үгсийг аймаглахдаа үгсийн ай тус бүрийг зэрэгцүүлэн авч үзсэн байх бөгөөд иймээс төлөөний үгийг нэр үгийн нэгэн дэд хэсэг болголгүй үгсийн аймгийн системд биеэ даасан нэгэн ай болгосон байна. Ингэж үзэгчдийн нэг Я.Шмидт өөрөө төлөөний үгийг дотор нь -биеийн төлөөний нэр (би, чи, бид, та, энэ, тэр, эд, тэд), -хамаатуулах төлөөний нэр (миний, чиний, манай, танай, бидний, минийх, чинийх), -заах төлөөний нэр (эд, тэд, эдгээр, тэдгээр, ийм, тийм, ийн, тийн) гэж гурван дэд анги болгожээ. Харин үүний дараагаар монгол хэлний хэлзүйг судалсан О.Ковелевский (8), А.Попов (9) нар тухайн үедээ төлөөний үгийн аймгийг Шмидтийн нэгэн адилаар ухааран үзэж байжээ. Энэ зарчмыг баримтлан монгол хэлний үгийг аймаглаж ирсэн хожуу үеийн эрдэмтэд төлөөний үгийн үгзүйн болон өгүүлбэрзүйн бас утгазүйн шинжийг тодруулах талаар болон төлөөний үгийн дэд хэсгүүдийг тодорхойлон гаргахад багагүй анхаарч иржээ. Тухайлбал ЗХУ-ын эрдэмтэн монголч эрдэмтэн Б.Х.Тодоева 1951 онд нийтлэгдсэн «Орчин цагийн монгол хэлний хэлзүй» гэдэг бүтээлдээ орчин цагийн монгол хэлний үгсийг арван аймаг болгоод үүний нэг нь төлөөний нэр гэж урьдын эрдэмтдийн адил үзэн төлөөний үгийг дотор нь биеийн төлөөний нэр, заах төлөөний нэр, асуух төлөөний нэр, хамаатуулах төлөөний нэр, тодорхой төлөөний үг гэж ангилаад эдгээрийн утга, үүргийг нарийн нягт тодорхойлон гаргажээ (10.

82 - 89). Зохиогч хамаатуулах төлөөний нэр нь биеийн төлөөний нэрийн харъяалахын тийн ялгалд байгаа үг шиг утга илэрхийлдэг (миний, чиний, манай, үүний, түүний, эдний, тэдний) гэж үзсэн байна. Харин тодорхой төлөөний үгэндээ бүгд, бүр, зарим (нь) гэсэн үгүүдийг багтаан тэдгээрийн өгүүлбэрт гүйцэтгэх үүргийг жишээгээр үзүүлсэн байна (10. 88—90). Мөн нэрт эрдэмтэн Г. Д. Санжеев «Буриад-монгол хэлний хэлзүй» гэдэг бүтээлдээ төлөөний үгэнд тухайлсан хэлзүйн ай байхгүй, нэр үг, тэмдэг нэр, дайвар үгийн адил ялгахуйтай байдаг гээд буриад хэлний төлөөний үгийг а) биеийн төлөөний нэр, б) заах төлөөний нэр, в) асуух төлөөний нэр, г) дайвар үгийн төлөөний нэр, д) үйлийн төлөөний нэр гэж дэд анги болгосон байна. Зохиогч энэ бүтээлдээ дайвар үгийн төлөөний нэр, үйлийн төлөөний нэр гэж ангилсан нь өмнөх судлаачдын бүтээлээс нэлээд өөр болсон бөгөөд дайвар үгийн төлөөний нэр гэдэгт ийшэ, тийшэ, яаха гэдэг үгсийг оруулсан байна.

Ихэнхдээ уламжлалт хэлзүйн энэ аргаар үгсийг аймаглаж ирсэн, их дээд сургуулийн хичээлийн хэрэглэгдэхүүнд зориулсан бүтээлүүд болон эрдэм шинжилгээний чанартай зохиолуудад «монгол хэлний төлөөний үг нь үгийн сан ба хэлзүйн өвөрмөц шинжийг хадгалсан биеэ даасан ай болно (ОЦМХ 11. 199)» гэж үзээд түүний хэлзүйн болон утгазүйн талаар нэлээд чамбай гэхдээ өмнөх үеийн эрдэмтдийн бүтээлд энэ талаар өгүүлсэн зүйлүүдийг нэгтгэн дүгнэсэн маягтай тодорхойлтуудыг гаргасан байна. Энд зарим тодорхойлолтуудыг авч үзье.

— «Юм ба түүний бэлгэ чанарыг шууд нэрлэхгүй зөвхөн төлөөлөн хэлэх ялган заах, асуун лавлах зэргийн утга илтгэх хэсэг үгсийг төлөөний үг гэнэ. ...төлөөний үгийг ангилан зүйлчлэхдээ түүний гүйцэтгэх үүрэг, өгүүлбэр зүйн шинжийг юуны өмнө анхааран үзэх нь чухал «(мөн тэнд)».

— «Хүн юм тэдгээрийн тоо хэмжээ шинж чанар, үйл байдал зэргийг шууд хэлэхгүй ялган зааж асуун лавлах зэргээр төлөөлөн хэлэгдэх үгсийг төлөөний үг гэнэ. Төлөөний үг нь нэр үг, тэмдэг нэр, тооны нэр, үйл үг зэрэг биеэ даасан аймгийн үгсийг төлөөлж чадна. ...Төлөөний үг байнга тодорхой юм шинж чанар, тоо, үйлийг зааж тодорхойлдоггүйгээрээ бусад биеэ даасан аймгийн үгээс ялгаатай бөгөөд ямар нэг тодорхой ухагдахуун илрүүлж чаддаггүй, чухам юуг зааж байгаа нь хэл ярианы тухайн нөхцөл байдлаас илэрч байдаг сөрөнхий хийсвэр шинжтэй байдаг. ...төлөөлсөн үгтэйгээ адил

үгзүйн хувиллаар хувилах учир төлөөний үгийг бүхэлд нь авч үзвэл биеэ даасан бүх үгсийн аймгийн аль алиных нь шинжтэй гэдэг (Бямбасан 12. 84)».

— «Төлөөний үг бол хүн юм үзэгдэл болон түүний шинж чанар тоо, хэмжээ, үйл байдлыг шууд нэрлэдэггүй, зөвхөн төлөөлөн хэлэх, ялган заах, төлөөлүүлэн хэлэх асуун лавлах зэргийн утга санааг илэрхийлнэ. ...Төлөөний үгийн нэг онцлог бол нэр үг, тэмдэг нэр, тооны нэр, үйл үг зэрэг үгсийн аймгийн янз бүрийн үгийг дахин давтан нуршихаас зайлсхийж тэдгээрийг төлөөлж чаддагт оршино (Балдан 13. 70)» г.м.

Харьцангуйгаар сүүлийн үед зарим эрдэмтэд үйлийн төлөөний үг байдаг гэдгийг зөвшөөрөн, түүнийг төлөөний үгийн нэгэн дэд ай болгон үзэх болсон байна. Иймээс төлөөний нэр гэдэг уламжлалт нэрийг хэрэглэхээс татгалзан «... энэ төлөөний нэр гэдгийг ажиглан үзвэл түүний бүрэлдэхүүнд ганц нэрийн зүйл ч биш мөн энд тэнд, үүгээр, түүгээр гэх мэтийн дайвар үг, ингэ-, тэг-, яа- гэх мэтийн үйл үг өөрөөр хэлбэл үгсийн айн бодит утга бүхий үгсийн бүх аймгаас багтсан байна. Ийм учир энэ айг төлөөний нэр гээд нэрийн зүйлд оруулан үздэг нь буруу бөгөөд төлөөний үг гэж нэрлэвэл арай дээр байна (Лувсандэндэв 1. 30—31)» гэсэн санал тавьж байв.

Энд иш татсан болон дээр өгүүлсэн зүйлүүдээс үзвэл үйл үгийг төлөөлсөн үйлийн төлөөний нэр монгол хэлэнд бий бөгөөд харин үүнийг үгсийн аймгийн системд яаж хамааруулах талаар эрдэмтдийн санал харилцан адилгүй байна. Тухайлбал өмнө дурдсан зүйлээс үзвэл Г. Д. Санжеев (1941), П. Бямбасан (1975), Л. Балдан (1987), А. Лувсандэндэв зэрэг эрдэмтэд үйлийн төлөөний үгийг төлөөний нэрийн аймагт хамааруулан, төлөөний үгийн нэгэн дэд хэсэг, тухайлбал биеийн төлөөний үг, заах төлөөний үг, асуух төлөөний үг зэргийн адил авч үзсэн байна. Гэтэл сүүлийн үед монгол хэлний судлалын хүрээнд гарсан бүтээлүүдэд үйл үгийг төлөөлөх үйлийн төлөөний үгийг үйл үгийн бүлэгт багтаан, гэхдээ үйл үгийн доторх нэгэн багахан дэд хэсэг гэж үзсэн байна (Чингэлтэй 14. 348). Проф. Чингэлтэй энэ саналыг түүний шавь Чойжинжав бүрэн дэмжжээ (Чойжинжав 19. 37). Бидний сонирхож байгаа, Чингэлтэй багшийн нэр томъёогоор бол төлөөний үйл үг нь бас дотроо 1. Заах төлөөний үйл үг (ингэх, тэгэх), 2. Асуух төлөөний үг (яах, ийх) гэж ангилагдах бөгөөд ийнхүү үзэгчдийн үзэж байгаагаар бол ингэж ангилд-

ийн цаад учир нь эдгээр үйлийн төлөөний үг нь үйл үгийн янз бүрийн хувиллаар харилцан адилгүй хувирч байгаатай холбоотой ажээ (Чингэлтэй, Бямбасан мөн тэнд).

Бидний бодоход тухайн ямар аймгийн үгийг төлөөлж байгаа болон, мөн ямар аймгийн үгтэй адил хувирч байгаа зэрэг дээр нь суурилан төлөөний үгийг ангилах энэ зарчмынхаа хувьд эргэн үзүүштэй байдалд хүргэж болох юм.

3. Бүтэц зүйн аргаар монгол хэлний үгсийг аймагласан эрдэмтэд «...дурдсан үгсийг (төлөөний үг Л.Б.) янз бүрийн нөхцөлтэй хэрхэн харьцах талаас нь авч үзвэл нэгдмэл биш зарим нь нэр үгтэй адил нэрийн тийн ялгалаар ялгагдаж, зарим нь үйл үгийн нөхцөлтэй харьцаж болдог байна. Энэ учраас бид дурдсан үгсийг нэгтгэж биеэ даасан үгийн нэгэн анги болголгүй би, чи, бид, энэ, тэр, хэн, юу, аль гэснийг нь харьцааны бус нэрийн ангид, ийм, тийм, өдий, төдий, энд, тэнд, хэзээ, хаана, ямар гэснийг нь харьцааны нэрийн ангид, ингэх, тэгсэн, хаачсан, хаачих гэснийг нь цагт нэрийн ангид, ингэ, тэг, яа, хаач гэснийг нь үйл үгийн ангид багтах ёстой гэж үзлээ. Өөрөөр хэлбэл үгийн анги бүр нь өөрийн нэрлэх үг, заах үг, асуух үгтэй байдаг гэж үзсэн хэрэг болно (Лувсанвандан 2. 268—269)» гэжээ.

4. Төлөөний үгийг үгсийн аймгийн системд хэрхэн ямар байр эзлүүлэн үзэж ирсэн байдалтай ийнхүү товч танилцан үзэхэд нэг хэсэг эрдэмтэд үгсийг аймаглахдаа түүний үг зүй, өгүүлбэр зүй, утга зүйг харгалзан шууд хуваан үзсэн, ингэхдээ төлөөний үгийг үгсийн аймгийн нэг биеэ даасан ай болгосон, нөгөө хэсэг эрдэмтэд ингэлгүйгээр эхлээд нэр үг, үйл үг, сул үг (зарим нь үл хувирах үг гэжээ Л.Б.) гээд нэр үгтээ цааш нь хэд хэдэн хэсэг болгон, үүнийхээ нэг нь төлөөний үг гэж үзсэн, эсвэл нэр үг, тооны нэр, тэмдэг нэр зэргийг төлөөлж чадах үгсийг төлөөний үг гээд харин үйл үгийг төлөөлөх үгсийг үйлийн төлөөний үг гээд үйл үгийн бүлэгт гэхдээ түүний дотор тусгай ай болгосон мөн төлөөний үгийг нөхцөлтэй хэрхэн харьцах байдлаар нь суурь хийж эдгээр үгс нь биеэ даасан үгсийн нэг анги болж чадахгүй гэж үзсэн зэрэг харилцан адилгүй зарчим баримталж ирсэн нь тодорхой харагдаж байна. Нийт үгсийг аймаглахдаа ерөнхийгөөс тусгай руу шатлан хуваасан, эсвэл ингэж шатлан хуваалгүйгээр эрэгцүүлэн авч үзсэн нь угтаа бол уламжлалт хэлзүйн арга гэж бидний үзэж байгаа өөрөөр хэлбэл үгсийг аймаглахдаа өгүүлбэр зүй, үг зүй, утга зүйн зарчмыг хэрэглэсэн хэрэг болно. Харин энд өөр нэг онцлон тэмдэглэвэл зохих зүйл бол эдгээр зарчмуудыг тэгш харгалзан үзсэн, эсвэл тийнхүү

тэгш харгалзан үзэлгүйгээр тухай тухайн хэсэгт нь тохируулан үзсэнд байна. Жишээлбэл үгсийг аймаглахдаа ерөнхийгөөс тусгай руу шатлан үзэхдээ эхлээд нэр үг, үйл үг, сул үг гэсэн нь гол төлөв эдгээр үгсийн үгзүйн шинж дээр нь тулгуурласан байдаг бол цаашид нэр үгээ задлан дэд хэсэг болгохдоо тэдгээрийн утга зүйн шинжийг харгалзан үзсэнтэй холбоотой. Нэр үг бол тийн ялгалаар ялгагдаж, ганц ба олон тоог үзүүлдэг, мөн хамаатуулах нөхцөл авч чаддаг, төлөөний үг мөн ийм хэлзүйн онцлогтой гээд нэр үгийн айд хамааруулсан байх жишээтэй.

5. Бид монгол хэлний үгсийг аймаглах талаар олон үеийн, олон орны монголч эрдэмтдийн хуримтлуулсан ололт дээр тулгуурлан үгсийн аймгийн системд төлөөний үг ямар байр эзлэхийг нь үгсийг аймаглах уламжлалт зарчимд тулгуурлан, гэхдээ өмнө үеийн эрдэмтдийнхээс арай өөрөөр авч үзэх боломжтой гэж үзэж байна. Хэлний нэг үзэгдэл нь нөгөөтэйгөө нягт шүтэн барилдсан байдаг учир энд бидний сонирхож байгаа асуудал маань нэг талаар монгол хэлний үгсийг ямар зарчим баримталж яаж ангилах вэ гэдэг асуудалтай нягт холбоотой нь тодорхой. Харин монгол хэлний үгсийг аймаглахдаа түүнийг зэрэгцүүлэн авч үзэлгүй, өөрөөр хэлбэл, үгсийн ай тус бүрээр нь тодорхойлон үзэлгүй, ямар нэг хэлбэрээр шатлан хуваах нь бидний үзэж байгаагаар бол нэлээд үр дүнтэй байж болох юм. Тэгвэл яаж шатлан хувааж үзэх вэ?

Бидний бодож буйгаар бол ийнхүү шатлан үзэхдээ юуны урьд тухайн үгсийн өгүүлбэрт гүйцэтгэх үүрэг, хэлзүйн утга илэрхийлдэг нөхцөлүүдтэй хэрхэн харьцах байдал, бас юмыг нэрлэн заах утга буюу утга зүйн талыг харгалзах хэрэгтэй санагдана. Ингэж үзвэл нэг хэсэг үг өгүүлбэрт биеэ даасан гишүүн болж, нэр, үйл үгийн янз бүрийн нөхцөлтэй харьцаж бас утга зүйн шинжээрээ тодорхой юм, үйлийн хөдөлгөөн, тоо хэмжээ, билэг чанар, цаг орны утга илэрхийлж чаддаг байхад нөгөө хэсэг үг нь өгүүлбэрт биеэ даасан гишүүний үүрэг гүйцэтгэж чадахгүй, нэр үйл үгийн нөхцөлүүдийг ардаа дагуулж чадахгүй, үгийн сангийн тодорхой утга илэрхийлдэггүй байна. Жишээлэхэд морь, ном, гэр гэсэн үг нь тодорхой юмыг зааж байна, сайн, цагаан, хурдан гэхэд тодорхой юмны тодорхой шинж тэмдгийг зааж байна, яв-, оч-, ир- гэхэд тодорхой үйлийг зааж байна, гурав, тав, арав гэхэд тодорхой тоог зааж байна, өглөө орой, эрт гэхэд тодорхой цаг хугацааг, урд, хойно, өмнө гэхэд тодорхой орон байрыг зааж байна гэж үзэж болох ахул адуун дотор, улаан тугийн намираан дор, энд бий гэсэн холбоо үгийн бүрэлдэхүүнд

орсон дотор, дор, бий гэсэн үгст үгийн сангийн бодит утга байхгүй, өгүүлбэрт биеэ даасан гишүүний үүрэг гүйцэтгэж чадахгүй, мөн нэр үйлийн янз бүрийн нөхцөлтэй харьцаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл дээр дурдсан эхний бүлэг үгс нь морь, морины, мориноос, номоор, сайнаар (хэлэх), цагаан нь (дээр), гэх буюу явжээ, ирэв, очлоо гэх зэргээр хувирч тодруулан хэлбэл нэр, үйл үгийн нөхцөлийг авч чаддаг байна. Мөн эдгээр үг нь өгүүлбэрийн (энгийн болон хавсарсан нийлмэл өгүүлбэр зэрэгт) бие даасан гишүүн болох нь өөр ямар ч баталгаа шаардахгүй ойлгомжтой юм.

Ийм зарчим баримтлан үзвэл монгол хэлний нийт үгийг юуны урьд бодит утгатай үг (вещественные слова), туслах үг гэж ангилан үзэж болох мэт. Харин орчин цагийн монгол утга зохиолын хэлний утга зүйн тогтолцоог бодит утгатай үг бүрдүүлж байна. Ийм үгсийн нэрлэх үүргийн талаар академич Ш. Лувсанвандан бичихдээ «...үг нь юм, үзэгдэл үйл хөдөлгөөний дохио байдаг бол нэг юм үзэгдэлд асуусан нэрлэсэн, заасан гурван зүйлийн дохио байж болно. Жишээлбэл ном, морь, сайн, хоёр, дээр, яв-, суу- гэх мэтийн үгс нь тухайн юм үзэгдэл, чанар, харьцаа, хөдөлгөөнийг шууд нэрлэсэн дохио болж, би, чи, бид, та, энэ, тэр, ийм, тийм, өдий, төдий, энд, тэнд, ингэ-, тэг- гэсэн үг нь уг юм үзэгдлийг шууд нэрлэлгүй заасан дохио болоод, хэн юу, хэд, ямар, аль-яа-, хаач- гэсэн үгс нь нэрлэж заагаагүй асуусан дохио болно (1. 268)» гэжээ. Нарийвчлан үзвэл үүнтэй нэлээд ойролцоовтор ангиллыг нэрт монголч эрдэмтэн, түрэг судлаач В.М.Наделяев өөрийн хэлзүүдээ дэвшүүлсэн байна. Тэрээр монгол хэлний үгсийг ерөнхийдөө гурав хувааж, харин үүний нэг нь бодит утгатай үг, заах үг гэж зэрэгцүүлэн хоёр ангилж үзсэн байна (Наделяев 16. 107). Энэ бол өмнөх эрдэмтдийнхээ зөвхөн ялгаатай төдийгүй, аргагүйн хувьд нэлээд ач холбогдолтой гэдгийг энд зориуд тэмдэглэн хэлмээр байна. Наделяевийн шавь доктор В.И.Рассадин тофа хэлний үгзүйг харьцуулсан бүтээлдээ багшийнхаа энэ зарчмыг авч хэрэгжүүлсэн билээ (Рассадин 17. 255). Энэ бүхэн бол бидний судалгаанд чухал чиг баримжаа болж өгч байна.

Дээр иш татсан зүйлүүд дээр тулгуурлан хүн, юм тэдгээрийн тоо хэмжээ, шинж чанар, үйл байдал, цаг хугацаа, орон байрыг шууд заан нэрлэхгүй, асуун лавлах, ялган заах зэргээр нэр үг, үйл үг, тэмдэг нэр, тооны нэр дайвар үгийг төлөөлж чадах бүлэг үгсийг бид уламжлалт хэлзүйн дагуу төлөөний үг гэж нэрлээд, тусад ангилж, цаашид хүн юм түүний тоо хэмжээ, шинж чанар, үйл байдал, орон цагийн утга

илэрхийлсэн үгийг нэрлэсэн үг (слова называния) гэж үзэв. Өөрөөр хэлбэл бодит утгатай үг нь дотроо төлөөний үг, нэрлэсэн үг гэсэн хоёр том ай болно гэж үзэж байна. Үгсийн нийт аймгийн системд энэ хоёр айн үгс нь утга зүйн шинжээрээ өөр хоорондоо ийнхүү ялгаатай боловч бусад шинжээрээ тухайлбал үг зүйн болон өгүүлбэр зүйн шинжээрээ өөр хоорондоо нягт холбоотой билээ. Энэ байдал нь төлөөний үгийн дэд хэсгүүдээс нэрлэсэн үгийн дэд хэсэг буюу бусад үгсийн аймгийн үгтэй хэрхэн харьцаж буйгаас нэлээд тодорхой харагдаж болно. Баатарыг дуудав. Хэнийг дуудав. Намайг дуудав. Зуун хонь бэлчиж байна. Хэдэн хонь бэлчиж байна? г.м. Монгол хэлзүйн бүтээлүүдэд «төлөөний үг нь төлөөлж байгаа үгтэйгээ маш нарийн уялдаа холбоотой байдаг (Төмөрцэрэн 18. 160)» гэж тэмдэглэсэн нь чухам энэ шинжийг нь онцлон үзсэнтэй холбоотой биз ээ. Өөрөөр хэлбэл нэр үгийг төлөөлсөн би, чи, эд, тэд нар, та г.м үгс нь нэр үгийн адил тийн ялгалаар ялгагдаж, хамаатуулах нөхцөл авч чаддаг бол үйл үгийг төлөөлсөн төлөөний үйл үг нь бусад үйл үгийн адил үйл үгийн нөхцөлийг авч, одоо, ирээдүй, өнгөрсөн цагийн утгыг зааж чадна. Жишээ нь хэн, хэний, хэнд, хэнээс, хэнээр, хэнтэй, хэн рүү, би, миний, надаас, намайг, надаар, надтай, надруу гэх буюу эсвэл, яах, яасан, яана (энэ үг нь ирээдүй цагийн утгаар хэрэглэгддэг нь тодорхой бөгөөд харин одоо цагийн утга илэрхийлвэл яамай* <яа+май* <муй болдог.) ингэсэн, ингэлээ, ингэнэ, тэглээ г.м. Төлөөний үгийн өгүүлбэрт гүйцэтгэх үүрэг ч бусад аймгийн үгийн адил байна. Хэн ирэв? — Бат ирэв. Хэнээс асуусан бэ? — Батаас асуусан г.м.

Төлөөний үгийн дэд ангийг тогтоохдоо уламжлалт хэлзүйн бичигт биеийн төлөөний нэр, заах төлөөний нэр, асуух төлөөний нэр гэж тодорхойлдог арай өөрөөр нэрлэсэн үгийн аймгийн ямар үгийг төлөөлж байгаагаар нь үзэж болох мэт. Тухайлбал өмнө дурдсан зүйлүүдээс үзвэл зарим монголч эрдэмтэд, зарим төлөөний үгийг ингэж ангилж байлаа. Тухайлбал нэрт монголч эрдэмтэн Г.Д. Санжеев-дайвар үгийн төлөөний нэр, үйлийн төлөөний нэр гэж үзэж байв. Энэ саналыг бага зэрэг өргөжүүлэн үзвэл, нэр үгийн аймгийн үгсийг төлөөлөх үгийг нэрийн төлөөний үг, тэмдэг нэрийг төлөөлөх үгийг нь тэмдэг нэрийн төлөөний үг, тооны нэрийг төлөөлөх үгийг нь тооны нэрийн төлөөний үг, дайвар үгийг дайвар үгийн төлөөний үг, үйл үгийг төлөөлөх үгийг үйлийн төлөөний үг гэж нэрлэж байна. Ийнхүү төлөөний үгийн доторх дэд ангиллыг толтоохдоо ямар аймгийн үгийг төлөөлж чадах, мөн

хэлзүйн хувьд үгсийн ямар аймагтай илүү ойр байгаагаар баримжаалан ангилах нь төлөөний үг, нэрлэсэн үгсийн айнуудын өөр хоорондын харьцааг илэрхийлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Жишээлбэл би, чи, та, эд, тэд нар, эн, юу, бид, та нар гэх зэрэг үгсийг нэрийн төлөөний үгийн айд, хэд, хичнээн зэргийг тооны нэрийн төлөөний үгийн айд, аль, ямар зэрэг үгийг тэмдэг нэрийн төлөөний үгийн айд, хэвч, хаана зэрэг үгийг дайвар үгийн төлөөний нэрийн айд, ингэх, тэгэх, яах зэрэг үгийг үйлийн төлөөний нэрийн айд багтааж байна.

Уламжлалт хэлзүйн бүтээлүүдэд асуух төлөөний үг байдаг гэж үзэн хэн, юу, аль зэрэг, ямар, хэр зэрэг, хэд хичнээн, хаа, хэзээ, хэдийд, зэрэг үгийг үүнд хамааруулан үзэж ирсэн бөгөөд эдгээр үгийг анхааралтай үзвэл төлөөний нэрийн дотор нэгэн бүлэг болохгүй, харин хэн, юу гэдэг нь нэрийн төлөөний үгийн асуусан дохио, ямар, хэр зэрэг гэдэг нь тэмдэг нэрийн төлөөний үгийн асуусан дохио, хэд, хичнээн гэдэг нь тооны нэрийн төлөөний үгийн асуусан дохио, хэзээ, хаана гэдэг нь дайвар үгийн төлөөний нэрийн асуусан дохио, яах гэдэг нь үйл үгийн төлөөний үгийн асуусан дохио тус тус болно гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл төлөөний үгийн дэд хэсэг бүр асуусан, төлөөлсөн буюу заасан ийм хоёр эсрэг зүйлийн нэгдэл байна гэж бодож байна. Үүнийг төлөөний үгийн тодорхой дэд хэсэг бүр дээр үзвэл хэн, юу гэдэг нь нэрийн төлөөний үгийн асуусан дохио, би, чи, бид, тэд, эд нар гэх зэрэг үг нь төлөөлсөн буюу эсвэл заасан дохио, тэмдэг нэрийн төлөөний үгийн асуусан дохио нь ямар, хэр зэрэг, ийм тийм гэдэг нь заасан буюу эсвэл төлөөлсөн дохио нь, хэзээ, хаана гэдэг нь дайвар үгийн асуусан дохио нь, энд, тэнд, түрүү, хожид зэрэг нь төлөөлсөн дохио нь, яах гэдэг нь үйлийн төлөөний нэрийн асуусан дохио, ингэж, тэгэж гэдэг нь төлөөлсөн дохио нь болно гэсэн хэрэг юм.

НОМ ЗҮЙ

1. Лувсандэндэв 1956 — А. Лувсандэндэв. Монгол хэлний үгсийн аймгийг ангилах тухай асуудалд. «Монгол хэл бичгийн зарим асуудлууд» УБ
2. Лувсанвандан 1981 — Ш. Лувсанвандан. Монгол хэлний үгсийг ангилах тухай асуудалд. Монгол хэл шинжлэлийн асуудлууд. УБ.
3. Балданжапов 1962 — П. Б. Балданжапов. Монгольские грамматические сочинение. XVIII века. Улан-Удэ.
4. Бобровников 1849 — А. Бобровников. Грамматика монгольско-калмыцкого языка. Казань
5. Поппе 1937 — Н. Поппе. Грамматика письменно-монгольского языка.

6. **Ишдорж** 1930 — Ишдорж. Монгол хэлний дүрэм. (хуучин үсгээр) УБ.
7. **Лувсанвандан** 1939 — Ш. Лувсанвандан. Монгол хэлний зүй. (хуучин үсгээр) УБ
8. **Ковелевский** 1835 — О. Ковелевский. Краткая грамматика монгольско-го книжного языка. Казань
9. **Попов** 1848 — А. Попов. Калмыцкая грамматика. Казань
10. **Тодоева** 1951 — Б. Х. Тодоева. Грамматика современного монгольского языка. Фонетика и морфология. М
11. **ОЦМХ**. 1966 — Орчин цагийн монгол хэл зүй. УБ.
12. **Бямбасан** 1975 — П. Бямбасан. Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг. УБ
13. **Балдан** 1987 — Л. Балдан. Тэмдэг нэр «Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал, тэргүүн дэвтэр. УБ
14. **Чингэлтэй** 1980 — Чингэлтэй. Одоо үеийн монгол хэлний зүй. (хуучин үсгээр) Хөх хот
15. **Санжеев** 1941 — Г. Д. Санжеев. Грамматика бурят-монгольского языка. М-Л
16. **Наделяев** 1988 — В. М. Наделяев. Современный монгольский язык. (морфология) Новосибирск
17. **Рассадин** 1978 — В. И. Рассадин. Морфология тофаларского языка в сравнительном освещении, М
18. **Төмөрцэрэн** 1962 — Ж. Төмөрцэрэн. Монгол хэлний зарим төлөөний үгийн тухай. Монголын судлал, боть IV, дэвтэр 1—7, УБ
19. **Чойжинжав** 1985 — Чойжинжав. Монгол хэлний үгсийн аймаг, Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл» (хуучин үсгээр) № 2. Хөх хот

(Акад. Ш. ЛУВСАНВАНДАНГИЙН «Орчин цагийн монгол хэлний бүтэц» (1968) бүтээл хэвлэгдсэний 20 жилийн ойд)

Д. Цэрэнпил

МОНГОЛ ХЭЛНИЙ ЗАЛГАВАР БҮТЭЭВРИЙН ЕРӨНХИЙ АНГИЛЛЫН АСУУДАЛД

1. Ф. де. Соссюрийн (1857—1913) үеэс ерөнхий хэл шинжлэлийн онолд тодорхой зааглан ялгах болсон **хэл, хэлэхүй** гэсэн хоёр ойлголтыг монгол хэл шинжлэлд анх академич Ш. Лувсанвандан ул суурьтай гарган тавьсан билээ. Хэлийг хүний харилцааны хэрэглүүр болох үндсэн үүргийнх нь талаас авч үзвэл түүний хамгийн гол нэгж нь өгүүлбэр юм. Өгүүлбэрийг хэлний болон хэлэхүйн төвшинд зарчмын ялгаатай авч үзэх нь онол-аргазүйн чухал ач холбогдолтой. Энэ нь нэг талаас өгүүлбэр ямар бүтэц, тогтолцоотой болохыг танин мэдэх, нөгөө талаас энэхүү тогтолцоот бүтэц бүхий цогц хүмүүсийн харилцааны хэрэглээнд орохдоо хэрхэн үйлчилдгийг илрүүлэн гаргах биеэ даасан тусгай хоёр зорилгоос шууд урган гардаг билээ.

Хэл, хэлэхүй хоёрын салшгүй нягт холбоо нь тэдгээрийн төгс нийлмэл дохио болох **үглэбэр, өгүүлбэр**¹ хоёрын харилцан нөхцөлдсөн шинж дээр тулгуурладаг. Хэлний гаргалгын талыг илэрхийлэх үглэбэр нь харилцааны хэрэглээнд орж мэдэгдэл болохдоо гаргалгын бод бие болох авианы бүрхүүлийн хувьд (дуудлага, аялгуу) хувирах төдийгүй, мөн гаргалгын хэлбэрийн талаар (хэлний хэмнэлийн зарчмын үзэгдлүүд) зохих өөрчлөлтөд өртдөг байна. Улмаар хүмүүс уг мэдэгдлийг бие биедээ дамжуулахдаа заавал тодорхой зорилгын үүднээс ханддаг бөгөөд энэ зорилгоо ихэвчлэн хамт илэрхийлж байдаг. Ийнхүү, өгүүлэгчээс мэдэгдэлд хандах харьцааг «хандал» гэж нэрлэвэл хэлэхүйн нэгж болох өгүүлбэр нь **мэдэгдэл, хандал** гэсэн хоёр үндсэн хэсгээс бүтдэг гэж хэлж болно. Монгол хэл шинжлэлийн бүтээлүүдэд «сул үг» гэж нэрлэсээр ирсэн бүлэг бүтээврийг бид эл хандал бүтэвэр гэсэн ойлголтод хамруулан нөхцөл бүтээврээс ялган авч үзэж байна.

Хандал, нөхцөл хоёрын үндсэн ялгаа нь:

1. Нөхцөл бүтээвэр нь үглэбэрийн доторх хоёр үгийн хоорондын харьцааг заадаг (1.16—19) хэлний нэгж бол хандал бүтээвэр нь өгүүлэгчээс мэдэгдэлд хандах харьцааг заадаг хэлэхүйн нэгж болно.

2. Нөхцөл нь үглэбэрзүйн утга илтгэж хэлний хэлзүйн байгууллыг тодорхойлох үндсэн хүчин зүйл болдог бол хандал нь баймж утгыг илтгэж хэлэхүйн хэм хэмжээг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг.

3. Нөхцөл нь хоёр бүрэлдүүлэгчийн шүтэн барилдсан хоёр эсрэг чиглэлт харьцааг илэрхийлдэг бол хандал нь зөвхөн нэг чиглэлт харьцааг илэрхийлдэг.

4. Орчин цагийн монгол хэлний зөв бичих зүйд нөхцөлийг нөхцөлдүүлж буй үгтэй нь залган бичдэг бол хандлыг хандаж буй үгээс нь тусгай бичдэг дүрэмтэй.

Монгол хэлний хандал бүтээвэрт **ч, л, шүү, даа** (доо, дээ, дөө), **бэ** (вэ), **уу** (үү) **биз, юу** (юү), **шив** зэрэг бүтээвэр багтана. Акад Ш. Лувсанвандан эл бүлэг бүтээврийг сул үг гэж нэрлэн үгийн аймагт оруулах нь зарчмын хувьд буруу болохыг зөв зүйтэй шүүмжлээд (1.33, 84, 90—91) «монгол хэлний үглэбэрийн доторх нэг үг нь нөгөөтэйгөө хэрхэн харьцахыг заах дохио болох нөхцөлийн зүйлийг юуны өмнө үгэнд холбогдох, үглэбэрт холбогдохын аль нь болох дээр үндэслэж үгийн нөхцөл, үглэбэрийн нөхцөл гэж ангилж болно» (1.33) гэж үзэн дээрх бүлэг бүтээврийг үглэбэрийн нөхцөл гэж нэрлэсэн билээ. Гэтэл эдгээр бүтээвэр нэг үглэбэр нөгөөтэйгөө хэрхэн харьцахыг заахгүй, харин өгүүлэгч этгээд үглэбэрээр илэрч буй мэдэгдэл буюу түүний аль нэг гишүүнд хэрхэн хандахыг заасан тул асуух, онцлох, барагцаалах нөхцөл гэлгүй, харин асуух, онцлох, барагцаалах хандал гэж нэрлээд залгавар бүтээврийн ангиллын гадна авч үзүүштэй санагдана.

Үүнд, нэг зүйлийг ташрамд тэмдэглэхэд, монгол хэлийг тогтолцоот бүтэц бүхий цогц болохынх нь талаас судлахад мөн чанараараа харьцааны (хэрэглээнд ороогүй) цэвэр хийсвэр бүтэц болох үглэбэрийг түүний хэрэглээндэх материаллаг илрэл болсон мэдэгдлийн бүтцээс цуваа цагийн харьцаанд тодорхой зааглан салгах явдал чухал ач холбогдолтой байна. Энэ бол уг хоёр ойлголтын арга билгээр шүтэн барилдсан диалектик уялдаа холбоог ямар нэг хэлбэрээр үгүйсгэнэ гэсэн үг огт биш юм. Хэлний тогтолцоот мөн чанар үглэбэрээр дамжин мэдэгдэлд тусгалаа олж, ингэснээрээ хэлэхүйн

үйл ажиллагааны үндэс болж түүнийг харьцангуй удаан хугацааны турш бат найдвартай **тогтоон барьж** байдаг бол хэлний хөгжлийн тодорхой хугацааны туршид хэлэхүйд хэвшин тогтсон үзэгдэл мэдэгдлээр дамжин үглэбэрт тусгалаа олж, ингэснээрээ хэлний тогтолцоот мөн чанарт нөлөөлөн түүнийг алгуур аажмаар **хувьсган өөрчилж** байдаг. Энэ хувьсал өөрчлөлт хэлний дотоод зүй тогтол, хэл шинжлэлийн бус хүчин зүйлийн нөлөөгөөр явагдахдаа хэлний зөвхөн гаргалгын талаар дамжин илэрдэг. Өөрөөр хэлбэл, хэлний агуулгын талаар тодорхойлогддог түүний тогтолцоо нь хэлэхүйгээс ангид өөрөө аяндаа хувьсан өөрчлөгддөггүй гэж ойлгож байна. Чухам үүнд л хэлний хувьсах, үл хувьсах хөгжлийн диалектик орших бөгөөд эдгээрийг бие биенээс нь зөв зүйтэй ялган салгаж тайлбарлах явдал хэл шинжээчийн хамгийн гол зорилгын нэг билээ.

2. Залгамал хэлний хэв шинжит төлөөлөгч болох монгол хэлний бүтцийг судлахад залгавар бүтээврийн мөн чанарыг ерөнхий тогтолцоонд нь нээн гаргах явдал чухал ач холбогдолтой юм. Үүнд юуны өмнө залгавар бүтээврийн анхдагч ангиллын асуудлыг авч үзэх ёстой.

Монгол хэл шинжлэлийн бүтээлүүдэд монгол хэлний залгавар бүтээврийг юуны өмнө хамгийн ерөнхий шинжээр нь дагавар, нөхцөл гэсэн хоёр үндсэн ангид хуваан үздэг билээ. Гэвч зарим тодорхой бүлэг бүтээврүүдийг чухам аль ангид хамруулан авч үзэх талаар судлаачдын дунд өнөө хэр санал зөрөлдөөн гарсаар байна. Судлаач П. Бямбасан энэ тухай тоймлон дурдаад (2.168—170) «Монгол хэл судлаачдын дотор монгол хэлний залгавар бүтээврийг ангилах талаар ийм ноцтой зөрөө байгаа нь монгол хэлний чухал чухал асуудлыг шийдвэрлэхэд саад болж байгаагаар барахгүй, ерөнхий боловсролын сургуулиудын хэл бичгийн хичээлийн программ, сурах бичиг зохиогчдыг ихээхэн будлиулж, монгол хэлний багш нар ч сурагчдад заахад түвэгтэй болж байна» гэж уг асуудлын эрдэм шинжилгээний болон практик учир холбогдлыг тодорхойлон бичсэн байна.

Монгол хэлний залгавар бүтээврийн ерөнхий ангиллын талаарх судлаачдын саналыг хоёр үндсэн хэсэгт хувааж болно. Үүнд:

1. Акад. Ш. Лувсанвандан нийт залгавар бүтээврийг дагавар, нөхцөл гэсэн ерөнхий хоёр ангид хуваахдаа дагавар нь юм, үзэгдлийн дохио, нөхцөл нь тэдгээрийн хоорондын янз бүрийн харьцааны дохио гэсэн үзэл онолыг баримтлан хэлзүйн утга илэрхийлдэг боловч ямар нэг харьцааны дохио

болж үл чадах нэр үгийн олон тоо, үйл үгийн хэв, байдлын бүлэг бүтээврүүдийг үглэбэрзүйн харьцаанд орох чадамжтай биеэ даасан нэгж (үүнийг «үг» гэж нэрлэсэн) үүсгэх шинжийг нь гол шалгуур болгон дагаврын ангид оруулсан байна.²

2. Дээрх бүтээл гарахаас өмнөх үеийн монгол хэлний хэлзүйн бичиг, хэл шинжлэлийн бүтээлүүдэд залгавар бүтээврийг хоёр ерөнхий ангид хуваахдаа тэдгээр нь хэлний тогтолцооны үндсэн хэсэг болох үгийн сан хэлзүйн байгуулал хоёрыг тодорхойлох гол хүчин зүйл гэж үзээд үгийн сангийн буюу хэлзүйн утгын алиныг үүсгэж байгааг гол шалгуур болгон ангилж байсан тул харьцааны утга илтгэдэггүй боловч хэлзүйн утга илэрхийлдэг дээрх бүлэг бүтээврүүдийг зүй ёсоор нөхцөлийн ангид хамруулан үзсэн байдаг. Акад. Ш. Лувсанвандан ч түрүү үеийнхээ бүтээлүүдэд ингэж үзэж байсан.

Энэхүү зарчмын ялгаатай хоёр бүлэг санал нь угтаа аргагүйн хоёр өөр байр сууринаас уг асуудлыг авч үзсэнтэй холбоотой боловч дээрх санал зөрөлдөөн нь зарим нэр томьёо, ухагдахууныг (дагавар, нөхцөл, хэлзүйн болон харьцааны утга, хэлний агуулгын болон гаргалгын тал, хэлний тогтолцоо хийгээд хэлний бүтэц зэрэг) хоёрдмол утгатай, нарийн зааг ялгаагүй хутган хэрэглэснээс гол төлөв үүдэн гарсан мэт санагдана. Энэ мэт санал зөрөлдөөнтэй асуудлын мөн чанарыг тайлбарлахын тулд монгол хэл шинжлэлийн өнөөгийн төвшинд хэрэглэж буй зарим нэр томьёог нарийвчлан ялган салгаж тодотгох, тэдгээрээр илрэх хэл шинжлэлийн нарийн ойлголт, ухагдахуунуудыг бие биеэс нь тодорхой зааглан нэгэн утгатай тодорхойлох шаардлага гарсаар байна.

Акад. Ш. Лувсанвандангийн бүтэц хэл шинжлэлийн зарчимд тулгуурласан ангилал монгол хэлний залгавар бүтээврийн ерөнхий мөн чанарыг хамгийн үнэн зөв нээн гаргасан гэдгийг монгол хэл шинжлэлд тухайн үед нь нэгэнт хүлээн зөвшөөрсөн билээ. Гэтэл түүний үзэл баримтлалын мөн чанар, зарим ойлголт ухагдахууны утгыг өнгөц ойлгон тайлбарлах явдал судлаачдын дунд, түүний дотор уг үзэл онолыг хүлээн зөвшөөрөгчдийн дунд байсаар байгаа нь академичийн ангиллыг эрдэм шинжилгээний болон практик хэрэглээнд тууштай нэвтрүүлж, нэгэн мөр болгон дагаж мөрдөхөд саад бэрхшээл учруулсаар байна. Тухайлбал, П. Бямбасан дээрх өгүүлэлдээ: «Бид хэлийг дохио тэмдгийн систем гэдгийг баримталж монгол хэлний шинжлэлд акад. Ш. Лувсанвандангийн анх гаргаж ирсэн морфем бол хэлний энгийн дохио учраас морфемийн нэг хэсэг нь юм үзэгдлийн дохио, нөгөө хэсэг нь тэдгээр юм үзэгдлийн хоорондын янз бүрийн харьцаа-

ны дохио гэсэн үзлийг монгол хэлний морфемийн үндсэн шинжийг илрүүлж, түүнд нь тохируулан ангилах хамгийн тохиромжтой шалгуур болно гэж үзэж байна. Юм үзэгдэл, тэдгээрийн хоорондын харьцааны дохионы тэмдэг болох морфемийг юм үзэгдлийн дохио, харьцааны дохио хоёрын аль нь болохыг ялган ангилах хуваарь үнэн бодитой ангилал болох бөгөөд хамгийн эхний ерөнхий хуваарь болно (2.177)» гэж академичийн зарчмыг бүрэн хүлээн зөвшөөрсөн боловч хэрэг дээрээ хуучин уламжлалт ангиллыг баримтлах нь зүйтэй гэж үзжээ. Үүнтэй холбогдуулан академичийн үзэл баримтлалын зарим ойлголт, ухагдахуун, хэрэглэсэн нэр томьёоны учир утгыг сайтар ухан ойлгох, зөв зүйтэй тайлбарлах явдал өнөө хэр чухал хэвээрээ байна гэж үзэж байна.

Акад. Ш. Лувсанвандан монгол хэлний үглэбэрийг бүрдүүлэгчийнх нь талаас уг, нөхцөл гэсэн хоёр үндсэн хэсэгт хувилахдаа үглэбэр дэх үгсийн хоорондын харьцаа заах залгавар бүтээврийг нөхцөл гэж үзээд хэдийгээр хэлзүйн хувьд үгийг хувилгадаг боловч үглэбэрт уг үгийг өөр үгтэй холбоогүй залгавар бүтээврийг бусад үг үүсгэх бүтээврийн хамт дагавар гэж үзсэн билээ. Тэгвэл дагаврыг тодорхойлох гол шалгуур нь үгийн сангийн шинэ нэгж үүсгэх явдал бус, харин нөхцөлөөр өөр үгтэй нөхцөлдөх чадамж бүхий үндэс үүсгэх явдал юм. Тэрээр «нөхцөл нь бодит ертөнцийн олон юм үзэгдлийн хоорондын янз бүрийн харьцааг илтгэх дохио юм (1.16)» гэж тодорхойлоод үүнийгээ тодотгон «юм үзэгдэл нь үгээр илэрдэг (1.16)», «нөхцөл нь ямагт хоёр үгийн хоорондын харьцааг заадаг (1.17)», «Бодит ертөнцийн олон юм үзэгдэл нь харилцан шүтэн барилдсан байдаг бол үглэбэрийн доторх үгс нь мөн харилцан холбогдсон байдаг. Үглэбэрийн доторх үгсийн хоорондын харьцаа нь гол төлөв³ нөхцөлөөр илэрнэ (1.18—19)» гэхчлэн бичсэн байдаг. Үүнээс үзвэл нөхцөлийг тодорхойлох гол шалгуур нь хэлзүйн аливаа утга илэрхийлэх явдал бус, харин ямар нэг харьцаа заах явдал юм.

Гэтэл судлаачдын дунд «хэлзүйн утга», «хэлзүйн харьцаа» гэсэн ухагдахууныг адилтган хэрэглэдэг нь академичийн хэрэглэсэн «харьцаа» гэсэн ухагдахууныг хоёрдмол утгатай ойлгоход хүргэсэн бололтой. «Харьцаа» гэдэг үгийн утгыг монгол хэлний тайлбар толь: «өөр, өөр хэмжигдэхүүн, юм, үйл явдлыг жишсэн жишиг» гэж тодорхойлсноос ч үзсэн энэ ухагдахуун нь уг хам бүтэцдээ наад зах нь хоёр бүрдүүлэгчийг шаардах нь илэрхий. «Үглэбэрзүйн харьцаа» гэж байх бөгөөд «үгзүйн харьцаа» гэж байхгүй тул «хэлзүйн харьцаа» гэсэн нэр томьёо оновчгүйгээр барахгүй будлианы эх үүсвэр

болж байна. Үүнээс үүдэн «юм, үзэгдлийн дохио болох морфем үгийн сангийн утга илрүүлж, **харьцааны дохио болох морфем хэлзүйн утга илрүүлж** агуулгаараа ялгарна... Нөхцөл нь юм үзэгдлийн дохио болох үгийн сангийн салангид нэгж (үгсийг) -үүдийг өөр хооронд нь холбон хэлхэж зохион байгуулах, үгийн сангийн нэгжүүдийг тэдгээрээр тэмдэглэж байгаа юмс үзэгдлийн оршин байх зайлшгүй нөхцөл болсон орон, цаг, тоо эзэн бие зэрэг бусад олон төрлийн харьцаанд (?-Д.Ц) нөхцөлдүүлж хэлзүйн байгууллыг бүрдүүлдэг» (2.178) гэсэн ойлголт өнөө ч монгол хэл шинжлэлд нийтлэг байна.

Аливаа олонлогийн нэгэн адил монгол хэлний залгавар бүтээврийг янз бүрийн зорилгоор, өөр өөр шалгуураар ангилж болох нь мэдээж. Түүний дотроос хэлний бүтцийг гаргалгынх нь талаас, хэлний тогтолцоог агуулгынх нь талаас авч үзэж залгавар бүтээврийг ангилах нь хэлний тогтолцоот бүтцийн мөн чанарыг нээн гаргах хоёр үндсэн ангилал болно. Гэвч тэдгээрийг тодорхой зааглан ялгахгүй хольж хутгах нь буруу бөгөөд хэлний бүтцийн илрэх хэлбэр болох үглэбэрийг юм үзэгдлийн дохио, тэдгээрийн хоорондын харьцааны дохио гэж хуваан, хэлний тогтолцоог үгийн сан, хэлзүйн байгуулал гэж хуваан эдгээр ухагдахууны нэгжийг залгавар бүтээврийн хүрээнд бие биеэс нь зааглан ялгаж тодорхой нэр томъёогоор тэмдэглэн хэлэлцэх нь зүйтэй байна. Акад. Ш. Лувсанвандан монгол хэлний бүтцийн үндсэн бүрэлдүүлэгчийг үүсгэх нэгжийг дагавар, нөхцөл гэж нэрлэсэн билээ. Харин монгол хэл шинжлэлд монгол хэлний тогтолцооны үндсэн бүрэлдүүлэгчийг үүсгэх нэгжийг өнөө хүртэл тусад нь авч тусгай нэр томъёогоор тэмдэглээгүй байна. Бид энд акад. Ш. Лувсанвандангийн хэрэглэсэн нэр томъёоны төсөөр үгийн сангийн тогтолцооны нэгжийг «үүсгэвэр», хэлзүйн байгууллын нэгжийг «хувилал» гэж нэрлэх санал оруулж байна. Эдгээр ухагдахууныг илүү оновчтой нэр томъёогоор тэмдэглэхийг үгүйсгэхгүй, харин дагавар, нөхцөл гэж давхцуулахгүй, тусгайлан тэмдэглэх шаардлага зайлшгүй юм.

Тэгвэл дагавар, нөхцөл гэдэг нь хэлний гаргалгын талын ойлголт бөгөөд үүсгэвэр, хувилал гэдэг нь хэлний агуулгын талын ойлголт болно. Хэлний агуулгын тал нь бодит ертөнцийн тусгал тул түүнийг мэдлэгийн олон салбар судалдаг бол түүний гаргалгын талыг зөвхөн хэл шинжлэл судалдаг. Энэ утгаараа акад. Ш. Лувсанвандангийн үзэл онол монгол хэлийг судлах гол зарчим, чиглэлийг тодорхойлж байна. Үүнийг

товхон хүлээн зөвшөөрөх төдийгүй хэл судлалын эрдэм шинжилгээний болон практик хэрэглээнд тууштай нэвтрүүлэх хэрэгтэй юм.

3. Монгол хэлний залгавар бүтээврийн ерөнхий ангиллын орчмын тухай ярихад бидний өмнө авч үзсэн шалгуурын үүднээс бүх залгавар бүтээврийг дагавар, нөхцөл хоёрын аль нэгэнд заавал хамааруулах ёстой юу?, мөн чанараараа энэ хоёр ангийн алинд нь ч орохгүй тийм залгавар бүтээвэр байж болох уу? гэсэн асуулт гарна. Бид энэ тухай авч үзэхдээ судлаач П. Бямбасангийн «Морфемийг ангилахдаа ганц нэг гол бус шинжийг нь товойлгон, түүгээрээ зонхилох шинжүүдийг нь бүрхэгдүүлэх, завсрын үзэгдэлд тооцон бөөрөнхийлөх нь хэлний зүй тогтлыг нээн олоход ужиг саад болсоор байна» (2. 178) гэж бичсэнтэй бүрэн санал нийлэхийн хамт мөн үнэхээр завсрын шинжтэй, гуйвалтгүй хатуу баримтлах ёстой шалгуурынхаа үүднээс алинд нь ч оруулж болшгүй тийм мөн чанартай бүтээврийг заавал аль нэгэнд нь албадан оруулах нь уг шалгуурынхаа утгыг хоёрдмол болгон бүрхэгдүүлэх, цаашилбал энэ ангилалдаа захирагдан хэлний зүй тогтолт үзэгдлийг албадлагаар буруу тайлбарлахад хүргэж болох юм гэдгийг нэмэн хэлмээр санагдана.

Орчин цагийн монгол хэлэнд арав орчим өөр байрлалд тохиолддог бөгөөд зөв бичих зүйд -Х, -ХЬ, -ХИ гэсэн гурван хэлбэрээр хэрэглэгдэж буй монгол хэлний нэгэн зүйл «-ХИ» бүтээвэр хоёр үндсэн шинжээрээ бусад залгавар бүтээврээс өөрмөц юм. Үүнд:

1. Залгавар бүтээврийн ерөнхий системд нэгэн утгатай тодорхойлж болдоггүй. Өөрөөр хэлбэл, хэлний тогтолцоонд үгийн сан, хэлзүйн байгууллын аль алинд холбогдож дагавар, нөхцөл хоёрын аль алины шинжийг заримдаг хэлбэрээр хадгалсан байдаг. Тухайлбал:

- Харьяалахын тийн ялгалаар хэлбэржсэн эрхшээлт нэрд залгаж, орон гэр гэсэн утга үүсгэнэ. Жишээ нь: ахынхи (нүүв), минийхи (зусланд гарсан) г.м. Мөн -Хи бүтээврийн олон тооны хувилбар хүмүүсийн олонлиг гэсэн утгатай үгийн сангийн нэгж үүсгэнэ. Жишээ: Нийслэлийнхэн, өрөөнийхөн г.м.

Нэрийн харьяалахаас бусад бүх тийн ялгалаар хувилах үндэс үүсгэж үгзүйн утга илтгэнэ. Жишээ: минийх, минийхийг, минийхээс, минийхээр, минийхтэй, минийхэд, минийх рүү г.м.

Харьцааны нэрийг нэр үгтэй холбох үглэбэрзүйн үүрэг гүйцэтгэнэ. Жишээ: хөдөөхи мал, урдхи гол г.м.

2. Залгавар бүтээврийн байрлалын ерөнхий хуульд захирагдаггүй - ХИ бүтээвэр нь ардаа нэрийн тийн ялгалын болон хамаатуулах нөхцөл авдаг төдийгүй өөрөө хэд хэдэн тийн ялгалын нөхцөлийн дараа орж үгийн хэлбэрийг төгсгөдөг. Иймээс ч акад. Ш. Лувсанвандан - ХИ бүтээврийг дагаврын ангид оруулсан боловч «давхар тийн ялгал» буюу «нөхцөл + нөхцөл» гэсэн байрлалын тухай ярихдаа (1. 175—185) түүнийг гол байр эзлүүлэн авч үзсэн. Гэхдээ - ХИ бүтээврийн өмнөх нөхцөл харьцааныхаа утгыг тэр бүр алддаггүй. Жишээ:

ахын ном ————— энэ ном ахынхи

гарт атга- ————— гартхи үзэг

урдуур урс- ————— урдуурхи гол

хүртэл ажилла- ————— хүртэлх хугацаа г. м.

— ХИ бүтээвэр энэ мэт ноцтой шинжээрээ залгавар бүтээврийн системд онцгой ялгардаг тул түүний хэлний тогтолцоон дахь мөн чанар, хэлзүйн үүрэг, хувьсал хөгжлийг нарийвчлан тогтоох явдал монгол хэлний бүтцийн олон чухал асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай юм.

Энэ талаар бид тусгай өгүүлэл бичиж буй тул энд зөвхөн - ХИ бүтээврийн хэлний тогтолцоонд гүйцэтгэх үндсэн үүргийн талаар товч саналаа хэлье.

Монгол хэлний нөхцөл нь үглэбэрдэх хоёр үгийн хоорондын харьцааг илэрхийлэхдээ өмнөх үндсээ үглэгдэхүүнд холбож байна уу, эсвэл өөр үгэнд холбож байна уу гэдгээр нь хамаатуулах нөхцөл, захируулах нөхцөл гэж хоёр хувааж болно. Захируулах нөхцөл нь ямагт синтагмыг үүсгэдэг бөгөөд синтагмыг тодотгуулагч харьцаанд байгаа үг нь нэр, үйлийн алин болох дээр үндэслэн нэрийн синтагма, үйлийн синтагма гэж хуваадаг.

Монгол хэлний нэрийн синтагмын харьцааг (өөрөөр хэлбэл, хоёр нэрийн хоорондын харьцааг) зөвхөн харьяалахын тийн ялгалын нөхцөл илэрхийлдэг. Гэтэл энэ бол монгол хэлэнд илэрдэг, бодит ертөнцийн тоо томшгүй үзэгдэл, тэдгээрийн хөдөлгөөний хоорондын харьцааг заах 20 орчим бүлэг бүтээврийн (нэрийн болон үйлийн тийн ялгалын) зөвхөн нэг нь юм. Бусад нь бүгдээрээ үйлийн синтагмын харьцааг илэрхийлдэг. Монгол хэлэнд аливаа ухагдахууныг үйлийн синтагмаар илэрхийлэх хандлага зонхилдог хийгээд харьяалахын тийн ялгал хэт ачаалалтай байдаг зэрэг нь үүгээр тайлбарлагдана.

Ийнхүү монгол хэлний системд үйлийн синтагмын баялаг олон харьцааг нэрийн синтагмын харьцаа болгон өөрчлөх хэлзүйн хэрэглүүрийн шаардлага хэмнэлийн зарчимд тулгуурла-

сан хэлний илэрхийлэх чадвартай шууд холбоотой гарч ирсэн байна. Чухам энэ шаардлага - XII бүтээврийн хэлзүйн утгыг нөхцөлдүүлсэн ажээ.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. Акад. Ш. Лувсанвандан монгол хэлний бүтцийг судлахдаа «үглэбэр» гэсэн нэр томъёог хэрэглэж түүнийхээ утгыг цуваа цагийн үүднээс тайлбарласан байдаг (1. 10—11). Харин бид хам цагийн харьцаанд «үг-үгнэ», «өгүүл-» гэсэн үгийн сангийн хоёр өөр нэгжээс үүссэн «үглэбэр», «өгүүлбэр» гэсэн үгсийг утгын хувьд эсрэгцүүлэн хэлний төгс нийлмэл дөхнөг хэлний төвшинд «үглэбэр», хэлэхүйн төвшинд «өгүүлбэр» хэмээн тэмдэглэн хэлэлцэж байна. Үүний төсөөр «үглэгдэхүүн», «үглэхүүн» гэсэн нэр томъёог хэлний төвшинд, «өгүүлэгдэхүүн», «өгүүлэхүүн» гэснийг хэлэхүйн төвшинд хэрэглэж болох юм.

2. Акад. Ш. Лувсанвандан үйлт нэр үүсгэх бүлэг бүтээврийг мөн дагаврын ангид оруулсан. Гэвч энэ нь түүний энэ үзэл баримтлалд огт хамаарахгүй зүйл юм. Учир нь тэдгээрийг «цагт нэр» үүсгэх бүтээвэр гээд хэлзүйн үзэгдлийн гадна авч үзсэн билээ.

3. Акад. Ш. Лувсанвандан нөхцөл нь ямагт хоёр үгийн хоорондын харьцааг заадаг гэж үзсэн боловч ямар ч хоёр үг заавал нөхцөлөөр холбогдох албагүй гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, юмс үзэгдэл, үйл хөдлөлийн тэмдгийг заасан аймаг үгс нөхцөлгүйгээр «үндэс хэлбэрээрээ» уг үгтэй-гээ холбогдоно гэж үзсэн тул энд эс оруулан тооцсон байна. Харин үндэс хэлбэрээрээ биш, тэг нөхцөлөөр холбогдоно гэж үзвэл энэ «гол төлөв» гэсэн нэмэлт огт шаардлагагүй билээ.

НОМ ЗҮЙ

1. Ш. Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний бүтэц. УБ. 1968.

2. Н. Бямбасан. Монгол хэлний залгавар морфемийн ангиллын асуудалд. Монголын судлал. 1977. боть V (13). 171—181.

Г. Ц. Пюрбеев

ТИПЫ СЛОВСОЧЕТАНИЙ С ПОВТОРОМ ДЕЕПРИЧАСТНЫХ ФОРМ В МОНГОЛЬСКИХ ЯЗЫКАХ

В монгольском языкознании существует значительная литература по проблемам синтаксиса словосочетания (1). Тем не менее продолжение дальнейших разработок в этой области грамматики остается одной из актуальных задач монголоведов. Особенно важным представляется изучение словосочетаний в историко-типологическом аспекте, что позволяет с наибольшей полнотой обнаружить структурно-функциональные различия и национально-специфические черты в развитии синтаксической системы родственных языков. Именно под таким углом зрения рассматриваются в данной статье модели словосочетаний с повтором деепричастных форм, зафиксированных в различных письменных и реально функционирующих современных литературных и бесписьменных монгольских языках.

Следует подчеркнуть, что в истории монгольских языков редупликация деепричастий всегда выступала как живой и продуктивный способ передачи лексико-грамматических значений, в частности аспектуальных. Об этом неоднократно указывалось в трудах многих лингвистов, например, Г. Д. Санжеева, Ш. Лувсанвандана, Т. А. Бертагаева, Ц. Ц. Цыдыпова, А. Шархүү и др. Как отмечает З. В. Шевернина, специально занимавшаяся исследованием редупликации деепричастий в современном монгольском языке, повтор деепричастных форм служит для выражения таких аспектуальных характеристик действия, как интенсивность, продолжительность, непрерывность, повторяемость, длительность, последовательность и т. д.

Материал, привлеченный к анализу, позволяет выделить два типа словосочетаний с повтором деепричастных форм: 1. конструкции с тождественным повтором, т. е. удвоением одной и той же деепричастной формы однокоренного глагола; 2. конструкции, включающие неполное, или частичное удвоение различных деепричастных форм одного и того же глаго-

ла (идентичный повтор). Оба типа повтора представляют собой лексически целостное образование и выполняют функцию единого члена предложения-обстоятельства образа действия¹. Компоненты редуликата объединяются одной интонацией и произносятся без паузы. Чаще всего наблюдаются повторы соединительного, слитного, разделительного и продолжительного деепричастий.

Модель словосочетаний с повтором формы слитного деепричастия имеет место в памятниках среднемонгольского, классического монгольского и ойратского письменного языков: ай-тур қонаулан қонаулан уабуқи (СС, §81) 'скитаться, почуя по чужим юртам' simin simin asqaqu (СС, §145) 'отсасывая выплевывать (кровь)' тогурен тогурен айсуқи (АТ., 1, 62) 'приближаться с ревом и мычанием', еке дегуи наг-йуан егін егін одуқи (АТ., 1, 42) 'отправляться в поисках матери и младших братьев', уаган уаган огулеки (ТД., 104); говорить быстро быстро'.

Из современных монгольских языков словосочетания с повтором слитного деепричастия наиболее широко представлены в халха-монгольском, бурятском, монгорском и дунсянском. Ср. например, монг. эргэн эргэн харах 'смотреть, часто оглядываясь назад', бур. хүшэлэн хүшэлэн үндэлзэхэ; делать усилие приподняться', монгор, даулан даулан сауку 'голосить, громко рыдать, издавать вопль', дунс. үджэн үджэн сауку 'сидеть, все время посматривая'. Менее употребительны они в современном калмыцком языке. Словосочетания этой модели более характерны для фольклорно-эпических текстов, например, өндөн өндөн цоклдох 'обмениваться ударами, привставая на стременах' (из «Джангара»). Как свидетельствуют примеры, конструкции с повтором слитного деепричастия обычно реализуют значение непрерывности действия и методичности его совершения.

Словосочетания с повтором соединительного, разделительного и продолжительного деепричастий также относятся к числу достаточно распространенных в монгольских языках. Причем конструкции с редупликацией разделительного деепричастия особенно показательны для калмыцкого и халха-монгольского языков: калм. өср д өср д йовх 'идти слегка подпры-

1. В известной мере можно говорить о наличии еще одного типа словосочетаний с редупликацией деепричастных форм, образованных от глаголов парного употребления. Ср. монг. чадан ядан хийх 'делать кое-как, еле еле' калм. хахн пахн идх 'есть, давясь пищей' бур. уйлан хайлан һууха 'сидеть рыдая и плача' и т. д.

гивая и подскакивая' дээвлэд дээвлэд зулх 'убегать, покачиваясь из стороны в сторону' монг. уншаад уншаад ойлгохгүй 'читать, читать и не понимать'.

В бурятском и калмыцком языках более известны словосочетания с тождественным повтором соединительного деепричастия: бур. мүшхэжэ мүшхэжэ һурагшлах 'выведывать, разуживать все досконально; калм. келж келж тэвх 'высказать все и отпустить'. Ср., монг. явж явж очих, 'ходить ходить и придти'.

В таких изолированных, или маргинальных, языках, как баоньский и дагурский весьма часто употребляются словосочетания с повтором продолжительного деепричастия: баон. йүсээр йүсээр кэлэку 'говорить, все продолжая идти'; дагуур. гүйсээр гүйсээр үдүрээ барах пробегаць целый день'. Указанная модель типична также для монгольского и калмыцкого языков: монг. сурсаар сурсаар эрдэмтэн болох 'долго учась, стать ученым человеком', калм. йовсар йовсар күрэд ирх 'долго идти и прибыть' (букв. идя идя добраться').

Словосочетания с повтором деепричастия на -ж и -саар выражают значение непрерывного и длительно совершающегося действия, а словосочетания с повтором деепричастия на -аад передают значение многократности и частой повторяемости действия.

Как отмечалось выше, конструкции с нетождественным повтором образуются на базе разных форм деепричастий. Более частыми являются словосочетания с формами слитного и продолжительного, слитного и разделительного, слитного и соединительного деепричастий. Приведем ряд примеров: классич. kodelju keger-e baуиqu (АТ., 1, 21) 'продолжая двигаться, остановиться в степи', ойрат. уабун уабуq-sar иулзаqu (ТД. 126) 'ехать ехать и встретиться' tedkun tedked otulku (ТД., 57) 'опекая и ухаживая, состариться', монг. майлан майлсаар явах 'идти неустанно блея', ноцолдож ноцолдсоор хил давах 'с затяжными боями переходить границу' (букв. 'борясь, схватываясь'), бодож бодоод хэлэх 'поразмыслив, говорить что-л.', калм. сун сууж үрглх 'сидя, посиживая дремать', 'кевти кевтж цокх 'бить, находясь в лежащем положении'.

В ойратском письменном и калмыцком языках употребляются словосочетания с повтором слитного и предельного деепричастий: багун bartala ideku (ТД., 147) 'есть до тех пор, пока все не съест' үкн үктлэн санх 'вспоминать до самой смерти'.

Словосочетания с нетождественным повтором основы глагола и продолжительного деепричастия активно функционируют в монгольском и бурятском языках. Представлены они и в классическом монгольском языке: классич. *уаби уабуу-ауаг иреку* (МСЧ, 465) 'идя, идя придти' ехать, ехать и приехать', монг. *өг өгсөөр дуусах* 'давать, давать и все отдать', бур. *мүлхи мүлхиһөөр эрье дээрэ гараха* 'ползя ползком податься на берег; хараа харааһаар ошожо бууха' 'подъехать с руганью и бранью'. Как отмечают исследователи, с помощью конструкций с удвоением глагольной основы и деепричастия на -саар реализуется значение давно начатого и продолжающегося во времени действия.

В бурятском языке допускается утроение разных форм одного и того же глагола, которое используется для усиления длительно протекающего действия, а также для указания на методическую настойчивость его выполнения, о чем в свое время писали Т. А. Бертагаев (1961, с. 17), Г. Д. Санжеев (1962, с. 289) и Ц. Ц. Цыдыпов (1972, с. 118) *хүбүүн яба ябаһаар ябана, ошо ошоһоор ошоно*. 'Мальчик все идет и идет, все двигается и двигается'. *Баахалдай хүсөө гаргажа харай харайһаар харайжа...* 'Мишка что есть силы бежать, бежать, бежать...

Аналогичное явление иногда можно наблюдать и в языке калмыцкого героического эпоса «Джангар»: *Күрсэр күрсэр уулын хажууд нь бүгэд бултад бээв*. 'Шли долго, долго и, достигнув горы, укрылись там'. *Эн хойр көвүн йовсар йовсар йовад...* 'Эти два мальчика продолжали идти, идти и идти...

Такого рода факты говорят об исконности и древности словосочетаний с деепричастными редуplikатами. Вместе с тем нельзя не заметить постепенное угасание прежней их активности и продуктивности. Отличительной особенностью бурятского языка является то, что в нем употребительны словосочетания-редупликации, состоящие из деепричастия степени действия на -хысаа и однокоренного глагола: *баярлахысаа баярлаха* 'сильно радоваться, ликовать', 'По своей функциональной природе словосочетания с деепричастно-глагольными редуplikатами призваны выражать характер и способы протекания действия. В этом отношении они тесно граничат с аналитическими видовыми формами, от которых отличаются преимущественно тем, что состоят не из деепричастия и служебного глагола, а из деепричастия и знаменательного (полнозначного) глагола.

На основании рассмотренного материала можно сделать вывод о том, что набор и состав типовых моделей словосоче-

таний с повтором причастных форм, сохраняя историческую преемственность, в большинстве своем совпадает в монгольских языках. Однако наряду с общностью действующих моделей, указанные словосочетания отличаются степенью продуктивности, сферой употребления и характером сочетаемости деепричастных форм в рамках той или иной конструкции.

ЛИТЕРАТУРЫ

1. Бертагев Т. А. О морфологическом строе бурятского языка. М., 1961.
2. Санжеев Г. Д. Глагол. Грамматика бурятского языка. Фонетика и морфология. М., 1962.
3. Цыдыпов Ц. Ц. Аналитические конструкции в бурятском языке. Улан-Удэ. 1972.
4. Шархуу А. Деепричастие и деепричастные конструкции в современном монгольском языке (в сопоставлении с аналогичными фактами русского языка). Автореф. канд. дисс., М., 1971.
5. Шевернина З. В. Редупликация деепричастий в монгольском языке. Исследования по восточной филологии. М., 1974.
6. Базаррагчаа М. Монгол хэлний өгүүлбэр. УБ., 1987.
7. Тодаева Б. Х. Монгольские языки и диалекты Китая. М., 1960.

СОКРАЩЕНИЯ ИСТОЧНИКОВ

- МСЧ Черемисов К. М., Румянцев Г. Н. Монгольско-русский словарь по современной прессе. Л., 1937.
- ТД Лувсанбалдан Х. Тод үсгийн дурсгалууд. УБ., 1976.
- СС Козин С. А. Сокровенное сказание. Монгольская хроника 1240 г. М.-Л., 1941.

О. Самбуудорж

ӨГҮҮЛБЭРИЙН ГИШҮҮН ТЭГЭЭР ИЛРЭХ НЬ

Хэл шинжлэлд тэг бүтээврийн тухай ойлголт бий болж улмаар монгол хэл шинжлэлд нэлээд хугацаа өнгөрсний эцэст хүлээн зөвшөөрөх болсон байна. (4: 4—5). Монгол хэлзүйн бичигт тэг бүтээврийг үгийн язгуурын дараа нөхцөлийн өмнө тохиолдох үндэс үүсгэх тэг бүтээвэр (4: 5, 5: 32), нэр үгийн тэг нөхцөл (8: 36—60, 4: 46—56) зэргээр холбон ойлгож байна. Жишээлбэл: **Манай үйлдвэр цагийн ашиглалтыг сайжруулах бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, аж ахуйн тооцоог нэвтрүүлэхийг гол болгож байна.** («Үнэн» сонин, 1988, № 118) гэсэн үйлт нэрийн хэллэгтэй нийлмэл өгүүлбэрт эцсийн бус хоёр хэллэг өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүн **«сайжруулах, дээшлүүлэх»** хоёр заахын тийн ялгалын тэг нөхцөлөөр илэрсэн байна. Монгол хэлэнд үйл үгийг тэг нөхцөлөөр илэрдэггүй гэдэг. Үүнд, «сайжруулах, дээшлүүлэх» эл хоёр үгийг тэг нөхцөлтэй үйл үг гэж ойлгож болохгүй бөгөөд, нэрийн нөхцөл авах үгийн сан-хэлзүйн утга бүхий дагавар бүтээвэртэй бидний «Үйлт нэр» гэж нэрлэж хэвшсэн дагавар бүхий үгс билээ.

Үгзүйд буюу үг холбож өгүүлбэр бүтээхэд хэлэлгүй орхисон үгийн бүтээврийг тэг бүтээвэр гэдэг бол өгүүлбэрт хэлэлгүй орхисон өгүүлбэрийн гишүүнийг тэг гишүүн гэж болно. Гэхдээ үгзүйд буюу үг холбож өгүүлбэр бүтээхэд хэлэлгүй орхисон бус, харьцаагаар нь үндэс үүсгэх тэг бүтээвэр, нэрлэхийн тийн ялгалын тэг бүтээвэр гэх мэт ойлгодог зүйл бий. Үүнийг бид нэлээд нарийвчлан судалж үзэх хэрэгтэй байна. Тэг гишүүн хэлэхүйн төвшинд ихэвчлэн харьцааны явцад нэг өгүүлбэрт нэг гишүүн, нэг төрлийн зэрэгцсэн хэд хэдэн гишүүн, өөр төрлийн хэд хэдэн гишүүн ч тэгээр илэрдэг байна. Гэтэл тэг бүтээвэр ихэвчлэн (зөвхөн) өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүний эцсийн бус гишүүний бүтээвэрт илэрдэг байна. Ийнхүү өгүүлбэрт тэг гишүүн бий гэж үзвэл, хэлний үзэгдлийг харагдах өнгөн талаас нь бус, түүний хэлбэр агуулгыг бүрэн

гүйцэд танин мэдэхэд болон монгол хэл шинжлэл, хэлзүйн бичиг хийгээд, ерөөс хэл шинжлэлд гүйцэд ба заримдаг өгүүлбэр, нэг ба хоёр бүрэлдэхүүнт өгүүлбэр гэх мэт нэрлэж ирсэн хэлний ойлголтыг өөрөөр авч үзэх боломжийг олгож байна. Жишээлбэл: — Дүүгийн нэр хэн билээ. — Хонгор. (Ч. Лодойдамба «Тунгалаг тамир» УБ; 1971, х. 18) гэсэн хоёр өгүүлбэрийн хоёрдугаар өгүүлбэрийг заримдаг ба гүйцэд бус өгүүлбэр гэж нэрлэдэг нь үнэндээ харагдах өнгөн талаас нь хэлсэн хэрэг. Энэ өгүүлбэрийн гүн бүтцийг — Миний нэр Хонгор билээ гэсэн өгүүлбэр гэж үзвэл, наад зах нь өнгөн бүтэцдээ Миний нэр Хонгор билээ, (Миний нэр) Хонгор (билээ) гэсэн гишүүд нь ил ба тэгээр илэрсэн хоёр гүйцэд хувилбар өгүүлбэр байгаа ажээ. Дурдсан өгүүлбэрийг хэлний нөхөх байрлалын зарчмаар тайлбарлаж болно гэж үзвэл нэг нь нөгөө өгүүлбэрийнхээ байрлалд эс тохиолдовч, нэг нь нөгөө өгүүлбэрийнхээ үүргийг гүйцэтгэж чадах Миний нэр Хонгор билээ, (Миний нэр) Хонгор (билээ) гэсэн хоёр өгүүлбэр болно. Хэлний нөхөх байрлал, өнгөн ба гүн бүтцийн тухай (9: 201-212, 11: 55—65, 14: 45—55, 2: 47—60) зэрэг өгүүллийг үзнэ үү.

Энэ мэт өгүүлбэрийн гишүүн тэгээр илрэх нь хүн төрөлхтний хэлэнд байдаг түгээмэл үзэгдэл юм. Иймд тухайн хэлийг сурч эзэмшихэд зайлшгүй анхаарах зүйлийн нэг. Ийм тэгээр илэрсэн гишүүнийг хаалтад нөхөн бичиж үзүүлбэ. Жишээлбэл, Монгол хэлэнд, Бадарч өнгөрсөн жил Төмөрийг усанд хөвж явахад нь бариад тамган дээр аваачиж өөрөө банздан, ширлэжээ. (Бадарч) Тахар хийсэн үедээ олон хүнийг ширлэсэн бөгөөд тэд нараас оргож байсан хүнгүй (байв). Гэтэл цахнур Төмөр (тэд нараас) оргожээ. (Ч. Лодойдамба «Тунгалаг Тамир» УБ; 1971, х. 19)

— Бөөрөлжийн төгөл (хаа байна аа)! Бөөрөлжийн төгөл хаа байна аа? гэж Палам дуу алдав. Жолооч түүний өөдөөс гайхан хараад,

— (Бөөрөлжийн төглийг) Огтолчихсон шүү дээ инженер ээ! гэв.

— Хэзээ, хэн? (Бөөрөлжийн төглийг огтолсон бэ?)

— Сарын өмнө, (огтолчихсон юм) ... С. Эрдэнэ «Шилмэл өгүүллэгүүд» УБ; 1988, х. 138) Орос хэлэнд, В окнах казарм и солдатских домиков давно уже было темно, но в одном (доме) из лучших домов крепости светились еще все окна. (Л. Н. Толстой «Хаджи-Мурат» повести, М; 1989, стр. 163) — Что давно встали, Михайло Василевич? — спросил Лухнов, ... — Нет, сейчас только (Я встал). Отлично спал. (Мөн ном, стр. 10) Англи хэлэнд, They have tea in the afternoon and

(they have) supper in the evening. — Did he take a bus from the station to the office? — Yes, he did (took from the station to the office bus) гэх мэт. Хэдий тийм ч ийм гишүүнтэй өгүүлбэрийг угсарсан өгүүлбэр, нийлмэг өгүүлбэр-слитное предложение, өгүүлбэрийн нуугдмал гишүүн, өгүүлбэрийн далд гишүүн-эллиптический член предложения, заримдаг өгүүлбэр, төгс бус өгүүлбэр-частное предложение, неполное предложение, дутмаг өгүүлбэр-недостаточное предложение гэх мэт нэрлэсэн, өгүүлсэн зүйл нэлээд байдаг. Манай нэрт эрдэмтэн академич Ш. Лувсанвандан энэ талаар чухал онол саналыг дэвшүүлж байв. Жишээлбэл, «Нэгэнт өгүүлбэр нь юм, хөдөлгөөн хоёрыг багтаасан дохио байдаг бол юмыг заасан нь нэрээр, хөдөлгөөнийг заасан нь үйл үгээр хэлбэржих нь зүйн хэрэг болно. Гэвч хэлзүйн бичиг зохиолд хоёр бүрэлдэхүүнт үгэлбэр, нэгэн бүрэлдэхүүнт үгэлбэр, нэр үглэхүүн, үйл үглэхүүн гэж ялгасаар байна. Энэ бол хэлний үзэгдлийг үзэгдэх өнгөн талы нь харж мөн чанарыг нь олохыг хүсээгүйгээс болсон байна (11:57) гэсэн нь үүний жишээ мөн. Мөн түүнчлэн «Өнгөцхөн үзэхэд нэг бүрэлдэхүүнтэй буюу нэр үглэхүүнтэй үгэлбэр гэмээр үгэлбэр ярих, бичихэд арвин тохиолдоно. Жишээлбэл, Манай үүгээр саяхнаас зуншиж байна. Би багш. Тэр залуу бол оюутан. Энэ эмэгтэй бол малчин гэх мэт. Гэвч энэ мэтийн үгэлбэрийг тал бүрээс нарийвчлан хянаж үзвэл, ганц бүрэлдэхүүнт үгэлбэр гэдэг нь үнэндээ хоёр бүрэлдэхүүнт үгэлбэр, үгэлбэрийн цэвэр нэр үглэхүүн гэдэг нь нэр, үйл хавсарч бүтсэн нийлмэл үглэхүүн, үглэхүүний цөм үйл үгийг хурааж хэлсэн дутмаг үгэлбэр юм. Ийм дутмаг үгэлбэрийг хялбархан хоёр бүрэлдэхүүнт үйл үглэхүүн болгож болно. Жишээлбэл, Би багш Би багш байна, Тэр залуу бол оюутан. Тэр залуу бол оюутан байна гэх мэт» (11:57—58) гэжээ. Энд хурааж хэлсэн тэр үг нь өгүүлбэрийн тэгээр илэрсэн гишүүнтэй таарна. Өөр нэг өгүүлэлдээ «Юм, үзэгдэлгүй хөдөлгөөн, хөдөлгөөнгүй юм, үзэгдэл гэж байхгүй тул чанартаа юм буюу үзэгдлийг хөдөлгөөний нь хамт гүйцэд заасан төгс дохио болох үгэлбэр нь заавал үглэгдэхүүн үглэхүүн гэсэн хоёр бүрэлдэхүүнээс бүтэх ёстой байна. Гэвч ярихад аль нэг бүрэлдэхүүний бүхлээр буюу зарим хэсгий нь хураан хэлж болно. Жишээлбэл, Би оюутан (байна), Тэр хүн багш (байна) гэх мэт. Үгэлбэрийн ямар нэг гишүүнийг хязгааргүй дэлгэрүүлж болдог тул бүх гишүүний нь шавхан ил хэлсэн төгс үгэлбэр гэж байхгүй, байж болох ч үгүй юм. Энэ учраас үгэлбэрийн өдий төдий гишүүнийг орхиж жинхэнэ хэрэгтэй хэлийг нь хэлнэ. Ингэж хэлбэр үгэлбэрийн гишүүнийг ил ги-

шүүн, далд гишүүн гэж хувааж болно. Далд гишүүн гэсэн нь хэлэлгүй орхисон гишүүд болно... Энэ далд гишүүн нь бүхэл үглэгдэхүүн бүлэг, үглэхүүний бүлэг, үглэгдэхүүн, үглэхүүн (ий—О.С) зарим хэсэг ч байж болно. Өөрөөр хэлбэл далд гишүүнгүй үгэлбэр байж болохгүй юм» (10: 46—47) гэж үгэлбэрийн далд гишүүн гэсэн чухал санааг хэлсэн байна. Гэхдээ далд гишүүн гэсэн ойлголтыг тухайн өгүүлбэрийн зайлшгүй байх гишүүнд бус, өгүүлбэрийн гишүүнийг хязгааргүй дэлгэрүүлэх боломжид түшиглэсэн нь бидний өгүүлж буй зүйлээс санал зөрж байгаа юм. Иймд далд буюу тэг гишүүн гэдгийг зөвхөн тухайн өгүүлбэрийн зайлшгүй байвал зохих хэлэлгүй орхисон тэр гишүүнд холбож үзэх нь зүйтэй.

Өгүүлбэрийн гишүүн тэгээр илрэх болсон нь түүхэн үзэгдэл мөн. Түүний үүсэх болсон шалтгаан нь хэлний хэмнэл, хүний хийсвэрлэх сэтгэхүйн үр дүн гэвэл зүйтэй. Хүн төрөлхтөн бодол саналаа хэл яриагаар илэрхийлж чаддаг болсон эхний үедээ үгийн бүтээвэр ба өгүүлбэрийн гишүүнийг тэгээр илрүүлж хэлдэггүй байжээ гэж болох юм. Үүнийг хүүхдийн хэл яриа, тухайн хэл сурч буй гадаадын хүн, ярих чадвар сул зэрэг хүний үг ярианаас мэдэж болно. Жишээлбэл, —Эгч ээ, хэнд ч битгий хэлээрэй, —Хэлэхгүй. (Ч. Лодойдамба «Тунгалаг Тамар» УБ; 1971, х. 17), Таныг таних ч үгүй, Харин хөгжмөө тоглоод үз л дээ гэж би тайвшруулав. (С. Эрдэнэ «Шилмэл өгүүллэгүүд» УБ; 1988, х. 265) гэх мэт тэгээр илэрсэн гишүүнтэй өгүүлбэрийг —Эгч ээ (та намайг) хэнд ч битгий хэлээрэй. — (Би чамайг хэнд ч) хэлэхгүй. Таныг (энэ хүн) таних ч үгүй. Харин (та) хөгжмөө тоглоод үз л дээ гэж би тайвшруулав гэх мэт гишүүнийг нь илрүүлэн ярьж бичих нь олонтоо байдаг.

Өгүүлбэрийн гишүүн тэгээр илрэхэд хэлний орчин болох бүтцийн (хэлзүйн) ба холбосон орчин, хэлний бус орчин болох мэдэгдэхүүн ба мэдэхүүний орчин онцгой үүрэгтэй байдаг байна. Иймд «Бүтцийн орчин гэдэг нь хэлзүйн хэлбэр, байрлалыг хэлж, холбосон орчин гэдэг нь урд хойд морфем, үг, холбоо үг, үгэлбэрээс болохыг хэлж, мэдэгдэхүүний орчин гэдэг нь уул дохионы цаад бодот юм, үзэгдэл мэдэхүүний орчин гэдэг нь тэр юм, үзэгдлийг мэдэж байгаа хүнээс болохыг хэлнэ» (12: 23) гэсэн үндэслэлийг гол болгож үгэлбэрийг энэ дөрвөн талаас нь ажиглан үзвэл өгүүлбэрийн бүтэц хийгээд тэг гишүүнийг амархан мэдэж болно. Чухамхүү өгүүлбэр зүйн асуудлыг энэ дөрвөн талаас нь буюу хэл ба хэлэхүй, мэдэгдэхүүн ба мэдэхүүний талаас нь судлахыг гол болгож буйг өнөөгийн хэл шинжлэлд судлагчид тэмдэглэж байна (1:

3—4, 3: 410—510). Өгүүлбэрийн гишүүдийн ил ба тэгээр (бүрэн ба бүрэн бус) илрэх нь бодит байдал, тухайн нөхцөл шалтгаан чухал үүрэгтэй байдаг. Иймээс ч Зөвлөлтийн эрдэмтэн Б.Звегинцев нөхцөл байдал (ситуация)-ыг өгүүлбэрийн нэг үндсэн шинж (7:174—185) гэсэн буй.

Монгол хэлний тэг гишүүнтэй өгүүлбэр нь хэд хэдэн онцлогтой. Тэг бүтээвэр нь өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүний эцсийн бус гишүүний бүтээвэрт тохиолддогийн адил, тэг гишүүн нь зэрэгцсэн холбоо үг ба өгүүлбэрийн эцсийн бус холбоо үг ба өгүүлбэрийн гишүүнд тохиолдоно. Жишээлбэл, Академич III. Лувсанвандан «Үг зэрэгцүүлэн холбох ёс гарсан нь үг хурааж хэлэхээс болсон байна. Жишээлбэл, Цагаан цэцэг ургажээ, Шар цэцэг ургажээ, Улаан цэцэг ургажээ гэхийг хурааж Цагаан, шар, улаан цэцэг ургажээ гэж хэлсэн, Цэцэг шар байна, Цэцэг улаан байна, Цэцэг цагаан байна гэхийг хурааж Цэцэг шар, улаан, цагаан байна гэж хэлсэн хэрэг болно (12: 8—9) гэсэн байдаг. Үүнд цэцэг, байна хоёр үгийг тэгээр илрэхэд хэлний холбосон орчин чухал үүрэг гүйцэтгэжээ. Ийм маягийн өгүүлбэрийг манай зарим эрдэмтэд угсарсан өгүүлбэр гээд «Энгийн өгүүлбэр (эсвэл өгүүлбэрийн цөм)-тэй нэг буюу түүнээс дээш өгүүлбэр (эсвэл өгүүлбэрийн цөм)-тэй шүтэн барилдахдаа зэрэгцэх харьцаанд ороод нөгөө өгүүлбэрийнхээ цөм эсвэл дэлгэрүүлэгч гишүүнийг түрж гаргасан өгүүлбэрийг угсарсан өгүүлбэр гэж нэрлэж байна (6: 47—48). Жишээлбэл, Өвгөн нь бэл рүү, эмгэн тал тийш, хүү нь уул өөд явав (П.Хорлоо) гэсэн угсарсан өгүүлбэрийг

(а) Өвгөн нь бэл рүү явав,

(б) Эмгэн тал тийш явав,

(в) Хүү нь уул өөд явав гэсэн өгүүлбэрийн цуваанаас бүрэлдэн тогтсон байна... (в) өгүүлбэрийн өгүүлэхүүн (явав) нь (а), (б) өгүүлбэрийн өгүүлэхүүнийг түрж гаргасанд оршино (6: 50) гэж үзсэн байдаг.

— Дүүгийн нэр хэн билээ — (Миний нэр) Хонгор (билээ) ийм өгүүлбэрийн гишүүн тэгээр илрэхэд хэлний ба хэлний бус орчин зэрэг чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Гэтэл Эгч ээ (та намайг) хэнд ч битгий хэлээрэй гэсэн өгүүлбэрийн гишүүн тэгээр илрэхэд хэлний бус орчин чухал үүрэгтэй байсан нь мэдэгдэж байна. Ийнхүү өгүүлбэрийн бүтэц, хэв шинжийг судлах, бүрэн гүйцэд танин мэдэхэд өгүүлбэрзүйн судлалд тэг гишүүн гэсэн ойлголт ихээхэн үүрэгтэй болох нь илэрхий.

1. **М. Базаррагчаа** Монгол хэлний өгүүлбэр (Албаны хэрэгцээнд) УБ; 1987
2. **Д. С. Бархударов** К вопросу о поверхностной и глубинной структуре предложения, — «Вопросы языкознания» М; 1973, № 3
3. **В. А. Белошапкова** Синтаксис В кн.: Современный русский язык М; 1981
4. **П. Бямбасан** Орчин цагийн монгол хэлний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг УБ; 1975
5. **П. Бямбасан** (хамтын бүтээл) Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулалт, Монгол хэлний үйл үгийн тогтолцоо УБ; 1987
6. **Г. Жамбалсүрэн** Монгол хэл шинжлэлийн онолын зарим асуудал, Хэлний пэрлэх, мэдээлэх, харилцах дохио УБ; 1987
7. **В. А. Звегинцев** Предложение и его отношение к языку и речи М; 1976
8. **Ш. Лувсанвандан** Орчин цагийн монгол хэлний бүтэц, Монгол хэлний үг нөхцөл хоёр нь УБ; 1966
9. **Ш. Лувсанвандан** Хэлний нөхөх, үл нөхөх байрлалын асуудалд- «Монголын судлал» VII боть, УБ; 1969
10. **Ш. Лувсанвандан** Үглэхүүний бүлгийн эцсийн үг нь үйл үгийн цаг заах, захирах хүсэх төлөвөөр хэлбэржих тухай асуудалд - «Монголын судлал» V боть, УБ; 1977
11. **Ш. Лувсанвандан** Хэлний өнгөн бүтэц, гүн бүтцийн тухай асуудалд — «Мөн цуврал»-д
12. **Ш. Лувсанвандан** Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн бүтцийг судлах тухай асуудал — «Хэл зохиол» УБ; XII боть, УБ, 1977
13. Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй (хамтын бүтээл) (Ш. Барайшир өгүүлбэрийн хэв шинж УБ; 1989
14. **Б. Рагчаа** Монгол хэлний энгийн өгүүлбэрийн өнгөн ба гүн бүтцийн тухай асуудалд — «Хэл зохиол» XII боть, УБ; 1977

Б. Пүрэв-Очир

МОНГОЛ ХЭЛНИЙ «ХАРИН» ГЭДЭГ ХОЛБОХ ҮГИЙН УТГА, ҮҮРЭГ, НАЙРУУЛГАД ХИЙСЭН ЗАРИМ АЖИГЛАЛТ

Нэрт хэл шинжээч эрдэмтэн Фердинанд де Соссюр «Хэлэнд адилтгаж үзэх, ялгаж үзэх хоёроос өөр юу ч байхгүй (2) гэсэн байдаг. Үүнийг хэлний төрлийн ба төрлийн бус нэгж элементүүдийн хоорондын эсрэгцлийн тухай чухал нэгэн сургаал гэж онолчид үздэг. Учир нь Соссюрийн энэ томьёолол бол хэлний олон үзэгдлийн амин сүнс-эсрэгцсэн бүтэц ойролцоо бүтцийн тухай онолын иш үндэс болж байгаа юм. Чухам ийм учраас ч «эсрэгцэл ба эсрэгцсэн бүтэц» (1: 235) гэсэн чиглэлийг Прагын хэлшинжлэлийн чиглэл, сургуулиас аваад Америк, Зөвлөлтийн хэлшинжлэлд баримталсаар иржээ.

Монгол хэлний бүтэц тогтолцоо, хэлзүйн байгууллыг судлахдаа бид бүтэц судлалын дээр дурдсан чиглэл буюу эсрэгцсэн бүтцийн онол, баримтлалыг хэлний түвшин, дэд бүтцийн асуудал дээр харгалзан үзэхгүйгээр өнгөрч боломгүй байна. Монгол хэлний өгүүлбэрзүйн түвшин, түүний их, бага ангиудыг судалж, ажиглаж үзвэл, эсрэгцсэн хос бүтцээр дүүрэн юм. Тухайлбал, холбох нөхцөл, төгсгөх нөхцөл: зэрэгцүүлэх нөхцөл, угсруулах нөхцөл; зэрэгцүүлэх холбоо, угсруулах холбоо; зэрэгцээ үг, угсраа үг; зэрэгцсэн холбоо үг, угсарсан холбоо үг; зэрэгцсэн гишүүлбэр, угсарсан гишүүлбэр; зэрэгцсэн өгүүлбэр, угсарсан өгүүлбэр; чөлөөт холбоо үг, чөлөөт бус холбоо үг; гол гишүүн, гол бус (дэд) гишүүн; нэрийн бүлэг, үйлийн бүлэг; хураангуй өгүүлбэр, дэлгэрэнгүй өгүүлбэр; нэг бүрэлдэхүүнт өгүүлбэр, хоёр бүрэлдэхүүнт өгүүлбэр; онцолбор, дэвсвэр; асуух өгүүлбэр, хариулах өгүүлбэр; батлах өгүүлбэр, үгүйсгэх өгүүлбэр г. м. өдий төдийг дурлаж болно.

Хэлний тэмдгүүдийн хоорондохь харьцааны утгын хүрээнд ч ийм эсрэгцэл, түүнийг илрүүлэх арга, хэрэглүүр байдаг. Ингэхэд тэр нь учирзүйн эсрэгцлээс хэлний эсрэгцэлд дамжих байдлаар илэрдэг тийм зүй тогтолтой байна.

Утгазохиолын хэлний баримтыг ажиглаж үзэхэд учирзүйн хийгээд, харьцааны утгын эсрэгцлийг өгүүлбэрзүйн зэрэгцүүлэх холбооны систем дээр үүрэг нь ойролцоодуу боловч бүтэцээрээ өөр өөр хэрэглүүрээр илрүүлж үзүүлэх тохиолдол, арга байна. Жишээлбэл: Лувсангийн ууц нуруу **бадайрдаг бол** миний ууц нуруу шархирдаг юм (Ц. Дамдинсүрэн) гэсэн эсрэг хоёр өгүүлбэрээс бүтсэн цуварсан хам бүтцийг

а. Лувсангийн ууц нуруу **бадайрдаг байхад** миний ууц нуруу шархирдаг юм.

б. Лувсангийн ууц нуруу **бадайрдаг, харин** миний ууц нуруу шархирдаг юм.

в. Лувсангийн ууц нуруу **бадайрдаг тэгвэл** миний ууц нуруу шархирдаг юм.

г. Лувсангийн ууц нуруу **бадайрдаг ба** миний ууц нуруу шархирдаг юм гэж санааных нь цөмийг эвдэлгүйгээр, хэлэхүйн талд нь арай өөр хэрэглүүр-холбох үгээр илэрхийлж, найруулах боломж байна. Монгол хэлний өгүүлбэрзүйн зэрэгцүүлэх холбооны хэвшинж дээр өгүүлбэрийн утгын эсрэгцэл, эргэлтийн байдлыг үзүүлэхэд гол үүрэгтэй хэрэглүүрийн нэг бол «Харин» гэдэг холбох үг юм. «Харин» гэдэг холбох үг нь бас солин найруулах боломжтой утга ойролцоо хэрэглүүртэй.

Монгол хэлний «**харин**» гэдэг холбох үгийн гарал, бүтэц, утга, үүрэг, найруулгын онцлогийг тусгайлан нарийвчлан судалбал сонин зүйлүүд байх шиг байна.

Өвөрмонголын судлаач Данаа «Монголын нууц товчооны хийсвэр үгийн тухай» өгүүлэлдээ: «**харин**»-ыг өгүүлбэрийн эргэлтийн утгыг үзүүлэн холбох үг гэж нэрлээд өгүүлбэрийн эхэн ба дунд хэрэглэж, өгүүлбэрийн эргэлтийг үзүүлдэг (3: 321) гэсэн байхад судлаач Б. Ваанчиг «**Харин**» гэдэг үг бол, нэгд, хандлага үг буюу сул бүрэлдэхүүний байдлаар, хоёрт, холбох үгийн үүрэгтэй орно, монгол хэлний «**харин**» бол гэд-рэг эргүүлэн холбох үг бөгөөд өгүүлбэрийг хооронд нь хол-бон хэрэглэнэ гээд, Хүйтэрмээр байсан чинь **харин** дулаан болов гэсэн жишээ авчээ (4: 228). Тэгвэл «Орчин цагийн мон-гол хэлний үгзүйн байгуулал» (тэргүүн дэвтэр) номд: «Эс-рэгцүүлэх холбоос нь голдуу өгүүлбэр холбох буюу догол мөрийг холбож орно. Холбоос үгийн үүргээр хэрэглэгдсэн **гэ-лээ ч, гэсэн ч, харин, эсвэл** гэх мэт үгс ийм холбоост багта-на» (5: 128) гэжээ. Дашрамд тэмдэглэхэд, **гэлээ ч, гэсэн ч, эсвэл** зэргийг эсрэгцүүлэх холбоост оруулсан нь эргэлзээтэй байна.

Утгазохиолын хэлний баримтыг ажиглаж үзэхэд учирзүйн хийгээд, харьцааны утгын эсрэгцлийг өгүүлбэрзүйн зэрэгцүүлэх холбооны систем дээр үүрэг нь ойролцоодуу боловч бүтэцээрээ өөр өөр хэрэглүүрээр илрүүлж үзүүлэх тохиолдол, арга байна. Жишээлбэл: Лувсангийн ууц нуруу **бадайрдаг бол** миний ууц нуруу шархирдаг юм (Ц. Дамдинсүрэн) гэсэн эсрэг хоёр өгүүлбэрээс бүтсэн цуварсан хам бүтцийг

а. Лувсангийн ууц нуруу **бадайрдаг байхад** миний ууц нуруу шархирдаг юм.

б. Лувсангийн ууц нуруу **бадайрдаг, харин** миний ууц нуруу шархирдаг юм.

в. Лувсангийн ууц нуруу **бадайрдаг тэгвэл** миний ууц нуруу шархирдаг юм.

г. Лувсангийн ууц нуруу **бадайрдаг ба** миний ууц нуруу шархирдаг юм гэж санааных нь цөмийг эвдэлгүйгээр, хэлэхүйн талд нь арай өөр хэрэглүүр-холбох үгээр илэрхийлж, найруулах боломж байна. Монгол хэлний өгүүлбэрзүйн зэрэгцүүлэх холбооны хэвшинж дээр өгүүлбэрийн утгын эсрэгцэл, эргэлтийн байдлыг үзүүлэхэд гол үүрэгтэй хэрэглүүрийн нэг бол «Харин» гэдэг холбох үг юм. «Харин» гэдэг холбох үг нь бас солин найруулах боломжтой утга ойролцоо хэрэглүүртэй.

Монгол хэлний «**харин**» гэдэг холбох үгийн гарал, бүтэц, утга, үүрэг, найруулгын онцлогийг тусгайлан нарийвчлан судалбал сонин зүйлүүд байх шиг байна.

Өвөрмонголын судлаач Данаа «Монголын нууц товчооны хийсвэр үгийн тухай» өгүүлэлдээ: «**харин**»-ыг өгүүлбэрийн эргэлтийн утгыг үзүүлэн холбох үг гэж нэрлээд өгүүлбэрийн эхэн ба дунд хэрэглэж, өгүүлбэрийн эргэлтийг үзүүлдэг (3: 321) гэсэн байхад судлаач Б. Ваанчиг «**Харин**» гэдэг үг бол, нэгд, хандлага үг буюу сул бүрэлдэхүүний байдлаар, хоёрт, холбох үгийн үүрэгтэй орно, монгол хэлний «харин» бол гэдрэг эргүүлэн холбох үг бөгөөд өгүүлбэрийг хооронд нь холбон хэрэглэнэ гээд, Хүйтэрмээр байсан чинь **харин** дулаан болов гэсэн жишээ авчээ (4: 228). Тэгвэл «Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал» (тэргүүн дэвтэр) номд: «Эсрэгцүүлэх холбоос нь голдуу өгүүлбэр холбох буюу догол мөрийг холбож орно. Холбоос үгийн үүргээр хэрэглэгдсэн гэлээ **ч**, гэсэн **ч**, **харин**, эсвэл гэх мэт үгс ийм холбоост багтана» (5: 128) гэжээ. Дашрамд тэмдэглэхэд, гэлээ **ч**, гэсэн **ч**, эсвэл зэргийг эсрэгцүүлэх холбоост оруулсан нь эргэлзээтэй байна.

Монгол хэлний баримтыг ажиглавал, «харин» гэдэг холбох үг нь цуварсан өгүүлэхүүн, цуварсан өгүүлбэр, тэрчлэн цуварсан цогцолбор, эхийн хэсгийг дундаас нь холбож, байгаль, нийгмийн юм, үзэгдэл, хэрэг явдлыг утгын эргэлтээр нь эсрэгцүүлэн жишсэн, эсрэгцүүлэн зэрэгцүүлэн тавьсан зэрэг утгыг үзүүлж, зэрэгцсэн хоёр хосыг холбодог хэрэглүүр болох нь харагдаж байна. Жишээ нь:

Хорт могойн хэл
Хооронд минь хутгаж
Хов жив оруулбал
Холдож салалгүй, харин
Хоёр нүүрээр учирч

Хор хөнөөлийг тасалж байя («Монголын нууц товчоо») гэхэд цуварсан өгүүлэхүүний хүрээнд утгын эргэлтийг үзүүлж; Голын усанд элэгдсэн бөөрөнхий чулуу бол мөлчгөр зөөлөн бас бүлээхэн эелдэг байна. Өндөр уулын орой дахь чулуу мөн салхины урсгалд элэгдэн зөөлөрсөн боловч хүйтэн байна. Харин асганы чулуу юунд ч элэгдээгүй учир хатуу, хурц бас хүйтэн байна (Л. Түдэв) гэхэд голын усны чулуу, өндөр уулын орой дахь чулуу, асганы чулууны байдлыг зэрэгцүүлэн тавьж, учирзүйн хувьд эсрэг тэсрэг шинжтэй байдгийг үзүүлж, хэлзүйн хувьд цуварсан өгүүлбэрийн утгын эргэлтийг нь гаргахад «харин» гэдэг холбох үгийг хэрэглэсэн байна.

Монгол хэлний «харин»-аар холбогдсон цуварсан байрлалтай, эсрэгцсэн утгатай хам бүтцийг шинжилж үзвэл хэллэгийн нэг тал нь нотлол хэлбэртэй, нөгөө тал нь үгүйсгэл хэлбэртэй байх нь олонт байна. Ингэхдээ үгүйсгэл хэлбэртэй хэсэг нь «харин»-ынхаа урд, нотлол хэлбэртэй нь хойно нь байдаг эсвэл нотлол хэлбэртэй нь «харин»-ынхаа урд, үгүйсгэл хэлбэртэй нь ард нь байдаг харьцаа зүй тогтол, байрын хуультай гэж үзэж болно. Жишээ нь:

1. Одоогоор манай нэгдэлд нэгдлээ тарааж, малаа хувааж авъя гэсэн саналтай малчид алга. Харин түрээсийн гэрээний болзол хатуу байна, Үүнийг хөнгөрүүлье гэдэг бодол санаа их байгаа юм. (Үнэн, 1990. № 294), гэхэд үгүйсгэл байдалтай хэсэг нь өмнөө, нотлол хэлбэртэй нь ардаа байрлажээ.

2. Ийм хүнийг чинь жожиг гэлгүй яах вэ дээ. Харин 1958 онд Сэрээнэн гуайг нэгдлийн тэргүүний сайчуудын нэг болж, мандаж эхэлснээс хойш Жож гэж хочлохоо больсон юм (Л. Ванган) г.м. гэхэд нотлол хэлбэртэй нь өмнөө, үгүйсгэл хэлбэртэй нь хойноо орсон харагдаж байна. Энэ мэт жишээ баримтаас харахад, «харин» гэдэг тэмдгийн хоёр талд үгсийн

жилгээний өгүүллүүд (доорд) Хас-Эрдэнэ найруулав. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, Хөххот, 1990.

4. **Б. Ваанчиг.** Монгол хэлний хийсвэр үгийн толь. Өвөрмонголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. Хөххот, 1990.
5. Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал. (тэргүүн дэвтэр), УБ., 1987.
6. **Ван Фусян.** Паратаксистная связь и паратаксистные конструкции. Русский язык за рубежом. 1988, № 3
7. **Ц. Өнөрбаян.** Орчин цагийн монгол хэлний холбоос, холбоос үгийн тухай. УБДС-ийн эрдэм шинжилгээ-заах аргын бичиг, УБ., 1981. № 1 (XIV)

Н. Батжаргал (БНХАУ)

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН ДАХЬ АРБУХА БА ЦООРХА ГЭДЭГ НЭРИЙН ТУХАЙ ШИНЭ СУДАЛГАА БА ДАЛИМД НЬ «ОНГОН ТАЛЫН ХУДГИЙГ» ХАЙХ НЬ

Монголын нууц товчоон дахь «арбуха» ба «цоорхад», жич «судрын чуулган» дахь «онгон талын худаг» гэх хэдэн газрын нэрийг шинжлэх нь Чингис хаан насныхаа эцэст Тангуд иргэнийг дайлаар явсан зам мөрийг тодотгож, нууц товчооны судалгааг гүнзгийрүүлэхэд тун чухал ач холбогдолтой юм. Тус өгүүлэлд би арваад жилийн турш анхааран сонирхож ирсэн асуудлаа дэлгэхийн хамт, энэ талаар өнгөрсөн үед эрдэмтдийн судлаагүй буюу судалсан боловч гүйцэд биш гэмээр зарим зүйлийг нөхвөрлөхийг зорив.

1. Арбуха

Ордосын өндөрлөгийн баруун хойт дэнжид хэдэн голын тахирласан тохой дээр арвас (arbas) гэх нэг уул буй. Тэр нь эргэн тойрон бараг 300 газар Уран дөш, Гандгар, Харанхуй, Цээл, Цавчир, Аман ус, Хашаат зэрэг арваад уулаас бүрдсэн болохоор нутгийн хүмүүс эдгээр уулсыг ерөнхийд нь нэг л уулсын системд оруулан үздэг ба уулаа тойрсон малжих сумаа ч «арвас» гэж нэрлэжээ. Арвасын уулын дундуур байрших Уран дөшийн уул нь эртнээс аваад хол ойрд алдаршсан ба Юлдарма дарханы сайхан домог тус уулаас үүсэлтэй. Уран дөш хэдэн зуун газраас харагдах бөгөөд орой нь тэгшхэн болохоор нээрээ ч дөш адил. Далайн төвшнөөс 2149 м өргөгдсөн ба газар зүйн байршил нь умард өргөрөгийн 39°06', зүүн уртрагийн 107°1'-д оршдог «Усан номын тайллага»-д Ши Яань гэж тэмдэглэсэн бөгөөд «...Халил хаднаа үсэг буй бөгөөд дайны агтын хэлбэртэй ажээ. Аяндаа бүтэж зураг мэт болжээ. Ийнхүү түүнийг хадны зурагт уул гэдэг»¹ гэжээ. Одоо арвасын уулнаа ихээхэн хэмжээний хадны зураг үлдсэн ба энэ нь голдуу Зостын хөндий, Сувай хөндий, Мухар жалгад төвлөрч байна. Соносвоос, энд бас Чингис хааны морин туурайгаар цавчигдсан ором ба морио усалсан булаг байдаг гэ-

нэ. «Монголын нүүдэл, малжилын тэмдэглэл»-д «Гол мөрний товчоо»-ноос эш татахдаа «...хэдэн голын умар тийш Ав уул болон Сэрвэн хар уулын баруун хормойгоор өнгөрч Цагаан суваргын зүүн талд хүрээд зүүн хойш муруйн дахин хойшоо урсаж хоёр салаа болов»² гэжээ. Энд дурдаж байгаа Ав уул ба Сэрвэн харын уул гэдэг нь Арвас ба Цээлийн уулыг зааж байна. Чин улсын Сайшаалт ерөөлтийн 25 дугаар оны (1820 он) Түүхийн газрын зургийн сийрүүлээс үзвэл Ордосын баруун гарын дунд хошууны баруун захаар Сэрвэн хар уул, Арвасын уул хойноос өмнө тийш одоогийн байршлалаар залгагдаж байдаг. Тангад улсын үед энэхүү Арвасын уулны өмнөд хэсгийг Шэн зэй шань гэж нэрлэж байжээ.³ Энэ нь миний бодлоор, тангадын Жэн зэй хотын нэрээс гаралтай юм.

Нууц товчооны 265, 267-р зүйлд тэмдэглэгдсэн *arbuqa* гэсэн газрын нэрийн тухай эрдэмтдийн саналыг ерөнхийд нь үзвэл 1. газрын нэр гэсэнд санал үгүй, 2. Хятад галигчлалын монгол сэргээлт хийгээд сийрүүлэл нь харилцан адилгүй. 3. Тус газар одоо хаана байгаа тухай санал зөрж байгаа буюу олонх эрдэмтэд үүнийг тодорхойлоогүй байна. Надад байгаа материалаар бол:

1. Ц. Дамдинсүрэн⁴, Сяа цай шан⁵, Жагчидсэцэн⁶, Элдэгтэй Оюундалай⁷, Хуасай Дугаржав⁸, Дорнотив⁹, Баяр¹⁰ нар «*arbuqa*» гэж буулган аваад тайлбар хийсэнгүй. Тус газрын хаана байгааг ч дурдаагүй.

2. Элдэгтэй Ардажав¹¹ «ар буха», Ихмянгадай Иринчин¹² *arbuqa* гэж уйгаржин монгол үсгээр сэргээсэн, хөдөөгийн Пэрлээ «арбуха» Мансан гуай *arbuqa*-а¹³ гэж сэргээн сийрүүлсэн ба «Асрагч нэрийнт түүх» «Эртний хаадын үндэсний их шар тууж оршив»-д *arbuqa*-а гэжээ.

3. Хятад эрдэмтэн Ту Жи «...цул үхэр гэсэн утгатай үг. Халхын сайн ноён хан аймгийн Арцбогд (*arca bogda*)-ыг хэлнэ. Хорун (Хар хорум)-аас Тангуд өөд асалсан элсэн замд байгаа нэгэн үхрийн хэлбэртэй товцог байгааг ийн нэрлэжээ»¹⁴ гэжээ. Сайшаал гуай Ту жийн энэхүү саналыг нь номдоо эшилэн авчээ. Х. Пэрлээ тус газрыг Алша нутагт байлтай гэсэн ба элдэгтэй Ардажав Пэрлээгийн энэхүү саналыг номдоо эш татаж оруулсан зэрэг болно.

Арван хоёр дэвтэрт нууц товчооны бүх барын хэвлэлүүд 15 дэвтэрт нууц товчоо (үүнд шинээр олдсон 15 дэвтэрт нууц товчоо багтана)-ны хятад галиглал, жич түүний ерөнхий орчуулгуудаас үзвэл тус нэрийн хятад галиглал хажуугийн орчуулга нь нэгдэлтэй байгааг үзэж болно.

Одоогийн Арвас уулын эртний нэрийдэл нь *arbuq* буюу *arbus* байгаад нууц товчоонд *arbuq*-а болсон тухай санал ба баримтаа дараах хэдэн бүлэгт хувааж ярья.

1. XIII зууны үеийн монгол хэлний онцлогоос үзвэл үгийн эхэн ба дунд ордог *v* авиатай нэг бүлэг үгийг уруулын эгшиг бүхий *bu bu*-ийн нийлмэл хэлбэрээр тэмдэглэдэг байжээ. Жишээлбэл орчин үеийн монгол бичгийн хэлэн дэх *bitegun-e* *biraqu bisiretugei jobaland* зэрэг үгсийг *bugun-e* (267 §), *buqau* (85 §) *buraqu* (116 §), *busiretugui* (Гүюг хааны тамгын бичиг (15: 15), *jobuland* Бодичарняа аватарагийн тайлбар (15: 25) гэх мэт. Дээрх жишээнээс үзвэл *arbaq* хийгээд *arbas* гэх үг нь эртдээ *arbuq*, *arbus* гэж дуудагдах буюу тэмдэглэгдэх бололцоо байхын хамт түүнд оршихын тийн ялгалын дагавар -а-г залгавал *arbuq*-а ба *arbus*-а болж болох юм.

Нууц товчоонд байгаа Дэлүүн болдог (*boldoq*-а) уг нь лавтай *deligun boldaq* байсан бөгөөд энэхүү газар Чингис хаан мөндөлсөн тул түүнд онцгойлон хүндэтгэлийн утга ба гийгүүлэгч төгсгөлтэй үгэнд эгшиг жийрэглэх зэрэг шаардлагаар оршихын тийн ялгалын дагавар -а авсан бөгөөд уул *deligun boldaq* нь *deligun boldaq*-а болсон байна. Газар усны нэрэнд оршихын тийн ялгалын хэлбэрээр эгшиг жийрэглэх жишээ МНТ ба уйгуржин монгол үсгийн дурсгалд олон тохиолдоно. «Тэр хавар Амбагай хааны хатад Орбай Сохатай жирин *yekes*-е газар янар гарсанд...» (70 §), «Хэрэйд иргэ-түр хороож тэр өвөл *abjig*-а хүдгэрт өвөлжив» (187 §), «Бичиг минь туулай жил өвлийн тэргүүн сарын арван зургаанаа *arq*-а бүхүйд бичив» (Ил хан Авагын бичиг (15: 27). «*misiq*-а-*arq*-а-ийн ном тэнгэрт тайгч үнэн бай» (Аргуун ханы илгээсэн бичиг (15: 46) гэх мэт.

3. Дээрх *arbas* гэдэг нэр эртдээ мөн одоогийн хэвээр нэрлэгдэж байсан бололцоо ч бий гэж ярьсан. Гэвч тухайн үеийн хэлний онцлогоос болж *arbus* гэж байснаа оршихын тийн ялгалын дагавар оруулбал *arbus*-а болж уйгаржин монгол үсгээр *arbus* гэж тэмдэглэгдэж байгаад нууц товчоонд бичигдэхийн үед доорхи олон тооны дагавар нь оршихын тийн ялгалын а дагавартайгаа нийлээд *q*-а болж ташаарсан буюу тэгж бүүр түүр үзэгдэхээс болж нэгмөсөн *arbuq*-а болсон ч байж мэднэ. Энэ бол үнэндээ нэг л ацаг, орхиц тэмдэг үсэг махбодын ташаарал болох юм. Тухайн үеийн хятад үсгээр салгичилсан хүний хичээмэл үгүйгээс юм уу эсвэл уул товчооныг бичиж хуулсан хүний ташаарал аль аль нь ч байж мэднэ.

4. arbuq~arbaq болон arbus~arbas аль нь ч гэсэн тэмдэг нэр болно. Тус хоёр үгний чухамхүү утга нь бол арвагар юмны арвас арвас, арвага, арвага харагдахыг заахын хамт дүрслэг чанар ба хүнчилсэн шинжийг хамт агуулж буй ар язгуураас бүтсэн үүсмэл нэр юм. Иймэрхүү нэр үг үгзүйн хувьд хэрэг бодисын төрх байдал ба үйл хөдөлгөөнийг дүрслэхдээ армаг, тармаг, орвог, торвог, агдас агдас, мярс, мярс гэхчилэн дан ба давтмал хэлбэрээр илэрдэг байна. Зохиолд дурдсан Сэрвэн хар уулын нэр нь ч иймэрхүү шинжтэй газрын нэрд багтах бөгөөд Чингис хаан тус ууланд ав хийхдээ ер нь арваг сарваг харагдах уулын шинж байдлаар нь ийн нэрлэсэн байж ч болзошгүй юм.

Уул усны төлөв шинжээр нь тус газрынх нь нэр болгох явдал нууц товчоо ба бусад зохиолд туссан жишээ өдий төдий бий. Жишээлбэл Дэлүүн болдог (59 §), Авжига хүдгэр (191 §), Хэлтгий хад (191 §), Түнхэлэг горхин (5 §), Шар хээр (61 §), Бүрги эрэг (96 §), Далан нөмөргөс (153 §), Үхэр чулуу, Тэмээн хүзүүт гэх мэт.

5. Арав, арван гэх тооны нэр дээр олон тооны дагавар -с угсран арвас хэмээх нэр бий боллоо гэж тайлбарлавал бас ч болох тал байна. Иймэрхүү үг нь тооны утгаас гадна бодисын тус биеийг заан нэрлэсэн үүсмэл нэр (тэмдэг нэр) болдог. Жишээлбэл улс, дөрвөд, түмэд зэрэг улс орон, аймаг угсааны нэр бол угийн олон тооны нэр дээр дахин олон тооны дагавар угсарч бий болсон юм. Хэдийгээр олон тооны дагавар нь нэр үгийг хувилгах журамтай боловч заримдаа бүтээвэр болдогийг заавал уул хэрэг бодисын тухайн үеийн орчин ахуйтай нь холбогдуулан үзэхээс биш, зөвхөн хэлзүйн хийсвэр шинжийг үндэслэн тогтоодог биш гэснийг дээрх хэдэн нэрийн жишээнээс мэдэж болно.

Одоогийн Арвас уулын байдлаас үзсэн ч армаг тармаг алслагдаж байгаа арваад уулс нь хоорондоо дэмий хол биш бөгөөд нэг л уулсын системд харъяалагддаг болохоор нээрээ Арвас хэмээх нэр хүртэх нь ч илэрхий. Хааяа нууц товчоонд арав, арван гэх үндсэн тооны нэр нь өмнөө h гэдэг угтвар гийгүүлэгчтэйгээр тэмдэглэгдэж байгаа тул бид заавал нарийн хянамгайгаар хандвал зохино. Би хувьдаа тэрхүү үзэгдэл нь бүх монгол аялгуутны нийтлэг онцлог мөн эсэхийг цаашид судлууртай гэж үзэж байна. Учир нь «XI—XII зуун болтол өнөөгийн өвөрмонгол*, Ниншиан, Алаша болон Хатан

* өнөөгийн өвөр монголын баруун хэсэг буюу Хатан голын орчим гэвэл зохистой.

гол орчмын газрыг Тангуд эзэлж байсан ба эдгээр газар оронд бас бусад үндэстнүүд олноор оршин сууж байжээ. Тухайлбал монгол, хятад, уйгар зэрэг хүн байсан бөгөөд тангуд хүн зөвхөн ноёрхож байсан төдий юм»¹⁶ гэж Тайваньд байгаа эрдэмтэн М. Ядамжав саяхны бүтээлдээ дурдсан ба монгол түүхийн зарим тулгар бичиг, тухайлбал «Алтан товч», «Шар тууж», «Эрдэнийн товч», «Асрагч нэртийн түүх» зэрэг номд «Мунын хошуу», Муна хан, Мунын хөөвөр, зэрэг монгол нэртэй байгааг тус хүн Тангудын харъяанд байсан монгол угсаатнаас нэрийдсэн уугуул нэр хэмээн үзэж байна. Ерөнхийлбөл өнөөгийн «арвас» ба өнгөрсний «арбуг» бол нэг адил «ар» язгуураас бүтсэн үүсмэл нэр, тэгээд шинэ хуучин утгыг хамтад нь агуулж ойролцоо авианы хэлбэр ба адилаватар утгын нэгдмэл цогцыг тун эвлэгээр ерөнхийлснөөр үл барам тэр нь үнэхээр Чингис хаан ав хийж байгаад мариагаа машид өвтгөсөн Арбуха мөн.

II. Цоорхад

МНТ-ны 265-р зүйлд 2 удаа гардаг Цоорха гэдэг газрын нэрийн чухамхүү утга нь бол «олон агуйс» гэсэн үг бөгөөд одоогийн Арвасын уулын системээс зүүн тийш 30 км алслагдан байгаа «Арзайулиас» (арзай улиас)-ыг хэлнэ. МНТ-д Чингис хаан Арбухад ав хийх зуур Зост бороосоо ойчоод мариа нь машид өвдөж тэр шөнө Цоорхад буусан, жич мөн тэндээс Тангадад элч илгээж, элчийг буцаж иртэл мөн энэ цоорхад биеэ сувилахаар болсныг тэмдэглэсэн байдаг. Арзай улиас-аржайулиас одоо Арвас сумын чулуун бай гацааны газар умард өргөрөгийн 39,7⁰, зүүн уртрагийн 107,3⁰-д намхан шиг тал газрын дээр тусгаар орших үйрэмдэг сиймхий улаан чулуулагаар бүтсэн товцог болно. Түүний орчим их арзай*, Бага арзай гэж адилаватар арзгар улаан хадат гурван товцог нэжгээд км-ээр учиглан байрших бөгөөд Сүмт арзай нь зуугаад агуйгаар бүрэлдсэн мөртлөө эртдээ орой дээр нь сүмтэй байсан тул хүмүүс түүнийг Сүмт арзай гэдэг. Ноднин өвөл бид тэнд хамтарсан судалгаа хийснээс үзвэл сүмт арзай бол газрын төвшнөөс 80-аад метр өргөгдөж зүүнш баруунш 300-аад метр урт, тэгшхэн оройтой ширээ шиг хэлбэртэй хад бөгөөд эгц хадыг тойроод адил бус цаг үед цоолдогдсон агуйс нь дээр, дунд, доор гурван дэгтэр жигдрэн өмнөд талд нь хамгийн их төвлөрч, ар талд нь үнэг шувууны үүр

* Арзай — арсайж барсайхыг заасан тэмдэг нэр. Тус товцгуудын жигд бус үзэгдэхээр нь ийнхүү нэрлэсэн байна.

гэмээр маш арвин «цоорхад» байдаг. Олон жилийн салхи бо-
рооны элэгдэлд оройн хэсгийн чулуу нь юүрч унаад зарим
агуй нь эвдлэгдсэн ба нилээд бүтэн гэмээр агуй одоохондоо
50-иад үлджээ. Сүмт арзай өлгийдөө гурван худагтай, усны
хэмжээ нь адилгүй. Яг арзайн хөмсгөн дэх 2 худаг нь ажирма¹
(ажирмаг ч гэж хэлдэг), бөгөөд зүүн өмнө дэх хол шиг бай-
гаа худаг нь чирга* болно. Тэрхүү чирга-ийг улаан усан ху-
даг гэдэг бөгөөд «Арзай-улаан ус» гэсэн ерөнхийлсөн холбоо
нэр ингэж буй болсон ба яваандаа авианы хувирлаас шал-
таж Арзайулиас болсон юм байна.

Тус уулын агуйд бараг XIV зууны үеийн гэмээр Буддагийн
соёлын үлдэц дурсгал маш арвин хадгалагдаж байдаг. Ялан-
гуяа бидний дугаарласан 26-р агуйд их хэмжээний уйгуржин
монгол үсгийн ханын бичээс байгааг бид зургийг нь авч су-
далгаа хийж байна. Бусад агуй дахь ханын зураг, ханын
сийлмэл нь адил бус цаг үед зурагдан сийлэгджээ. Урлагийн
онцлог нь дүн хуан ба Мүй лин агуйсын ханын зураг ба сийл-
мэлтэй адилшаах тал буй тул тус агуйс нь ядахдаа тангуд
улсын үед буй болоод сүүлээр нь Юан улсын үед нэмж бү-
рэлдсэн төлөвтэй. Тус газарт Буддагийн шашин ямар үед
ямар мэт дэлгэрснийг хойшид судлууштай тул энэ талын суд-
лалыг бид улам гүнзгийрүүлэх болно. Тус агуйсын тухай бид
нэгэнт «Монгол хэл утга зохиол» сэтгүүлийн 1990 оны 2-рт
танилцуулсан тул энд нуршихгүй. Тус цоорхадын тухай эр-
дэмтдийн санал нь мөн Арбухаг судалсантай төсөөтэй. Газ-
рын нэр гэсэнд санал нэгдэж сийрүүлэл тайлбар хийсэн нь
хоорондоо зөрөөтэй. Ялангуяа цоорхад гэсэн нэрийг утга зүйн
хувиас судалсан хүн бараг үгүй бөгөөд тус газрын хаа бай-
гаа тухай хэдхэн хүн ярьсан боловч тэр нь «Судрын чуул-
ган»-аас үүсэлтэй өөр нэгэн газрын нэртэй хутган үзсээр ир-
сэн болно. Доор эрдэмтдийн гол санал ба судалсныг бичиг-
лэвэл: 1. Жагчидсэцэн, Элдэгтэй Оюундалай, Хуасай Дугар-
жав, Элдэгтэй Ардажав, Баяр зэрэг эрдэмтэд ямар ч тайл-
бар хийлгүй зөвхөн газрын нэр гэж үзсэн ба монгол сийрүүл-
гийг цогоргад-шогоргад гэж 2 янзаар авсан байна. 2. Ц. Дам-
динсүрэн Цоорха, Мансан «Цоохор хад» гэжээ.

3. Ту жийн номд цоорхад гэсэн үгийн доор тайлбар хийх-
дээ «Газарын нэрийн нууц товчоон дахь утга нь ганц худ-

¹ — ажирма — ордос ярианд гүехэн худагийг ийнхүү хэлдэг.

* чирга — 1. гүн худаг, 2. ус татах дээсийг нь хэлнэ. Ийм дээсийг
үхрийн шир зүсч хийдэг. Зарим гүн худаг бараг 100 гаруй алд
байдаг ба ийм худагт бүхэл үхрийн шир 2 баймаажин дөнгөж
хүрдэг билээ.

гийг хэлнэ...»¹⁴ гэжээ. Сайшаал номдоо түүний тухай нилээд хураангуй чанартай тайлбар хийжээ. Түүнийг товчилбол: Цоорхад гэдэг газар бол нууц товчооны нэр болно. Үүнийг Доссоны номд «Онго талын худаг» гэсэн газраар тэмдэглэж байх бөгөөд «гагц худаг» гэсэн утгатай гэж Ту жий тайлж байна. Рашидын номд «Онгон талан худаг» гэжээ. Доссоны мэдээ нь үүнээс гаралтай нь илхэн байна. Гэвч Ту жийн тайлбар ямар үндэстэйг одоогоор ийн ойлгоход гүжир шиг санагдана» гэжээ. Асуудлын зангилаа нь миний бодлоор бол:

а. цоорхад гэсэн газрын нэрийн чухамхүү утга нь юу гэснийг тодорхойлох,

б. тус газар нь чухам Рашидын ном Доссоны түүх ба Ту жийн номд дурдсан байгаа «Онгон талын худаг»-тай ямар холбоотой,

в. цоорхад болон онгон талын худаг нэг газар мөн эсэх,

г. хэрэв нэг газар биш бол уул газрыг нь тодорхойлох зэрэг эдгээр хэдэн асуудлыг шийдвэрлэхэд оршино. Доор би энэ хэдэн асуудалд чиглүүлэн өөрийн саналаа хэлье.

1. Энэ үгийн хятад галигчилалыг Ихмянгадай Иринчин согоггад гэж уйгуржин монгол үсгээр сэргээсэнийг би зөв хэмээн үзэж буй. Түүнийг одоо үеийн монгол хэлээр сийрүүлбэл цооргад болно. Айлаас эрэхээр авдраасаа эр гэдэгчилэн монгол хэлний хууч язгуур цого-оос үүсэлтэй юм. Цого- (язгуур)→цогоро- (үүсмэл үндэс)→цогорг-а (үүсмэл нэр бүтсэн эдийн -га -гэ бүтээвэр)→цогоргад (олон тооны -д дагавар авч бүтжээ) болсон байна. Цогора-гэсэн үүсмэл үндсэн дээр -га -гэ бүтээвэр авбал цогорг-а болно. Га, гэ-ийн утга ба хэрэглэл нь -лга, -лгэ-тэй адил юм. Түүнийг л, р буюу заримдаа эгшгийн дараа хэрэглэж нэр үг бүтээх орчил монгол хэлэнд олон тохиолдоно. Жишээлбэл «нөмөр-нөмөргө (далан нөмөргөс), уур-уурга (91 §) тул-тулга, туур-туурга, хөш-хөшиг гэх мэтээр олон үгийн үндсэнд залгаж нэр үг бүтээдэг байна.

2. Тус үгийн язгуур болох цого-ийг язгуур үгийн толь¹⁷-д тайлбарласныг үзвэл тэр нь юм хумыг нэвт хатгах буюу нүхлэх, сийлэхийг хэлдэг бөгөөд голдуу хад чулуу, хас сувдыг цоолох үйлд хэрэглэгддэг байна. Тэрчилэн монгол хэлний дурсгал бичигт тусгалаа олж байсныг үзүүлбэл:

а. Тэргүүн одыг луу жилийн арван сарын нэгэн шинэд хавтсанд тамга цоолговой. («Долоон өвгөн одны тахилга»)

б. Дайд дахь цагаахан суваргат их сүмд тамга цоолуулж мянган төгс олноо түгүүлэв. («Бодичарияааватарагийн тайлбар»). Дээрх жишээнээс үзвэл хавтаснаа тамга цоолох атал

хаданаа нүх цоолох буюу цоочих нь аяндаа хэрэг бөгөөд ингэж цоочиж хийснээ хүмүүс цоорго гэж нэрлэх биз. Тэгээд олон болохоор нь - д нэмж олон тоог илтгэсэн төдий юм. Яг иймээс цооргад нь олон агуйсыг заасан утгатай байжээ. Тэр бол өнөөдрийн Сүмт арзайн агуйсыг зааж байсан нь гарцаагүй.

3. Цоорго гэдэг үгийг агуй гэж үзвэл Нууц товчоонд буй агуй гэсэн үгийг хэрхэн тайлбарлах вэ? хэмээн мэргэд асууна. Миний бодлоор бол МНТ-д байгаа агуй гэсэн үг нь тухайн үед уул хадны нүхийг зааж байсан биш, бас хана, туурга буюу хорго, эргэнэгийн юм агуулах хөндийг хэлж байсангүй. Харин агуу их багтаамжтай (чээж уудам) агудам гэсэн утгаар хэрэглэгдэж байсан ажээ. Жишээ нь «Этүгэн эх агуй буй. Мөрөд усад олон буй» (255 §) Тэрчилэн XII зууны үеийн уйгуржин монгол үсгийн дурсгалд олонхидаа МНТ-ны утгаар хэрэглэж байв. Жишээлбэл: Алдарт Чингис хааны зургадугаар үе арчмал толь мэт гэгээн билигт агуй улсын наядугаар их эзэн Аюурбарбада хааны зарлигаар... («Бодичария аватара-гийн тайлбар») гэх мэт. Орчин цагийн монгол хэлэнд тус үгийн утга нэгэнт шилжиж уул хадны агуйг заах болсон нь үндэстний зан суртахуун, шашин шүтлэгтэй холбоотой бөгөөд голдуу бөөгийн шашны устахыг дагалдан тус үгийн утга нь ч бас хувирсаныг харуулж байна. Тухайлбал ноён гэсэн үг мөлжигч байгууллыг устахыг дагалдан зөвхөн одоо зочлолын утгатайгаар хэрэглэгдэх болсон ба банди гэдэг зээлдсэн үг ламын шашны устахыг дагалдан Ордос зэрэг аман аялгуунд утга шилжээд өөрийн хүүхэд дүү нараа өхөөрдөн хайрлах тусгай нэрийдэл тийш хөгжиж байгаатай бараг сацуу очно.

4. Цооргадтай авиа ойролцоо үг МНТ-д хэд хэд тохиолдоно. Гэвч би одоохондоо түүнийг цооргодтай харилцаагүй гэж үзэж байна. Жишээлбэл: а) цуургатай тэрэгний чих нь бүү чигүлдэгүлсү, тэнгисгэтэй тэрэгний тэргүүр дээр бүү тэргүрэгүлсү. (124 §), б. Цоргон гэр цоголиулж цогтой эмийг арвилж (115 §), в. Цэгцэр чигургу (61, 94, 142 §) гэх мэт... тус тус авсан бөгөөд эрдэмтэд эдгээр нэрсийг зүйл зүйлээр тайлбарласны дотор хөдөөгийн Пэрлээгээс «Монголын зарим түүхэнд энэхүү газрын ойр (худаг) цорго (Гомбын Галсаны хэвлүүлсэн алтан товчид Есүхэй баатар Дэй Сэцэнтэй Цэгцэр Чигургу хоёрын хооронд цоргоос морио усалж байхад уулзав гэсэн байдаг. Иймд уул тал завсарласан газар байжээ) байсан гэдгийг үзвэл Хэрлэний адаг байлтай»¹⁸ хэмээн нэг «худаг» буюу «цорго»-ын тайлбар гаргасан нь яг Ту жийн «Монголын түүх тэмдэглэл»-д дурдсан цооргадыг «гагц ху-

тэг» гэж үзсэнтэй санал нэгдсэн мэт болжээ. Гэвч эдгээр эрдэмтдийн тайлбар хийснийг няцаах баримт МНТ-д гарч байна. 1. «Цогоргад» ба «чигурга», «шогоргатай тэрэг» «цорган тэр» зэрэг нэрийн хажуугийн орчуулгад худаг гэсэн үг гаргаагүй. 2. МНТ-д худаг гэсэн үг олон тооны хэлбэртэйгээр 2 удаа илэрсэн явдал бол хамгийн ноттой баримт болно. Жишээ нь «Бас нөгөө үйл усгүй газар худгууд ухаж гаргуулж улс иргэн үс өвснөө хүргүүлэв» (281 §) «...цөмийн худгууд ухуулж хаштугай» (279 §) гэх мэт.

5. Цооргад ба «онгон талын худаг» ~ «онгон далан худаг» нь нэг газрыг зааж байгаа биш, өөрөөр хэлбэл хоорондоо алслагдан орших 2 тусгаар газар болно. Ту жийн номд «Улаан нохой жилийн хаврын эхэнд хаан (Чингис хаан) цооргадаас онгон талын худагт нүүсний дараа муу зүүд зүүдэлж оорийн насан хугацаа тулснаа мэджээ»¹⁴ гэж тэмдэглэсэн байгаа нь «Онгон далан (талын) худаг» нь цооргадаас ойролцоо байх өөр нэгэн газар болно гэсэн чухал сүвэгчийг ханган өгсөн явдал болно. Тухайн үед Чингис хаан юунд «Онгон далан (талын) худагт» нүүсэн тухай дараа ярих болно.

III. Онгон талын худаг

Рашид-ад-дины «Судрын чуулган»-ны 231, 258-р зүйлд 2 удаа гардаг Онгон далан кудук¹⁹ бол онгон талын дундахь худаг болох бөгөөд энэхүү худаг нь одоогийн олон чирга ~ ~ олон нохойн худаг-ыг хэлнэ. Тус худаг Ас Онгоноос баруун тийш холгүй. Арзай улиасаас зүүн өмнө тийш 20 км, одоогийн Онгон талын баруун захад байх бөгөөд газар зүйн байршил нь умард өргөрөгийн 39,6°; зүүн уртрагийн 107,6°-д оршдог, тус газар одоо Отог хошууны Гүнчирга сумын газарт улаан балгаснаас Баянгол хүрэх засмал зам үүгээр хойш онгөрнө. 1972 онд би Гүнчиргад ажиллаж байхдаа хэдэн удаа хүрч очсон юм. Баруун хойноос зүүн рүү хандсан сужигийг дагаж километрийн дотор хааяагүй олон худаг үргэлжилж, хоорондоо арваад метрээр алслагдаж, булагдаагүй байгаа нь 80 илүү байжээ. Нутгийн хүмүүсийн хэлэхээр, энд уул нь 108 худаг байсан бөгөөд Чингис хаан ав хийж явах зуур олон талга (авын нохойс) нь ангаж мухардахдаа Юлдарма дарханаар 108 худгийг тайгасын тоогоор шордон гаргуулсан болохоор одоо худгийн доторхи хаяанд нь дөрөө (малтмал дөрөө нүх, хүн орж гарах дөрөө нүхэвч) үлдсэнгүй гэнэ. Ингээд «Олон нохойн худаг» гэх нэр буй болсон гэдэг. Бас зарим хүний хэлэх нь, уул нь ас онгоны шилд чоно арвин байсан тул олон нохой (чонын цээрлэл нэр) гэж нэрлэсэн гэдэг.

Олон чирга гэдэг бол ордосын ярианд олон гүн худаг гэсэн утгатай үг болно. Саяхан болтол олон чаргаас зүүн өмнө баруун зүгт Хүн малгүй удам шил үргэлжилж байсан ба одоо ч гэсэн өвс бэлчээр сайтай тул нутгийн малчид газрын байршил нь Ас онгоны шил, нохойн шил, Баян овооны шил, Тужийн шил (энд тужийн задгайтай) гэж хэдэн хэсэгт хуваан нэрийдэж байдаг. 6. Онгон талын худаг. Онгон далан худаг гэсэн газрын нэр хэдийгээр Нууц товчоонд тэмдэглэгдээгүй боловч Чингис хаан Тангадыг дайлаар явах зуур хуарагнан сууж өнгөрсөн чухал нэг газрын хувьд анх «Судрын чуулган»-д тэмдэглэгдсэн байгаа бөгөөд Рашид-ад-дины дараа Швед улсын дорнодахиныг судлагч эрдэмтэн Доссон «Монголын түүх»-дээ бичиж оруулсан ба дараа нь монголыг судлагч хятад эрдэмтэн Ту жий «Монголын түүх тэмдэглэл»-дээ бичиж оруулсан байдаг. Гэвч судрын чуулганы манай гарт олдож байгаа хятад орчуулга нь орос хэлнээс дам орчуулагдсан ба орос хэлний орчуулга нь ч бүрэн бүтэн биш бөгөөд ялангуяа зарим газрын нэрийг буруу галиглан буулгасан зэрэг шалтгаанаар онгон талын худаг буюу онгон далан худагийн чухам алин болохыг тодорхойлоход хүчир болжээ. Тэрчлэн Доссоны «Монголын түүх» нь ч бас анх франц хэлээр бичигдээд дараа нь хятад хэлээр орчуулагдсан тул ихээхэн алдаатай зүйл байгаа ба ялангуяа түүний галиглал нь тогтсон баримжаа гэж үгүй хэмээн Пэн жэн жиүйн хятад хэлэнд анх орчуулахдаа хэлсэн байна. Эдгээр эрдэмтдийн галигчилсныг харьцуулан жагсаавал 1. Судрын чуулганы хятад орчуулгын галиглалд... ба уул зохиолд «уунгуун таалан худук» гэж галиглаж байсныг тайлбар хадсан ба мөн номын ар дахь газрын нэрийн хэлхээст «Онгон далан кудук» гэсэн орос хэлний галиг дагалдуулжээ. 2. Доссоны «Монголын түүх»-ийн хятад ба Монгол орчуулгыг үзвэл... онгу тала-ын хуудуг гээд хятад орчуулгын ард «онгон талан коудоук» гэсэн галиг хадсан ба атар хээр бүхий худаг гэсэн утгатай монгол үг болно. Энэ газар Гажил нурууны (онгоу)* орчим байлтай. Учир нь Гажил нуруу бол шанси буюу Тангиудаас хойш холгүй байдаг гэжээ.⁵⁶

Ту жийн номд Арбуха-г тайлахдаа аль болохуйц Халхын Сайн ноён хан аймгийн Арцбогд буюу Онгон гол зүг ойртуулан хэлж байгаа юм. Хэрэв Онгон голын талд байгаа худаг гэж үзвэл тэр нь өнөөгийн халхын Арвайхээр буюу сайхан овоо орчмын газрыг хэлэх бөгөөд бараг Хар түнээс Тангуд

* Энэхүү Онгон гэсэн галиглал монгол орчуулгад дөхөмхийлжээ.

улсыг аслаж байгаа замд байна. Харин их ордос тангудыг неласан замд байгаа биш, үүнийг Доссоны хэлсэн Гажил нурууны орчим байлтай гэсэнтэй адилтгавал тун их зөрж байна. Миний хэлж байгаа «Олон чирга~олон нохойн худаг» бол бас Онгоны талд байх зуугаад худагтай газрыг зааж байгаа бөгөөд «Онгон талын худаг» буюу «Онгон далан» худгийн алинаар тайлбарласан ч дүйх ёстой мөртлөө ялангуяа цооргад-аас нэг нэгүрийн* газар ойрхон байдгаар ийн гэрчлэгдэх болно. Чингис хаан цооргадад мариа халуун байсан тул түүнээс хол нүүх бололцоогүй нь ч лав үнэн байх.

Оngo ба онгон гэсэн үгийг утга зүйн талаас үзвэл хэд хэдэн утгатай. 1-д ангамал хуурай гэсэн утга бий. 2-т газрын гадаргуугийн хотойж гүдийсэн байдлыг хэлнэ. 3-д дархан голдуу онгон шүтээнд холбогдоно) гэсэн утгатай. Жишээлбэл Онгон уул, Онгон шил, онгон тэмээ, онгон азарга гэх мэтчилэн сэтэрлэсэн малыг хэлнэ. 4-д юмны онго цонго урагдаж нэвтэрсэн байдлыг хэлнэ. Эдгээр үгийн утга нь одоогийн олон чирга хийгээд онгоны шилийн байдалд яв цав тохирч байна. Энэ газар эртнээс аваад өвс бэлчээр хуурай боловч чанар сайтай, газрын төвшин өндөр болохоор монгол орны онцлог хийгээд монгол адууны онцлогт тохирсон байдаг. Ялангуяа Олон чиргад олон худаг байсан, жич тужийн задгай эндээс нилээд ойр байж зун намрын борооны ус энэхүү төхөмд аяндаа балхаран нууршиж удаан жил хатдаггүй байснаар Чингис хаан хэдэн түмэн цэрэг морио ус бэлчээр ба бусад талын хэрэгцээгээр энд авчирч түр байрлуулах нь ч зүй ёсонд нийцэж байгаа юм. Өөрөөр хэлбэл олон чирга-ын олон худгууд (77 худаг*) ба тужийн шилийн өргөн уудам бэлчээр ба нуур адил ус задгай үгүйгээр хэдэн түмэн цэрэг морины идэж уух асуудлыг хэрхэн шийдвэрлэх буй. Яг иймэрхүү хэрэгцээгээр цооргадаас Онгон талын худагт шилжсэн гэж би үзэж байна. Энэ газар бол Рашидын ном Доссоны түүх ба Тужийн ном доторхи Чингис хаан муу зүүд зүүдэлсэн газар мөн юм.

4. Чингисийн цэрэг орсон зам шугам Нууц товчоонд тэмдэглэгдсэнээр «тэр өвөл өвөлжиж Тангуд иргэнд морилъя хэмээн шинэ тоо тоолж нохой жилийн намар Чингис хаан, Тангуд иргэнд морилов...» (265 §) гэжээ. Энэ бол Чингис хаан 5

* Рашид нэг нэгүрийг 4 км-ээр боддог гэнэ. Шинжааны Э. Бадмара 15—20 км., Жагчидсэцэн 15 км гэсэн гэнэ.

-- Монгол хэлний заншлаар бол 77 гэсэн тоонд тодорхой утга үгүй. Тэр нь балархайч бөгөөд тойм тоог заана. Далан буюу далан долоо гэнэл олон тооны тойм нэрийдэл, иймээс тэр нь зуун буюу зуугаад худгийг тоймчлон нэрлэж болно.

дахь удаагаа Тангудыг дайлсан, мөн хамгийн сүүлийн удаа Тангудыг мөхөөсөн дайн болно. а. Чингис хаан Тангуд иргэнд морилсон цаг үеийн тухай одоо болтол маргаантай байсаар. «ИМАУ-ын түүх» (нэмж засварласан 3 дахь хэвлэл)-д «1225 онд Чингис хаан эх орондоо буцаж насныхаа сүүлийн жил хагасыг Тангуд улсыг байлдах аян дайнд өнгөрөөжээ» гэснээс үзсэн ч монголын цэрэг 1225 оны намар буюу өвлийн эхээр Тангудад орсон нь үнэн байх ёстой. Гэвч Чингис хаан ба түүнийг дагаж сартуулд явсан ихэнх тооны цэргүүд нь буцаж ирэнгүүт мордохын бололцоо үгүй байна. Тэгвэл ямар цэрэг нь урьдаар Тангудад орсон бэ? гэвэл Сартуулд мордохын үед их аурагт үлдсэн Отчигон ноён тэргүүтэй хэдэн түмэн цэргийг урьдаар явуулах бололцоо байхыг үгүйсгэж болохгүй юм. Тэрчилэн эдгээр цэргийг Тангудыг довтолсон жуулын замаар оруулж Чингис хаан өөрөө охархан хэдэн сарын хугацаандаа шинэ тоо тоолох ба бусад олон талын явдлыг шийдвэрлэсэн байна. Сартуулд хийсэн дайн нь 6—7 жилийн хугацаа авч сунжирсан, монгол цэргийн аялсан замыг бодит тоогоор хэмжихийн аргагүй мөртлөө хэдийгээр энэхүү дайн нь амжилттай явагдсан боловч их хэмжээний хүн ба материалыг сүйтгэсэн болохоор буцаж ирэнгүүт эдгээр цэрэг морь ба бэлтгэл төхөөрөмжийг шинээр нөхөх явдал аль алианаас чухал байсан. Ялангуяа жар гарч жажин үс нь цайж яваа Чингис хаанд авч хэлбэл улс гүрний их явдал язгуур залгамжийн хэцүү асуудал овоорч байсны хамт асын бид нь алжаал зүдрэл асад нь бас зүч хөвүүний эмгэнэл зовнил ба хэд хэдэн жанжны гашуудлууд давхцаж байсныг бүү хэл түм түрүү түмний ноёдоос аваад өвгөрч яваа цэргийн эрчүүл ч гээд машин тоноглол угсарсан биш мах цусаар бүтсэн хар толгойт хүмүүс болохоор аав ээж ах дүү садандаа золгох, гэр нутаг гэргий хүүхэддээ учрах нь ертөнцийн ёс биз. Яг эдгээр биет шалтгаанаар Чингис хаан шинэ тоо тоолж, намрын сүүлч өвлийн эхээр цэргээ бас хэдэн зам хуваан тангудад орсон бөгөөд өөрөө хамгийн ойр дөт хамгийн аюулгүй замаар явж орсон гэж би үзнэ.

2. Цэрэг дайны явдал бол язгуураас аваад явж суух ба ирж очих нь мэдэгдэхгүй нууц далд байдаг нь зуршил билээ. Тухайн үед Чингис хаан Сартуулаас сая эргэж ирэнгүүтээ Тангудыг довтолхгүй гэж Тангудын талаас үзэж байсныг Чингис хаан олж сэдсэн буюу өтлөх насандаа Тангудыг байлдан дагуулахаас гадна өмнө зүгийн хэд хэдэн улс гүрнийг эрхшээлдээ оруулах зорилгоо түргэхэн биелүүлэхийн төлөө 1225 он (тахиа жилийн)-ны эцсээр амжиж Тангудад цэрэг

орсон ба хамгийн охорхан цагийг хэрэгсэж одоогийн Хатан голын тохой Арвас уулын орчимд цөмрөн орсон байна.

3. Тухайн үед Хатан голын тохой доторхи өргөн уудам газар орон нь Тангудын харъяанд байсан боловч зүүн ба өмнө талаараа Алтан улс хийгээд Өмнөд Сүн улстай алслагдан оршиж Алтан улсад нэгэнт цэрэг ороод байсан нь зүүн жигүүрт аюулгүй, ар талаас ойрхон зэрэг давуу нөхцөлтэй байжээ. Нөгөө талаараа Ас шугамаар цэрэг оруулснаас хавьгүй ойр дөт бөгөөд анхдагч дайны зорилгоо Тангудын өрлөг жанжин Аша Гамбуд чиглүүлж байсны хамт алгинч явсан баруун жигүүрийн цэрэг ба ар талд үлдээсэн цэрэгтэй хамтран баруун ба хойт талаас нь Чингис, зүүн талаас нь Алшаад байсан аварга жанжин Аша Гамбуд авч хэлбэл дэвүүрийн хэлбэртэй бүслэлтийн цагирагийг бүрдүүлсэн хэрэг болжээ.

4. Сартуулд хийсэн дайнаас Чингис хаан харийг довтлох нэн арвин туршлагыг хуримтлуулсан. Жич шинэ тоо тоолсон явдал нь хэдийгээр аж ахуй, улс төрийн чанартай тохируулалт ба цэгцлэлтийн агуулга багтаж байгаагийн зэрэгцээ нэн чухал талаас нь авч хэлбэл Тангуд иргэнийг довтлон өмнөд зүгийн хэд хэдэн улсыг охорхон цагийн дотор эрхшээлдээ оруулж цэргийн явдлын шинэ байршуулалт болж байснаар ойлгож болох юм. Яг энэхүү байршуулалтад Эзэнэ голыг өгсөн Тэнгэр элсийг ороон Хашины хөндийгөөр зүүншилдэг байлдах бодлогын зуршлыг эвдэж шууд Мунын хошуу—Хэрмийн зам—Хатан голыг гэтэлж Арбухад ирж дахин баруунш Хатан голыг өнгөрөн Алашад зорьж хүрээд Аша-гамбу лугаа хатгалдаж тэрэм гэрт тэмээн ачаат иргэнийг үнэсээр хийс-тэл дайлсан байна. Ас шугамаар цэрэг орсон баримт Алтан Товч, Эрдэнийн товч, Шар тууж, Асрагч нэртийн түүх Болор толь зэрэг монгол түүхийн тулгар бичигт дурдагдах «Мунын хошуу ~ Мунайн хошуу зэрэг» газрын нэрээр тодотгогдох бөгөөд Хар шуурга хараалч хар эмгэн хачин жигтэй гөрөөс ба шувуу хавт Хасарын учрал зэрэг үлгэр домгууд олонхидоо цөм Тангудын хил (Муна орчим) орчим илрэх бөгөөд ялангуяа Арбухад ирээд агтаасаа ойчсон «Онгон талын худаг»-т хүрээд муу зүүд зүүдэлсэн зэрэг ёр тохиолдох болгон хажууд яваа хатан Есүй жич Толун Чэрби Тулуй хийгээд Өгөөдэй нар нь хаан Чингист айлтгаж харьж буцахыг дуртхагсан атал богд эзний бодлогыг нь хувиргаж чадсангүй, буцаад Тангадыг дайлах зоригийг нь нэн хөвчилжээ. Юу ч гэсэн Чингис хаан 1225 оны өвлийн үеэр их орд буюу Туулын хар түнээс мордож гараад замын Хэрэм, Муна-ын хошуу Хатан голын олмоор дотогшлон Арбухад чиглэж ирсэн төлөвтэй бай-

на. Зарим түүхийн тулгар бичигт олонтоо дурдагдах Эзнэ голоор цэрэг орсон гэх хэллэгүүд нь Чингисийн захирлаар яваа монгол цэргийн баруун жигүүрийг хэлж байгаа бололтой. Учир нь монгол цэргийн байлдан эзэлж явсан газруудыг Чингис хаан эзэлж явлаа гэх нь буруугүй юм.

НОМ ЗОХИОЛ

1. Ван Хүвэ жэй «Усан номын тайллага» Шанхай хот. 1984 он. Хятад хэвлэл. 15-р тал.
2. Жан Му «Монголын нүүдэл малжилын тэмдэглэл». IV боть. 7-р тал.
3. Н. Банзрагчийн монголчилсон «Монгол хошуу нутгийн тэмдэглэл». (дээд дэвтэр) Бээжин, 1988 он. 514-р тал.
4. Ц. Дамдинсүрэн «Монголын нууц товчоо» Хөх хот. 1957 он.
5. Сяа зай шан «Монголын нууц товчоо» Бээжин. 1956 он. 261—263-р тал.
6. Жагчидсэцэн «Шинээр орчуулж тайлбарласан Монголын нууц товчоо». Дундад иргэн улсын 68-р он. Тайвань. 415—419-р тал.
7. Элдэгтэй, Оюундалай «Монголын нууц товчооны харгалан зассан дэвтэр». Хөх хот. 1981 он. 179—180-р тал.
8. Хуасай Дугаржав «Монголын нууц товчооны харгуулан хянасан дэвтэр. Хайлаар. 1984 он. 246—247-р тал.
9. Дорногив «Шинээр орчуулж тайлбарласан Монголын нууц товчоо». 1978 он. 261—252-р тал.
10. Баяр «Монголын нууц товчоо» (гутгаар дэвтэр) 1980 он. 1335, 1336, 1339, 1356-р тал.
11. Элдэгтэй Ардажав «Монголын нууц товчооны сийрүүлэл, тайлбар» 1986 он. 883, 884, 890-р тал.
12. Их мянгадан Иринчийн сэргээлт «Монголын нууц товчоо» Хөх хот. 1987. 261, 265-р тал.
13. Мансан «Шинээр орчуулж тайлбарласан Монголын нууц товчоо» Хөх хот. 1985 он. 373, 376-р тал.
14. Ту Жин «Монголын түүхэн тэмдэглэл» III боть. 30—32-р тал.
15. Товуу «Уйгаржин сонгол үсгийн дурсгалт бичгүүд» Бээжин. 1983 он. 15, 25-р тал.
16. М. Ядамжав «Монгол уран зохиолын түүхэн яриа» Тайвань. 30-р тал.
17. Сэцэнцогт «Монгол үсгийн яагуурын толь» Хөх хот. 1988 он. 75, 2266-р тал.
18. Х. Пэрлээ «МНТ-ны газар усны нэрийн тухай урьдчилсан мэдээ» «Монгол хэл бичиг» сэтгүүл. 1957. № 1. 82, 91-р тал.
19. Рашид-Ад-дин «Судрын чуулган» I боть, 2-р дэвтэр. Бээжин. 1983 он. 318, 352, 431-р талууд.

Б. Намжилов

К ВОПРОСУ О ВОЕННОЙ ТЕРМИНОЛОГИЧЕСКОЙ ЛЕКСИКЕ В «СОКРОВЕННОМ СКАЗАНИИ»

«Сокровенное сказание» (1240) (1)-важный источник для изучения состояния военной терминологической лексики монгольского языка XIII в. В нем содержится значительное количество терминов-наименований воинов, частей и подразделений войска, оружия и военного снаряжения, тактических способов действий. Ценность источника и в том, что он дает представление об особенностях и важнейших понятиях военного искусства древних монголов. Некоторые термины «Сокровенного сказания» зафиксированы также в таких источниках, как «Монгольский словарь Мукаддимат-ал-Адаб» (2), различные документы XIII—XIV вв (3).

В настоящей статье рассматривается ряд терминов лексико-семантической группы с опорным словом *cerig*, принадлежащих к числу наименований войска и его частей. Учитывая, что речь идет о древнемонгольском языке, под словом «термин» мы подразумеваем слово в функции наименования понятия военного дела.

К древнейшему слою военных терминов монгольского языка относится слово *cerig*. Санскритское происхождение его установлено Б. Я. Владимирцовым: «Скр. *ksatrika* согд. *ysort'k* «царский» уйг. *ksatrik carik* монг. письм. *carik carig cerig* совр. монг.-письм. *cerig* халх. *церік* «воин, солдат, войско» (4: 136). «В древнетюркском словаре отмечено» *cerig* 1. (скр. *ksatrika*) войско» (5: 144).

«Сокровенное сказание» и другие источники фиксируют слово в форме единственного (*cerik cerig*) и множественного числа (*ceri'ut ceri'ud cerigud*) с обобщенным значением «войско», «вооруженная сила». Например: *cerik e'uscu*-поднял войско (§ 141 «С.с.»); *cerik bokleju*-усилил войско (§ 251 «С.с.»); *ceri'ud qari'ulju*-отозвали войско (§ 248 «С.с.»); *mongqol ceri'ut* монгольское войско (МЭЕ, с. 141); *cerigud-iyen jasaju-*

построили свое войско (МР, с. 308); *cerigi jasaba qatquldu-quyin tula* выстроили войско для сражения (МСМА, с. 132); *cerig eribe* просил войско (МСМА, с. 132).

В лексико-семантическую группу с опорным словом *cerig* входят близкие по значению или находящиеся между собой в различных семантических отношениях слова. В синонимические отношения могут вступать производные от *cerig* сочетания *cerig-un gu'un-e*, *cerik haran* в значении «служивые люди», «ратные люди», «войсковые люди». Например: *cerig gu'un-i qoro'esun-tur bu ha'ulqatqun* не загоняйте служивых людей на звериных облавах (§ 199 «С.с»); *esergun-ece cerik haran qataraju hergiju gurcu ireju*-навстречу им скажут, озираясь кругом, ратные люди (§ 100 «С.с»). Вместе с тем, каждое из этих синонимических сочетаний имеет свои оттенки значения. Отличия в семантическом плане *cerik haran* обусловлены значением слова *haran* «простолюдин». В эдикте Мангала (1287 г) *cerik haran* как отмечает Н. Н. Поппе, противопоставляется *ceri'udun poyad-da* «военным командирам», «командирам (нойонам) войска». Сочетание *cerik haran* означает «простые воины», «воины из простолюдинов», т. к. термин *haran* имеет несколько более узкое, специальное значение людей угнетенного класса в составе *irgen* (6. 104).

Термин *cerig*, как наиболее общее наименование войска, образует такие производные термины-наименования частей войска, как *bara'un qar-un ceri'ud*-войско правой руки, *jewu qar-un ceri'ud*-войско левой руки (7. 312), *qol cerig*-войско центра, а также термин *yeke cerig*-все войско, великое войско. В значении «войско центра» может функционировать и составная часть сочетания *qol cerig* термин *qol*, например: *mapaqar qatqulduya ke'eju usuju gol-tur neyilen* *qopoba*-в ожидании завтрашнего боя отступили на ночлег к войску центра (§ 142 «С.с»).

Термин *gol* часто употребляется в сочетании со словом *gol* в значении «великий» например: *minqan turqan turqa'ud gejige bida yeke qol dobtulai* *je*-позади тысячи турхаутов пойдем мы, Великое войско центра (§ 170. «С.с»); *yeke qol-tur gurcu Senggum-un enggesge qacar usumaqar qarbuqsan-u tula mongke tenggeri-dee e'uden jilo'a negekdebei*-когда ты продвинулся до Великого войска центра, то стрелою-учумах ранил в щеку румяного Сангума. Поэтому Вечное небо открыло нам двери и путь (§ 208 «С.с»).

Боевой порядок всего войска (*yeke cerig*), как правило, состоял из центра (*qol*), правого крыла (*bara'un qar*) и ле-

вого крыла (jewun gar). Кроме этих основных элементов в боевой порядок входили авангард и резерв. В функции наименования такого военного понятия, как авангард, в «Сокровенном сказании» зафиксированы два термина *alginci* и *taŋglai*. Например: *olon dayintur alginci ha'ulju*-на многих врагов устремляться в авангарде (§ 123. «С. с»); *jebe Guyigunek-ba'atur qoyar-i taŋglai ilebei*-выслал далее авангард под командою Чжебе и Гунгунека (§ 247. «С. с»).

Рассмотрим подробнее термин *alginci*. Термин употребляется в сочетании с глаголом *ha'ulqu-* 'гнать, преследовать, бежать, скакать' (8. 590). Например: *ger-tur-iyen guru'et aganar de'u-ner kelele-(e) duju morilaba mun bodoncar-i alginci ha'ulqaba*-воротясь домой, посовещались они с братьями и выступили в поход. Передовым-наводчиком пустили самого же Бодончара (§ 37). «С. с:» пер. С. А. Козина). Примечательно, что автор летописи и «Алтан тобчи» Лубсанданзан заменяет сочетание *alginci ha'ulqaba* на слово *uajarsilaуulju* велев... проводить, сделав проводником (9. 16). Вероятно, термин *alginci* был не очень понятным для него в данном контексте. Военное значение терминологического сочетания *alginci ha'ulqacu* сохраняет в последующем его вторая часть-*ha'ulqacu*. В XVII—XVIII вв слово *uulya uuly-a* означает «грабеж, похищение, добыча» (Ковалевский, т. I, с. 338), «грабеж, разграбление, военная добыча; нападение, передовой отряд войск; легкий отряд войск, составляющий авангард (Голстунский, т. I, с. 149).

«Сокровенное сказание» фиксирует термин в сочетании с глаголом *talbi* например: *alginci tammasin talbiju*-поставив разведчиков-алгинчинов и воевод-баскаков-танмачинов (§ 273. «С. с:» пер. С. А. Козина); *alginci talbiju-harban quru'un kimal inu ha'utala a'ulas metu balaqat-tur abari'uluуa*-вот поставлю-ка тебя разведчиком-алгинчином да велю тебе карабкаться на городские стены, словно на горы, пока ты не облупишь себе ногтей на всех десяти пальцах (§ 276. «С. с.» пер. С. А. Козина).

Можно предположить, что первоначально основным военным значением термина *alginci* было «разведчик, проводник». Так, вероятно, называли воина или группу воинов, на которых возлагалась задача разведки неприятеля. Они всегда действовали впереди войска, отсюда, вероятно, и значение «передовой». Впоследствии наименование *alginci* переносится на передовой отряд войска, в задачу которого входит разведка.

Для уточнения значения термина *alginci* рассмотрим ряд

примеров. В § 193 «Сокровенного сказания» говорится о событиях, происходивших примерно за сутки до сражения войска Чингисхана с найманами. Выступив в поход, Чингисхан высылает Чжебе и Хубилая: quluqana jil jun-u teri'un sarayin harban jirwa'an udur hula'an tergel-e tuq sacu'at morilarun kelüren o'ede jebe Qubilai qoyar-i algincilaju yabu'at Sa'arike'er-i guru'esu Kangqar-qan-u teri'u-te Naiman-u qara'ul tede aju'u bidanu qara'ul-a huldelduju-Выступив, по окроплении знамени, 16-го числа первого летнего месяца, в красный день полнолуния Мыши (1204), он послал передовыми-алхумчинами Чжебе и Хубилая вверх по реке Келурену. Достигли Саарикеере где в истоках Канхархи оказался уже Найманский караул. Начались столкновения караул... (§ 193. «С.с.» пер. С. А. Козина).

Основная задача передового отряда под командою Чжебе и Хубилая состоит в разведке. Этот передовой отряд высылав от себя караулы, именно они первыми сталкиваются с неприятельскими караулами. Здесь alginci-элемент походного порядка.

В § 195 говорится о построении боевого порядка войска Чингисхана в сражении с найманами: Cinggis qahan o'esun algincilaju Qasar-i qol jasa'ulba Otcigin noyan-i kotot jasa'ulba-Сам Чингис-хан пошел в передовом отряде, Хасару поручил главные силы центра, а Отчигину поручил тыл с заводными конями (пер: С. А. Козина). Судя по данному фрагменту и дальнейшему содержанию § 195, боевой порядок войска Чингисхана состоит из трех эшелонов которые последовательно вводятся в бой. Первый эшелон-alginci. Он, в свою очередь, также состоит из трех эшелонов, последовательно вводимых в бой. В состав alginci входят: 1. эшелон-это две пары: Чжебе и Хубилай, Чжельме и Субетай, которые со своими воинами гонят перед собой найманский караул; 2. эшелон-это отборные части войска Чингисхана Урууты и Манхуты; 3. эшелон-это уже сам Чингисхан со своими телохранителями.

Вслед за alginci в бой вступает второй эшелон-qol войско центра, которое возглавляет Хасар. Третий эшелон войска-kotot тыл во главе с Отчигином вступает в бой последним. Такое построение боевого порядка отвечало замыслу боевых действий: qaraqana yorcil yorciju na'ur bayuildu'a bayuilduju bayuilduju si'uci qatquldu'a qatqulduya-будем двигаться «караганой» в положении «озеро» и биться «долотом» (§ 195 «С.с.»). Исследование Ш. Гаадамбы, в котором детально расс-

матриваются древние термины-наименования способов действий войска, содержащиеся в данном фрагменте, позволяет раскрыть замысел боя: ...-будем двигаться, рассредоточившись на множество мелких групп, по большому пространству, чтобы запугать противника числом, и, сосредоточившись, ударим разом в одно место, стремительно пробьем его ряды, расширяя затем прорыв в стороны и глубину новым своими силами (10.112—125).

Состав *alginci* в сражении с найманами свидетельствует о том, что данный термин имел также значение «передовая часть войска в бою», «первый эшелон боевого порядка войска». Таким образом, в зависимости от контекста термин служил для обозначения различных военных понятий.

Рассмотрим термин *manglai*. В военном значении слово *manglai* используется как наименование авангарда, передового отряда войска. Содержание военного понятия поясняет «Сокровенное сказание»: Cinggis qahan altan Qucar Daritai qurban-i manglai yabu'ulba. Ong qan Senggum jaqa-qambu Bilge-beki qurban-i manglai yabu'ulbai ede manglan-aca urugsi basa qara'ul ilerun Enegen-guiletu-de niken sa'urin qara'ul talbibai te'un-u cinana cekcer-e niken sa'urin qara'ul talbi'ulbai te'unu cinana ciqurqu-da niken sa'urin qara'ul talbi'ulbai-В авангард Чингисхан отрядил Алтана, Хучара, Даритая. Ванхан отрядил в авангард Сангума, Чжаха-Гамбу, Билге-беки. Эти авангарды выслали от себя вперед караулы: один неподвижный караул выставили в Энегенгуйлету, за ним дальше один неподвижный караул на Гекчере, за ним в Чихурху выставили еще один неподвижный караул (§ 142 «С.с.»).

В данном фрагменте раскрывается структура *manglai*. Авангард, выдвигаясь навстречу неприятелю, в первую очередь высылает вперед караулы, причем каждый караул на определенную глубину. Вестовой с самого дальнего караула, о чем говорится далее в § 142, сообщает о появлении противника. Принимается решение выдвинуться ему навстречу для захвата пленного. Допрос пленного позволяет выяснить состав передовых сил противника. Выполнив свою задачу *manglai* возвращается к главным силам.

Термин *manglai* в сочетании с глаголом *yabu*-употребляется в значение «идти в авангарде», например: ede dorbn Jamuqa-yin manglan yabuju'ui-эти четверо идут у Чжамухи в авангарде (§ 142 «С.с.»). Здесь термин зафиксирован во множественном числе. В сочетании с глаголом *ile*-передает значение

«выслать авангардом», например: *manglai ilebei*-выслал авангардом (§ 247. «С.с.»).

Глагол *manglaila*-зафиксирован в значении «иметь в авангарде», «назначить в авангард», например: *dayin jirgin-i manglailaju*-неприятель, имея в авангарде Чжуркинцев: (§ 247 «С.с») *simayı manglailaya*-тебя назначим в авангард (§ 171 «С.с.»); в сочетании с глаголом *jas* также передается значение «назначить в авангард»: *serik bokleju Hula'an degelen-i manglailan jasaju*-усилил войско и назначил в авангард Улаан-дегилена (§ 251 «С.с.»). С глаголом *qatquldu* употребляется в значении «сражаться впереди», «сражаться в бою в передовом отряде войска» например: *jurcedei ugulerun Cinggis qa'an-u emune ba Uru'ut Mangqut manglailan qatquldusu ke'eju'ui teyin ke'et Jurcedei Quyildar qoyar Uru'ut Mangqut-iyar-iyen Cinggis qa'an-u emune jasaju bayyibai*-Чжурчедай говорит: «Перед лицом Чингисхана будем сражаться впереди мы оба, Урууты и Манхуты». С этим словами Чжурчедай и Хуилдар выстроили перед Чингисханом своих Уруутов и Манхутов (§ 171 «С.с.»).

Рассмотрев термины *alginci* и *manglai*, можно сделать вывод о том, что синонимические отношения, в которые они вступают в значении «авангард, передовой отряд», обусловлены, в частности, таким экстралингвистическим фактором, как становление военных понятий в русле развития военного дела. Недостаточная дифференциация военных понятий сказывается на их наименованиях. Одно и то же слово может означать разные по сути понятия, а одно понятие выражаться разными по исходному значению словами. Исторически термин *manglai* сменяет термин *alginci*. В значении «авангард» он зафиксирован в старописьменных источниках XVII-XIX вв., функционирует и в системе современной монгольской военной терминологии.

В группе терминов-наименований войска и его отдельных частей можно выделить слова, которые семантически противопоставлены друг другу. Это *alginci-kotot*, *manglai-gejige*. Слово *kotot* (11. 319) в функции наименования одного из элементов боевого порядка, имело значение «арьергард, задний отряд войска, в котором находились семьи воинов, их имущество, заводные кони стада и т.д». Слово *gejige* в «Сокровенном сказании» в военном значении употребляется ситуативно в значении «тыл, заднее войско». В классическом старописьменном языке слово *gejige* в сочетании со словом *se-*

гиг функционирует как военный термин *gejige-yin cerig*- «арьергард, заднее войско».

Следует отметить, что и само опорное слово рассматриваемой лексико-семантической группы не выпадает в последующие века из системы военной терминологии. Лексиконы и источники XVII—XIX вв. фиксируют производный термин *cerigleku* 'выступать в поход', 'идти на войну': новые устойчивые сочетания: *cerig qurıyaqu*- 'собирать, стягивать войска, трубя в трубы, после сражения: *cerig bolıyaqu*- 'сделать солдатом, ссылат за преступление в пограничные гарнизоны на казенные работы' и т. д.

Лексико-семантическая группа термина *cerig* значительно расширяется за счет новых понятий военного дела. Например: *cerig-yin erdem* 'военное искусство', *buıci cerig*- 'пушкарь', 'артиллерист', 'канонир'. Увеличивается и количество терминов данной группы, относящихся к числу наименований войска и его частей, например: *jırumtu cerig*- 'ополчение', 'войско, снаряженное на общественный счет'; *tus sakıqu cerig*- 'пограничная стража'; *tursiyul cerig*- 'разведывательный отряд войска'; *sergeyilegsen cerig*- 'сторожевое войско'; *piyusa cerig*- 'скрытое в засаде войско', 'засада'; *odugeku cerig*- военный отряд, посланный для завлечения неприятеля и т. д.

Изменения в составе рассматриваемой лексико-семантической группы обусловлены развитием военного дела, появлением новых понятий в этой области. Диахронные исследования подобных лексико-семантических групп могут способствовать прояснению особенностей и закономерностей процесса становления системы военной терминологии классического старописьменного языка. Эти исследования весьма актуальны для исторической лексикологии монгольского языка, полезны в деле изучения военного искусства древности и средневековья.

1. Козин С. А. Юань-чао-би-ши. Сокровенное сказание. Монгольская хроника. 1240 г., т. I, М.-Л., 1941; Ligeti L. Histoire secrete des Mongols. Par Louis Ligeti. Budapest, Acad. kiado. 1971. (С, с)
2. Поппе Н. Н. Монгольский словарь Мукаддимат-ал-Адаб. ч. 1—2., «Труды Института востоковедения», М.-Л., 1938, т. 14. (МСМА)
3. Ligeti L. Monuments preclassiques. Par Louis Ligeti. Budapest. Acad. kiado (MP); Ligeti L. Monuments en ecriture 'phagspa. Pieces de chancellerie en transcription chinoise. Par. Louis Ligeti. Budapest. Acad. kiado. 1973 (МЕЕ).
4. Владимирцов Б. Я. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика. Л., 1929 г, с. 136.
5. Древнетюркский словарь (Ред. В. М. Наделяев и др.). Л., 1969, с. 144.
6. Поппе Н. Н. Квадратная письменность. История монгольской письменности. М.-Л., 1941, т. I, с. 104.
7. Примечательно, что в классическом старописьменном языке наряду с указанными терминами употребляются barayun mürü-ylн cerig, jegun mürü-ylн cerig. См. Injannasi. Köke sudur. terigun debter. Kökeqota 1957, с. 312.
8. Ср. то. ayulyacin-военные курьеры, гонцы (Козин С. А... с. 590),
9. Ср. ger-lur-iyen kürcü aq-a-par deguu-ner-luge eyetulduju mun Bodoncar-i yajarcilayulju (Ligeti L. Histoire secrete des Mongols Texte incorpore dans L' Altan toci. Budapest. Aca. kiado. 1974., с. 16)
10. Гаадамба Ш. Монголын нууц товчооны зарим нэр томъёоны учир. Нууц товчооны нууцаас. Улаанбаатар, 1976, с. 112—125.
11. Ср. Древнетюркск. kot зад, задняя часть. (Словарь Мухмуда Кашгарского, 1072—1074 гг). Древнетюркский словарь..., с. 319.

В. И. Рассадин

ОХОТНИЧЬЯ ТЕРМИНОЛОГИЯ В ЯЗЫКЕ «СОКРОВЕННОГО СКАЗАНИЯ»

Самым крупным письменным памятником языка средневековых монголов безусловно является «Сокровенное сказание монголов» 1240 г.* Поскольку этот памятник повествует о жизни и быте, хозяйстве не только степных кочевых, но и лесных охотничьих монгольских племен, постоянно занимавшихся как охотой, так и рыболовством, что хорошо видно на примере детских лет Темучина (впоследствии Чингисхана) мы находим в нем довольно разнообразную и детализированную охотничью и рыболовческую терминологию.

В данной статье хотелось бы проследить, насколько широко нашло отражение в языке «Сокровенного сказания» (в дальнейшем СС) занятие средневековых монголов охотой.

Судя по терминам, представленным в СС, средневековые монголы знали несколько разновидностей охот. Они занимались как индивидуальной, так и облавной охотами, о чем говорят, например, слова из СС: **горээлэ** «охотиться», **горуэн** «звериная охота», **горуэлучин** «занимающийся звериной охотой», **аба** «облава», «облавная охота», **абала** «охотиться облавой, устраивать облавы на зверей». О наличии разнообразных видов охот целевого назначения свидетельствуют термины **булугачин** «охотник на соболей, соболевщик», **кэрэмучин** «белковщик», **тарбагачила** «охотиться на тарбаганов». Термины же **пуркала** «ловить силками», **марийа** «выслеживать, подкрадываться», указывают, что монголы в то время уже использовали наряду с индивидуальной целевой охотой и облавами также добычу дичи ловчими петлями и скрадом.

* Для выборки материала мы использовали интерпретацию и перевод текста, выполненные С. А. Кузиным (1), а также словарь к «Сокровенному сказанию», составленный Эрихом Хэйнишем (2).
.. Здесь и далее материал из памятников по техничским причинам приводится написанным современным бурятским алфавитом.

Многие из этих терминов, поскольку носят общемонгольский характер, дожили до наших дней и сохранились в языках современных монгольских народов, например, халха-монгольском бурятском. Ср., х.-монг. **гөрөө** «охота», **гөрөөч** «охотник», **гөрөөл**; = бур. **гүрөөл** «охотиться»; х.-монг. **ав**, бур. **аба** «облава, облавная охота»; х.-монг. **авла-**, бур. **абал** «устанавливать облавную охоту», бур. **булгаша** «охотящийся на соболя»; х.-монг. **тарвагачла**, бур. **тарбагашал** «охотиться на тарбаганов»; х.-монг. **хэрэмч**, бур. **хэрмэшэ** «белковщик, охотник на белок»; х.-монг. **урхил**, бур. **урьхада** «ловить силками»; х.-монг. **мяраа**, бур. **маряа** «подкрадываться, скрадывать».

Знали монголы эпохи «Сокровенного сказания» и охоту с ловчими птицами, о которой не раз рассказывается в памятнике и о наличии которой свидетельствуют термины **карчигай** «ловчий сокол», **шинкор** «кречет», **чаган шинкор** «белый сокол», **оорку шибאוун** «ловчая птица» **карчигайту** «соколиный охотник», **шибаоура**, **карчигай оор** «пускать сокола», **шибаоулакуй** «сококлиная охота», **шибаоулалду** «вместе охотиться с соколами». Такое разнообразие терминов говорит о распространенности и популярности соколиной охоты в средние века у монголов.

В современных халхаском и бурятском языках подобная терминология вышла из массового практического употребления, поскольку сам вид охоты с ловчими птицами стал весьма редок. Х.-монг. **шувуу**, бур. **шубуун** означают теперь просто «птица», в то время как в средние века это была скорее «ловчая птица, сокол». Возможно, что это было эвфемистическое название, ибо наряду с ним существовали слова **карчигай** «сокол» и **шинкор** «кречет». Сейчас х.-монг. **харцага**, **харцгай**, бур. **харсага** означают «ястреб», а для обозначения сокола, кречета употребляются х.-монг. бур. **шонхор**. Вместо **шибаоура** «пускать сокола», **шибаоула** «охотиться с соколом» сейчас используется выражение **шонхороор агна-**, что говорит уже об утрате этой специфичной терминологии в современных монгольских языках.

О важности и значимости охоты для монгольских племен той эпохи свидетельствует обилие терминов для обозначения различных видов дичи, как, например, **горээсун** «дичь, дикий зверь», **када-ин горээсун** «горный зверь», **ороа горээсун** «тенистый зверь», **кээр-ун горээсун** «степной зверь, степная дичь», **кун-о горээсун** «норные, пещерные звери». Средневековому термину **горээсун** «дичь» соответствуют х.-монг. **гө-**

рөөс, бур. **гүрөөһэн**, но значения их более узкие: в халхаском это слово означает «антилопа», в бурятском — «дикая коза, косуля». Остальным терминам аналогий нет. Однако, о том, что и в бурятском языке слово **гүрөөһэн** имело когда-то более широкое значение и обозначало не только козулю, лань, антилопу, но и вообще любое дикое (обычно крупное) животное, свидетельствуют бытующие в современном бурятском языке термины **хара гүрөө эн бурый медведь** (букв. «черный зверь»), **сагаан гүрээ эн белый медведь** (букв. «белый зверь»), **эрээн гүрөөһэн «тигр»** (букв. «пестрый зверь») **хүн гүрөөһэн** — в мифах это людоед, современное значение — снежный человек.

Очень многообразны и многочисленны названия конкретных диких животных и птиц, представлявших объект охоты средневековых монголов. В «Сокровенном сказании» зафиксированы, например, следующие анималистские термины: **названия пушных зверей: булуган «соболь», кэрэмун «белка», унэн «горностай», солонгга «ласка», тарбаган «сурок», тао-лай, та'улай «заяц», калиун «выдра»; названия хищников: чина, чино «волк», гэнду чино «самец волка», джозбури «шакал, барс «барс, тигр», арслан «лев», унэгэн «лиса»; названия копытных зверей; кандагай «лось», бугу «олень», Джо бугу «трехлетний олень», укулджа «дикий баран», марал «самка оленя», куралтук «дикая коза», малая пятнистая козуля», кулан «дикий осел, кулан».**

Если обратиться к современным халхаскому и бурятскому языкам, с которыми мы сравниваем весь материал, то найдем в них соответствия почти всем перечисленным выше средневековым названиям промысловых животных. Ср., например, х. -монг. **булга**, бур. **булган «соболь»** х. -монг. **хэрэм**, бур. **хэрмэн «белка»**; х. -монг., бур. **үен «горностай»**; х. -монг. **солонго**, бур. **һолонго «колонок»**; х. -монг. **тарвага**, бур. **тарбаган «сурок»**; х. -монг., бур. **туулай «заяц»**; х. -монг. **халиун**, бур. **халюун «выдра»**; х. -монг. **чоно**, бур. **шоно «волк»**; х. -монг. **гэндүү «барс, самец леопарда»**, бур. (тунк., окин) **гэндэ, гэндэ булган «самец соболя»**, бур. (агин.) **гэндэн жамса**, (хорин.) **гэндэн убша «волк»**; х. -монг. **цөөвөр чоно «шакал»**, бур. **сүүбэн шоно**, бур. (окин.) **сөөвөри**, (тунк.) **сүүбэр «альпийский красный волк; шакал»** х. -монг. **бар, барс «тигр»**, бур. **бар, барас «барс, тигр»**, х. -монг. **арслан**, бур. **арсалан «лев»**; х. -монг. **үнэг**, бур. **үнэгэн «лиса»**; х. -монг., бур. **хандагай «лось»**; х. -монг., бур. **буга «самец изюбра»**; х. -монг. **угалз «самец архара (горного барана)»**; х. -монг., бур. **ма-**

рал «марал»; х. -монг., бур. **хулан** «дикий осел, кулан»; бур. **хуурай** «самка косули».

В отдельной работе (3) нами специально рассматривалась анималистская терминология современного бурятского языка в сравнительно-историческом аспекте и доказывался ее в основном общемонгольский характер. Там были подробно рассмотрены и вышеприведенные термины, тоже имеющие в общем-то общемонгольский характер.

Охотились средневековые монголы и на различную пернатую дичь о чем говорят разнообразные названия этих птиц, зафиксированных в «Сокровенном сказании», например; **боровая и полевая пернатая дичь**; **каркиру** «куропатка», **хар хуру** «дикая курица, фазан»; **водоплавающая дичь**; **ногосу**, **нокосун** «утка», **анггир** «турпан», **соно**, **борчин** соно-вид утки, **каранбай** **нокосун** «селезень», **галаоун** «гусь», **хун** «лебедь».

Нам уже приходилось писать (4) об общемонгольском характере терминов х. -монг. **хур**, бур. **хура** «тетерев»; х. -монг. **галуу**, бур. **галуун** «гусь»; х. -монг. **нугас**, бур. **нугаһан** «утка»; х. -монг., бур. **ангир** «турпан». Сюда же можно отнести и х. -монг., бур. **хун** «лебедь».

Термину **соно** «вид утки» соответствуют х. -монг. **цоно нугас** «кряква», бур. **оно** «чирок-скистунук». При этом в бурятских говорах слово **ноно** имеет другие значения, например, в боханском говоре это «селезень», в тункинском-«утка» (здесь это слово бытует вместо литературного бурятского **нугаһан** «утка»), в окинском-«кряковый селезень, утка». Подробнее об этом слове см (4, с. 14).

Вызывает интерес х. -монг. **боржин нугас** «гусыня» и бур. **боржон** «утка (самка)», которые можно сопоставить с **СС борчин соно** - «вид утки». При это в основе данного слова, вероятно, лежит прилагательное **бор боро** «серый», снабженное древнейшим монгольским аффиксом-жин, обозначающим некогда существа женского рода (пола). Подробнее об этом аффиксе см (5, с. 28—29). Терминам же **СС каркиру** «куропатка» и **каранбай** **нокосун** «селезень» соответствий отыскать не удалось, хотя в бурятском языке куропатку называют отдаленно похожим словом **торхируун**.

В тексте «Сокровенного сказания» встретилось немало слов, обозначающих оружие, орудия, приспособления, использовавшиеся средневековыми монголами при различных видах охот. Это, например, лексемы **нумун** «лук», **сумун** «стрела», **джида** «копье», **Джэбэ** «пика», **китугай** «нож», **сукэ** «топор»,

чалир «пешня, с помощью которой нащупывали тарбаган в норе, ударяя сверху», урука «ловчая петля, силки».

Все эти термины хорошо сохранились в современных монгольских языках и продолжают в них широко бытовать. Ср., например, х.-монг. **нум**, бур. **номо** «лук»; х.-монг. **сум**, бур. **хомо** «стрела»; х.-монг. **жад**, бур. **жада** «копье, пика, штык» рогатина»; х.-монг. **зэв**, бур. **зэбэ** «острие, наконечник (стрелы, копья)»; х.-монг. **хутга**, бур. **хутага** «нож»; х.-монг. **сүх**, бур. **һүхэ** «топор»; х.-монг. **царил**, бур. **салир** «лом, пешня»; х.-монг. **урхи**, бур. **урьха** «силок, петля». При этом только термин **джэбэ** «пика» изменил свое значение, остальные же хорошо сохраняют и семантику, будучи общемонгольскими.

О широком использовании луков и стрел говорит разнообразная терминология, относящаяся к этому виду оружия, которая представлена в языке «Сокровенного сказания». Ср., например, названия типов луков и стрел, встретившиеся помимо общих терминов **нумун** «лук», **сумун** «стрела»; **аланггир пумун** «деревянный лук», **годоли**, **йори** «свистун-стрела», **арча манглайту** **годоли** «стрела с наконечником из можжевельника», **мусу** «деревко стрелы», оно «зарубка у стрелы», оно-ту **сумун** «стрела с зарубкой», **каткурасуту** **сумун** «стрела из дикого персика», **ангкуа**, **кейбур**, **учумак**, **одора** **одола** виды стрел, **кола-ийн** **оорчак** «дальная стрела хоорцах», **ойраин** **одола** «ближняя стрела одола», **шиба-ийн** **сумун** «шальная стрела».

В бурятском языке из всех этих терминов сохранились лишь **годли** (устаревшее) «стрела с роговым или деревянным наконечником» и оноо «зарубка у стрелы». В халхаском представлены: **алангир нум** «особы род лука», **годил** (устар) «стрела», оноо «зарубка у стрелы». Кроме того, в бурятском языке бытует специфический термин **үүдхэ** «оперенная стрела».

Видимо, в связи с повсеместным распространением огнестрельного оружия, давно вытеснившего из охотничьего обихода лук со стрелами, забылась и бытовавшая в прошлом развитая терминология, относящаяся к луку и стрелам. О разнообразии всевозможной терминологии, связанной с этим видом оружия, свидетельствуют и некоторые глаголы, зафиксированные в «Сокровенном сказании»: **сумуд-ийан уру** «очищать терпугом стрелы, править стрелы», **сумубан самба** «вынуть стрелу из колчана», **карбу** «стрелять из лука», **мэрэ** «стрелять», **годолиду** «подстрелить детской», **дэли** «натягивать лук». Из всех этих терминов сохранились лишь х.-монг. **ура** «царапать (ногтями)», **харва** и **годилдо** «стрелять из лу-

ка», при этом последнее слово устаревшее. Глагол дэлэ означает сейчас в халхаском «размахивать руками», а мэрэ «грызть». В бурятском языке предствалены харба «стрелять из лука», дэли «натягивать лук». Глагол мэрэ здесь тоже означает «грызть», но, возможно, средневековый глагол мэрэ «стрелять» лежит в основе общемонгольского слова мэргэн «меткий, искусный стрелок», то есть мэргэн мэрегэн мэрэ «стрелять».

О разнообразии терминов, относящихся к луку, свидетельствуют и названия типов колчанов, зафиксированные в памятнике: кор «колчан», уйлсун кор «берестяной колчан», утан кор «колчан из ивы», давчиту кор «колчан с крышкой». Бурятской язык сохраняет однокоренные со средневековым кор названия колчана; хормого, хормоонго, в халхаском хормого «колчан».

Подводя итоги проведенному нами выше краткому анализу состава охотничьей терминологии, представленной в одном из крупнейших памятников монгольского языка средних веков, следует отметить, что у монголов рассматриваемой эпохи охотничий промысел был довольно развит и играл значительную а у бедняков зачастую и решающую роль в их повседневной хозяйственной жизни. Рассмотренная терминология, носящая в основном общемонгольский характер, лишний раз убеждает в правильности вывода Б. Я. Владимирцова о том, что одним кочевым скотоводческим хозяйством монголы XI—XIII вв. прожить не могли; пищи не хватало. Недостаток этот восполнялся охотой на разнообразную дичь, а также рыболовством (6).

Таким образом, исторически довольно поздно вышедшие в степь и знавшие кочным скотоводством монгольские племена долго сохраняли черты «лесных», охотничье-рыболовческих племен.

1. **Козин С. А.** Сокровенное сказание. Монгольская хроника 1240 г. под названием... Юань чао би ши. Монгольский обыденный изборник. т. I. (Введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии). М—Л., Изд-во. АН СССР, 1941.
2. **Haenisch E.** Wörterbuch zu Mongol-un Niuca tobca'an (Yuan-ch'ao pi-shi). Yeheime Yeschichte der Mongolen. —Wiesbaden, 1962.
3. **Рассадин В. И.** К сравнительному изучению анималистской лексики бурятского языка. Языки и фольклор народов Севера. Новосибирск. Наука, 1981. с. 97—119.
4. **Рассадин В. И.** Промысловая лексика в говоре окинских бурят. Дialectная лексика в монгольских языках. Улан-Үдэ. 1987. с. 13.
5. **Болд Л.** Орчин цагийн монгол хэлний дагавар. УБ., 1986.
6. **Владимирцов Б. Я.** Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм. Л. Изд-во. АН СССР., 1934. с. 39—40.

Ж. Сэржээ

ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ОНООСОН НЭРИЙН ЗАРИМ ОНЦЛОГ

Монгол хэлний үгсийн санг нэрийтгэл нэр, оноосон нэр гэсэн хоёр үндсэн хэсэгт хувааж болно. Нэрийтгэл нэрийг нь бид үгсийн үндсэн сан гэж нэрлээд түүнийг судалдаг ухааныг нь үгсийн сангийн судлал гэдэг. Харин оноосон нэрийн тухай ойлголт төдий л тодорхой бус байсаар өнөөдрийг хүрч ирлээ. Дэлхий дахины хэл шинжлэлийн сүүлийн үеийн хөгжилтийн дагуу хэл бүрийн оноосон нэрийг судлах ажил үлэмж өргөжиж, нэрзүй гэдэг хэл шинжлэлийн салбар буй болоод багагүй хугацаа өнгөрч байна. Эрдэмтдийн судалгаанаас үзвэл аливаа хэлний оноосон нэр нь нэрийтгэл нэрээсээ олон байдаг бөгөөд монгол хэлний хувьд оноосон нэрээр онцгой баян юм. Энд бид оноосон нэрийн бүх онцлогийг бүрэн хамарч ярих боломжгүй тул юуны өмнө оноосон нэр, нэрийтгэл нэр хоёрын үүрэг, тэдгээрийн харилцан холбогдох шинжийг нь тодруулан үзье.

1. Нэрийтгэл нэр нь бодит ертөнцийн тодорхой юм үзэгдэл, түүнчлэн тухайн зүйлийг өөртөө багтаасан хэсэг бүлэг юмыг ерөнхийд нь нэрлэн заана. (1: 18) Жишээ нь хүн, хүүхэд, нуур, уул, цэцэг, амьтан гэх мэт. Тэгвэл оноосон нэр нь тухайн нэрийтгэл нэрээр илэрч буй нэг төрлийн олон юмыг дотор нь бие биеэс нь ялгаж нэрлэн заана. Жишээ нь: Хүн гэдэг нэрийтгэл нэрээр илэрч буй олон хүнээс Дорж, Бат, Оюун гэх мэтээр тус бүрд нь ялгаж өгсөн нэр нь оноосон нэр болно. Иймд оноосон нэр нь нэрийтгэл нэрээ бодвол уг объектойгоо илүү нягт холбоотой. Үүнээс үзвэл нэрийтгэл нэр нь ерөнхий, оноосон нэр нь тусгай болж хоорондоо диалектийн ерөнхий тусгайн харьцаанд оршино.

2. Ямар ч нэрийтгэл нэр тухайн юмаа нэрлэн заахдаа бидний ухамсарт тодорхой төсөөлөл бий болгоно. Жишээлбэл: нарс гэсэн үгийг сонсоод бид улаан шаргал холтостой, мөнх ногоон навчит модны тухай төсөөлнө. Эдгээр шинж тэмдгүүд

нь нийлж тэрхүү модны тухай ухагдахууныг үүсгэнэ. Энэ ухагдахуун нь нарс гэдэг үгийн үгсийн сангийн утгыг бий болгонс. Ийнхүү тодорхой ухагдахууныг илэрхийлсэн ухагдахуунтай холбоотой байх нь нэрийтгэл нэрийн нэг гол шинж мөн. Тэгвэл оноосон нэр нь ухагдахууныг илэрхийлж, ухагдахуунтай шууд холбогддоггүй. Энэ тухай К. Маркс «Ямарваа нэг юмны нэр тэр юмны уг чанартай ямар ч холбогдолгүй. Хэрэв нэг хүнийг Яков гэж нэрлэдэг гэж би зөвхөн мэдэх ахул тэр хүний тухай чухам юу ч мэдэхгүйтэй адил (2: 107) гэж бичжээ. Иймээс үгсийн сангийн утгагүй нэрийтгэл нэр гэж хэзээ ч байхгүй, харин оноосон нэр үгсийн сангийн утга нь мэдэгдэхгүй байхдаа ч үүргээ саадгүй биелүүлж чаддаг байна. Тухайлбал: Жавзан, Пунцаг гэх мэтийн хүний нэр, Завхан, Хэнтий, Хэрлэн гэх мэтийн газрын нэрийг юу гэсэн утгатай, аль хэлний үг болохыг нь хүн бүр мэдэхгүй байсан ч гэсэн эдгээр нэр хүн болон газар усаа нэрлэх үүргээ саадгүй биелүүлсээр байна.

3. Нэрийтгэл нэр нь ухагдахууныг илэрхийлдэг тул өөртөө тодорхой мэдээллийг агуулдаг. Нэрийтгэл нэр нь тухайн объектоо нэрлэн түүний тухай мэдээлэл өгнө. Ийм учраас нэрийтгэл нэр нь аливаа юманд тохиолдлоор өгөгддөггүй, нэрийтгэл нэрийг өөрчилж сольж болдоггүй, хэн нэгэн хүний дур хүслээр өөрчилж болохооргүй тухайн хэлэндээ тогтвортой олон үеийн турш хэрэглэгдэнэ. Тэгвэл оноосон нэр нь тухайн нэрлүүлж байгаа юмандаа харьцах харьцааны хувьд тохиолдлын чанартай байх нь олонтаа бөгөөд тухайн юмаа нэрлэдэг, харин түүний тухай мэдээлэл өгдөггүй, өгсөн ч мэдээлэл нь хязгаарлагдмал шинжтэй байдаг. Жишээлбэл: Баяр, Цагаан, Лхагва гэх мэтийн хүний нэр нь уг хүнийхээ тухай тодорхой мэдээлэл өгч чадахгүйгээс эрэгтэй эмэгтэй хүүхэд насанд хүрэгсдийн алин болохыг ч мэдэх аргагүй юм.

4. Гарлынхаа хувьд нэрийтгэл нэр нь анхдагч, оноосон нэр нь хоёрдогч болно. Өөрөөр хэлбэл оноосон нэр бүхэн эх хэлнийхээ үг бүтэх хуулийн дагуу үг, бүтээвэр, үгийн нийлэмжээр бүтдэг. Гэвч оноосон нэр болон хэрэглэгдэж байгаа эдгээр үг, бүтээвэр, үгийн нийлэмж нь өөрийн үндсэн утгаа алдаж зөвхөн тухайн нэрлүүлж байгаа зүйлээ төлөөлсөн дохио болсон байдаг. Иймд хүний нэр, газар усны нэр зэрэг оноосон нэр болсон үг, үгийн нийлэмж нь бидний ярианы болон бичгийн хэлэнд өдөр тутам хэрэглэгддэг үгээс эрс ялгарна. Тухайлбал: Нармандах гэдэг хүний нэрийг хэлэхэд бидэнд өглөө болж нар мандаж байгаа байдал санагдахгүй зөвхөн Нармандах нэртэй нэгэн хүн санаанд буух жишээтэй юм. (3:

114—115) Түүнээс гадна нэр үг, тэмдэг нэр, үйл үг зэрэг ямар ч үг оноосон нэр болонгуут шууд нэршиж хэлний зүйн хувьд нэр үг мэт хэлбэржинэ. Гэхдээ нэрийтгэл нэр бүхэн оноосон нэр болоод байдаггүй. Ямар үг оноосон нэр болох нь ямар юмыг нэрлэх гэж байгаатай болон тухайн ард түмний зан заншил, ертөнцийг үзэх үзэл зэрэг олон зүйлтэй холбоотой байдаг. Хоёрдугаарт монгол хэлэнд байгаа олон мянган оноосон нэр маань өөр хоорондоо ямар харьцаатай оршдог, тэдгээрийн бие биетэйгээ адил хийгээд, бие биеэсээ ялгарах онцлог нь юу вэ? гэсэн асуудал гарна. Энэ талаар хийсэн зарим ажиглалтаас та бүхэнд толилуулья.

1. Аливаа хэлний үгсийн үндсэн сан байнга хувьсан хөгжиж байдгийн нэгэн адил оноосон нэрийн санч хувьсан хөгжиж байдаг. Ийнхүү олон зуун жилийн хөгжлийн явцад зарим оноосон нэрийн үндэс болсон нэрийтгэл утга нь суларч аажмаар мартагдахад хүрдэг. Үүнд тухайн хэлэнд гарсан авиаар зүйн хувьсал ч нөлөөлдөг., тухайн ард түмний нийгмийн байгуулал, соёлд гарсан өөрчлөлт ч нөлөөлдөг. Орчин цагийн монгол хэлэнд буй хүний нэр, газар усны нэр, од гаригийн нэр гэх мэт бараг бүх төрлийн оноосон нэрийн дотор аль хэлний, юу гэсэн үг болох нь мэдэгдэхгүй нэр тун олон тохиолддог нь үүнтэй холбоотой.

2. Оноосон нэр болон хэрэглэгдэж буй үгс үгсийн сангийн үндсэн утгаа алдаж дохионы чанартай болдог нь нэрийтгэл нэрээс ялгарах гол ялгаа гэж өмнө бид дурдсан. Гэхдээ энэ чанар нь монгол хэлний оноосон нэрийн бүх төрөлд адил бус байна. Жишээ нь: Хүнд нэр өгөхдөө ихэвчлэн бэлгэ дэмбэрлийг боддог бол газар усны нэр нь тухайн газар усны бусдаас ялгарах гол онцлог шинжийг нь тусгасан байдгаас үндэслэн газар усны нэрийн үндсэн утга нь нэрлүүлж буй уг газар усныхаа үндсэн шинж чанартай тохирч байдаг ажээ. Жишээлбэл: Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан суманд «Шувуун чулуут» гэдэг газар байна. Тэндхийн чулуун дотор шувуутай төсөөтэй, бүр нисэж яваа шувуу шиг чулуу ч олон байдаг ажээ. Төв аймгийн Эрдэнэсант суманд Улаанморьт гэдэг Ян хад бий. Энэ хадан дээр улаан өнгөөр нямбайлан зурсан морины зураг байдгаас тийнхүү нэрлэжээ. Дорноговь аймгийн Өргөн суманд «Хөөт» гэдэг жижиг толгой байдаг нь тэнд нүүрстэйгээс болж ийнхүү нэрлэгджээ. Ийм маягаар тухайн газрыг ургамлаар нь: Мойлт, Арцат, Улиастай, Яргайт, Хялганат; амьтнаар нь: Үнэгт, Хандгайт, Бугат, Тарвагатай; эрдэс баялгаар нь: Мөнгөт, Төмөрт, Эрдэнэт гэх мэтээр нэрлэсэн нэр маш олон юм. Тэгвэл хүний нэрэнд ийм шинж бараг

байдаггүй. Жишээлбэл: Төмөр гэсэн нэртэй хүн төмөртэй ямар ч холбоогүй, Цэцэг гэсэн нэртэй хүн цэцэгтэй ямар ч холбоогүй байдаг.

3. Газарзүйн хувьд нэг доор оршиж байгаа уул тал, гол горхийг нэг нэрээр нэрлэдэг, тухайлбал аль нэгийнх нь нэрээр бусдыг нь нэрлэдэг ёс монгол хэлэнд байна. Жишээлбэл: Хархираа гэдэг уулаас эх аван урсаж буй голыг өөр нэгэн нэрээр нэрлэхийн оронд Хархираагийн гол гэж нэрлэдэг нь оноосон нэрийн ялгах үүрэгт саад болохгүйгээр үл барам хэлний товч тодорхой байх зарчимд ч тохирч байна. Ийм нөхцөлд тухайн оноосон нэр маань уул, ус, талын алиныг нь нэрлэж байгааг тодруулахад дэвсгэр нэр нь зайлшгүй хэрэг болдог ажээ. Иймээс газар усны нэрэнд дэвсгэр нэр их хэрэглэгддэг байхад хүний нэрэнд хүний эшийн нэр бараг ордоггүй. Жишээлбэл: Төв аймгийн Заамар суманд Заамарын нурууны өмнө орших талыг Заамарын хөндий, Булган аймгийн Рашаант суманд Бадын гол урсаж өнгөрөх хөндийг Бадын хөндий, Төв аймгийн Дэлгэрхаан суманд Давст нуур, Давстын хөндий, Давстын худаг гэж байна. Түүнчлэн Ховдын Чандмань суманд Дөргөн нуурын баруун талыг Дөргөний хүрэн тал, Увс аймгийн Бөхмөрөн суманд буй Түргэний уулаас Түргэний гол эхэлдэг. Ийм жишээ маш олныг дурдаж болно. Ийм тохиолдолд тухайн нэр маань уулынх уу, усных уу гэдгийг тодруулахад дэвсгэр нэр нь зайлшгүй хэрэгтэй юм. Тэгвэл хүний нэрэнд ийм үзэгдэл гардаггүй.

4. Газар усны нэрийн бусад оноосон нэрээс ялгарах бас нэг онцлог нь бол нэг объект хэд хэдэн нэртэй байх буюу газрын нэрийн зарим нь ерөнхий, зарим нь ерөнхий доторх тусгай объектыг тэмдэглэсэн ерөнхий тусгайн харьцаатай байдаг явдал байна. Зарим жишээ авч үзье. Манай орны бүх нуруу, томоохон уулсын нэр ерөнхий нэр болж, түүний доторх уул, хяр, ам, бүхэн нь өөр өөрийн нэртэй байдаг гэж болно. Тухайлбал: Булган аймгийн Сэлэнгэ сумын нутаг дахь Бүтээлийн нуруунд Бодонт (1560 м), Чонот өндөр (1650 м), Номт өндөр (1720 м), Баян (1813 м), Шар манхтай (1598 м) зэрэг томоохон уулууд бий. Түүнчлэн нийслэл хотын өмнө талд орших Богд ууланд Цэцээ гүн, Баруун, Зүүн ширээ зэрэг оргилууд байхын зэрэгцээ тус бүрдээ нэртэй 30 гаруй амтай билээ. Мөн нэгэн гол усны эхэн хэсэг, адаг хэсэг өөр нэртэй байх нь элбэг. Жишээ нь: Завхан аймгийн Идэр сумын нутагт Идэр голын эхийг Жаргалант гэдэг, Булган аймгийн Гурванбулаг суманд Харуух голын эхний хэсгийг Тарнайн гол гэдэг. Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд Цагаан ус гэ-

дэг голын эх нь Цагаан салаа нэртэй. Манай алдарт Сэлэнгэ мөрний эхийг Дэлгэр Мөрөн гэдгийг нийтээр мэднэ. Хүмүүс нягт оршин суудаг, аж ахуйн үйл ажиллагаанд байнга ашиглагддаг газар нутгийг их нарийвчлан нэрлэсэн байдаг бол аглаг зэлүүд газрыг ерөнхийд нь нэрлэдэг ажээ.

5. Монгол хүний нэрэнд нэгэн айлын ах дүү хүүхдүүдийг хооронд нь адилтгаж Гантулга, Баттулга, Мөнхтулга, гэх юмуу Энхбаатар, Энхбат, Энхболд гэх мэтээр нэрлэдэг шиг Монгол газар усны нэрэнд нэг доор орших хэд хэдэн объектыг нэг нэрээр нэрлэн дотор нь баруун, зүүн, их, бага, дээд доод гэх мэтээр ялгасан нэр түгээмэл байна. Жишээлбэл: Их богд, Бага Богд, (Баянхонгор, Богд сум), Урд Тамир, Хойд Тамир (Архангай Батцэнгэл), Зүүн Тэрмис, Дунд Тэрмис, Баруун Тэрмис гэсэн гурван гол (Увс аймгийн Давст суманд) байна. Түүнчлэн Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр суманд Залуу-Үүр, Хөгшин-Үүр гэсэн хоёр гол байгаа жишээ олныг дурдаж болно. Энэ нь тухайн газар усны байрлалыг харгалзан цөөн нэрээр олон объект нэрлэх монгол хэлний нэг өвөрмөц арга юм.

6. Тус тусдаа хүний нэр болдог хоёр үгийг нийлүүлэн гураг дахь нэр үүсгэдэг арга монгол газар усны нэрэнд ч нэгэн адил хэрэглэгддэг ажээ. Тухайлбал: Бат, Болд гэсэн хоёр нэрээс Батболд гэдэг нэр үүсдэг шиг Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр суманд буй Хэвэн, Залуу үүр гэсэн хоёр голын нэрээр тэдгээр голын эхний сарьдгийг Хэвэн залуу үүрийн сарьдаг гэж нэрлэжээ. Мөн Чандмань зүрх гэсэн уулууд байдаг бол тэр хоёрыг нийлүүлэн нэрлэсэн Чандмань зүрх уул Архангай аймгийн Булган суманд бий. Мөн Ховдын Үенч суманд Нарийн, Нүцгэн гэсэн хоёр гол нийлж Үенч гол болдог. Ер нь монгол хэлэнд газар усны нэг нэрээс нөгөө нь үүссэн тохиолдол цөөнгүй байна. Зарим жишээ дурдвал: Таацын голын адагт үүссэн нуурыг Таацын цагаан нуур (Өвөрхангай Баруунбаян-Улаан сум) Шаргын голын адагт тогтсон нуурыг Шаргын цагаан нуур (Говь-Алтай Шарга сум) гэх мэтээр нэрлэснээс гадна 3—4 үгээр нэрлэсэн нэртэй газар усны нэрийг ажиглавал тэдний зарим нь мөн л газрын нэрээр тодотгол хийж үүссэн байх юм. Жишээ нь: Баянцогтын овоо уул (Сэлэнгэ, Орхонтуул сум), Бумбатын ногоон булуу уул (Сэлэнгэ Баруун бүрэн сум), Жаргалантын эхний Булуу уул (Завхан, Идэр сум) Цагаан толгойн нарийн хар нуруу (Ховд, Булган, Үенч сум) Шартолгойн овоот толгой (Өмнөговь Хүрмэн сум), Бөхмөрөнгийн Хар хөдөө (Увс Бөхмөрөн сум) гэх мэт. Түүнээс гадна тухайн газарт нэр оноон өгөлгүйгээр дэр-

гэдэх газар усны нь нэрээр байрлалыг нь заасан чанартай нэр ч цөөнгүй байгаагаас заримыг нь дурдвал: Хойд тэрхийн эхний нуруу (Завхан, Отгон сум) Унтаа ямаатын эхний нуруу (Архангай Хангай сум) гэх мэт.

7. Орчин цагийн монгол хэлэнд нэг төрлийн оноосон нэр, өөр төрлийн оноосон нэр болж дахин нэршиж хэрэглэгдэх үзэгдэл өргөн дэлгэрчээ. Тухайлбал: монгол хүний нэрэнд Алтай, Хангай, Хэнтий зэрэг уулын нэр, Хөвсгөл, Хяргас, Буйр зэрэг нуурын нэр, Орхон, Туул, Сэлэнгэ зэрэг голын нэр; Орос, Монгол, Төвд, Хасаг зэрэг үндэстний нэр, Буриад, Өөлд, Урианхай зэрэг ястны нэр, Монголжин, Боржигон зэрэг овгийн нэр, Наран, Саран, Од зэрэг од гаригийн нэр байдаг бол монгол газар усны нэрэнд Сампилын овоо (Завхан), Бадамжавын уяа, (Баянхонгор, Баян-Овоо сум), Амарсанаагийн агуй (Увс Давст сум), Дансрангийн дөрөлж (Завхан, Сантмаргац сум), Галсангийн гозгор (Сэлэнгэ, Сант сум), Донхойн хөндий (Завхан, Улиастай хот) гэх мэт хүний нэр, Монгол уул (Төв, Лүн сум), Монгол элс (Өвөрхангай Бүрд сум) Төвд уул (Завхан, Баянхайрхан сум), Дөрвөд даваа (Баян-Өлгий, Ногоон нуур сум) Хасагтын говь (Дундговь Өлзийт сум), Тангадын Хар уул (Говь-Алтай Тонхил сум) зэрэг үндэстэн ястны нэр, Боржигон тал (Төв Баянцагаан сум), зэрэг овгийн нэр, Наранбулаг (Сүхбаатар, Мөнххаан сум), Наран Саран уул (Сүхбаатар, Мөнххаан сум), Нарантолгой (Өмнөговь Манлай сум) зэрэг гариг одны нэрээс үүссэн нэр цөөнгүй ажээ. Ийнхүү монгол хэлний оноосон нэр нэрийтгэл нэр хоёр чанарын ихээхэн ялгаатай үгсийн сангийн бие даасан хэсгүүд болохын зэрэгцээ бие биеэс ихээхэн ялгаа бүхий янз бүрийн юмсыг нэрлэдэг оноосон нэр маань ч дотроо бас багагүй ялгаатай хэсгүүдэд хуваагдаж байна. Иймд монгол ард түмний түүхийнхээ турш бүтээж уламжлан ирсэн баялаг ондосон нэрийг тал бүрээс нь судалж эх орныхоо хэл шинжлэлд нэр зүйн ухааныг хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавагдаж байна.

НОМЗҮЙ

1. В. Д. Бондалетов. Русская ономастика. М. 1983
2. К. Маркс. Капитал. т. I. М. 1955
3. Ж. Сэржээ. Монгол хүний нэрийг судлахад дохионы хэрэглэх нь. Хэл зохиол судлал. XIII боть. УБ. 1979.

Б. Амаржаргал

**БАРУУН ХАЛХЫН АМАН АЯЛГУУНЫ ҮГСИЙН
САНГИЙН ХАРЬЦУУЛСАН ОНЦЛОГООС**

Халх аялгууг судлагч гадаад, дотоодын олон эрдэмтэн өнөөгийн халх аялгуугаар ярилцагчдын ярианд онцын ялгаа байхгүй, гол ялгаа нь авианзүйн талаар байгаа бөгөөд үгзүйн талаар цөөн байгааг тэмдэглэн авианзүйн чиглэлээр голлон судалгаа хийж судалгааны нэлээд ном бүтээл, өгүүлэл нийтлүүлсэн билээ.

Халхын аялгууг харьцуулан үзэхэд баруун халхын аман аялгуунд багтах салбар аман аялгуунуудад үгсийн сангийн талаар эрс ялгаатай үг нэлээд ажиглагдаж байна. Баруун халхын аман аялгууны зөвхөн үгсийн сангийн зарим онцлогоос энд дурдах юм.

Засагт хан аймгийнхан, одоогийн Говь-Алтай аймгийн халх, Ховд аймгийн зарим сумын халх, мянгад, Хөвсгөл аймгийн дархад, ариг урианхай, хотгойд, Завхан аймгийн сартуул, хотгойд, Увс аймгийн зарим сумын сартуул, мөн элжгэн халх, Говь-Алтай аймгийн халхажсан хойд өөлд, Архангай аймгийн зарим сумын халхажсан өөлд эдгээр нь баруун халхын аман аялгуугаар ярилцагчид юм. Халхын эдгээр салбар аман аялгууны үгсийн сан нь өвөрмөц хэд хэдэн онцлогтой. Үүнд:

1. Бичиг зохиолын хэлний нэг үгийг салбар аялгуунуудад үгсийн сангийн өөр өөр үгээр ярина. Жишээ нь: Хүүхдийн даахь үсийг дархад арвуул, сартуул сэвгэр, урианхай сэвлэг гэнэ. Мориор давхихыг элжгэн нисэх, дархад сийгүүлэх, хотгойд гуядах, өрнөд халхын салбар аялгуунд хийсгэх, хогны дэрсэн шүүрийг элжгэн туужуур, Говь-Алтайн зүүн сумын халхчууд шоожуу, баруун сумын халхууд ширвүүл гэж хэлнэ.

2. Өөр өөр юмыг үгсийн сангийн ижил үгээр нэрлэсэн тохиолдол эл салбар аман аялгуунуудад байна. Жишээ нь: Завханы сартуул тоононы хүрээг баатар гэдэг байхад, Хөвсгөлийн хотгойд, Архангайн халхажсан өөлдүүд буйлны товхыг баатар гэнэ. Дархад аялгуунд хэрвээ гэж дээлийн эмжээрийг

хэлдэг байхад элжгэнд хэрвээ гэж уулын хяр, модны захын хэсгийг нэрлэнэ. Говь-Алтайн халхчууд юмны иш бариулыг баривч гэж хэлж байхад элжгэн халхад жижиг хүүхдийн дээлийг баривч, Завханы хотгойд тогооны эсгий бариулыг хэлдэг.

3. Баруун халхын аман аялгуун дахь салбар аялгууны үгсийн сангийн зөрөөтэй үгийг ажиглахад хэрэглэгдэх байдал, зориулалт, хэлбэр дүрс утга төсөөтэй байдлаараа нэрлэгдсэн бололтой үгс нэлээд байгаа юм. Жишээ нь: Дархад аялгуунд бариулыг атгавч, атгаж барьдаг юм, тогооны угаалтуурыг ширвүүл, ширвэж угаадаг гэсэн утгаар, эсгий гутлыг аатан-ка тагжгар богино түрийтэйгээр нь, элжгэн, мянгад аялгуунд гэрт дэвсдэг дэвсгэрийг тойруулга гэж тойруулан дэвсдэг утгаар нь, сартуулд малын ноос хайчилдаг том хайчийг ангаа-хай, ангайлган хайчилдаг хэлбэрээр нь гэхчлэн хэлдэг. Ийнхүү нийтлэг онцлог ажиглагдахаас гадна салбар аман аялгуу бүрд үндэсний бичиг зохиолын хэлний үгсээс өвөрмөц ялгаатай үг олон (11) байна.

Салбар аман аялгуу тус бүрээр нь авч үзвэл:

1. Өрнөд халхын салбар аман аялгуугаар Говь-Алтай аймгийн бүх сумын халхчууд, Ховд аймгийн Буянт, Дарви, Цэцэг сум, Дуут сумын хагас ярилцана. Өрнөд халхын салбар аман аялгуу нь халхын бусад аялгуунаас авианзүйн талаар багагүй зөрөөтэйг эрдэмтэд (3.7.12.) судалсан. Харин эл аялгууны үгсийн сангийн талаар дэлгэрэнгүй судалгаа хомс байгаа билээ. Бичиг зохиолын хэлний үгсээс эрс зөрөөтэй үг цөөнгүй тохиолддог. Жишээ нь: аагуу-гоё сайхан, домбо-урт хүзүүтэй лонх, дөрвөлж-аргалын хайрцаг, төвхнөх-тохижих, суурьших, замбаа-арвайн гурил, зээгэж-аль хэдийн, ганжин-гулууз мод, гампанз-гурилын хавтгай, голт-мянгатаас том цөгц, лавших-олон давхарлан оёх гэх мэтийн олон үгийг дурдаж болно.

2. Дархадын салбар аман аялгуугаар Хөвсгөл аймгийн Баянзүрх Ринчинлхүмбэ, Улаан-Уул сумынхан (23.19) ярина. Энэ салбар аялгуу нь баруун халхын бусад салбар аялгууг бодоход дэлгэрэнгүй судлагдсан.

Монголч эрдэмтэн А. В. Бурдуков, А. Д. Руднев, Г. Д. Санжеев нар судалснаас гадна Д. Төмөртоогоо, Ж. Цолоо, М. Шинэхүү, Ц. Шархүү зэрэг эрдэмтэн, судлаачид дархад аялгууны талаар тодорхой судалгаа хийсэн билээ. Судлаачдын зарим нь дархадын салбар аман аялгууг ойрд, буриадын завсрын байдалтай (15) гэжээ. Харин Д. Төмөртоогоо (1) халх, ойрд, буриадын дундын байдлыг хадгалсан гэсэн дүгнэлт

хийжээ. Эрдэмтэн С.Бадамхатан дархадын гарал үүсэл, зан заншил ахуй амьдралын талаар, мөн дархад гэдэг нэрийн үүслийн талаар нарийн судалгаа хийж бичсэн. С.Бадамхатан (2) дархадын элжгэн овгийг халхын элжгэнтэй гарал угсаа нэгтэй гэсэн сонирхолтой санал дэвшүүлсэн байдаг. Энэ аялгууг судалсан эрдэмтэд түүний авиазүйн өвөрмөц шинжийг голлон анхаарчээ. Уг аялгуунд бичиг зохиолын хэлэнд байхгүй, бусад салбар аялгуунаас эрс ялгаатай өөр үг олон бий. Жишээ нь: аглаг-саланги, асхан-гуу жалга, бишил-бусад, баалах сэтгэл хөдлөх, догдлох, богоон-бугуйвч, хөцөөрөх-аашлах, загнах, ичмээ-арвай будаа, яндаа-том шанага, согтоос-юм нүддэг уур, совх-ор тойм төдий, суйв-юм тохдог хэц, шивэргэл-эмэгтэй хүүхдийн үс, гээг, сөөмөг-савхин гутал, шүүдэнг-чийгтэй мод, тэвээ-хомоол гэх мэт.

3. Хотгойдын салбар аман аялгуугаар Завхан аймгийн Баян хайрхан, Баянтэс, Тэлмэн, Нөмрөг, Хөвсгөл аймгийн Арбулаг, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Цагаан-Уул, Алаг-Эрдэнэ, Тосонцэнгэл, Их-Уул, Хатгалын хотгойд (3, 18) ярилцана. «Хотгойд угтаа ойрдын хойд овгоос гаралтай гэсэн түүхчдийн судалгаа илүү үнэмшилтэй. Хойд овогтноос улбаатай хойд-гойд буюу хотлойд хошуу XVI зууны сүүлийн хагаст Засагт хан аймгийн том феодал Гэрсэнзийн угсааны Шолой убашин хунтайжийн мэдэлд оржээ. Ингэж хотгойд нь халхад бүрмөсөн нэгдэж дараа нь манжийн ноёрхолд ормогц халхжиж ахуй заншил хэл яриа нь ялгагдахгүй болсон байна» гэж эрдэмтэн Ж.Цолоо (3) бичжээ. Хотгойдын салбар аман аялгуунд андар-дэлгэц, бэдрэх-эрж хайх, булхах-шургах, бүтүү-шилбэ (товчны), гудрага-модонд говил гаргадаг харуул, гуявч-хүүхдийн өмд, гэдэстэй-жирэмсэн, гөнгий-чихсэн хошного, найтаг-аяганы хийц, чухар-давсгүй хярам, унхиар-хул аяга, гэх мэтийн үгсийн сангийн зөрөөтэй өвөрмөц үг олон бий.

4. Ариг урианхайн салбар аман аялгуугаар Хөвсгөл аймгийн Жаргалант, Шинэ-Идэр зэрэг маш цөөн, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумын ариг урианхайчууд ярьдаг. Ариг урианхай нарын гарлыг эртний Бурхан халдуны Аданхан урианхайн удам мөн гэж эрдэмтэд (4) дүгнэлт хийжээ.

Тэдний ярианд бичиг зохиолын хэлэнд ховор тохиолдох үгс бий. Агил-өтгөн, төв халхын агилуун гэсэн үгтэй утга ойролцоо байх, доштаг их, ихтэй, дуулга-үстэй малгай, завхай-мөнгөн гоёл, нораа-ширэнгэ, шугуй, өгөөжин- өгөөмөр, хувьшигсах-донгодох гэх мэт.

5. Сартуулын салбар аман аялгуугаар Завхан аймгийн Дөрвөлжин Завханмандал, Алдархаан, Сантмаргац, Сонгино,

Түдэвтэй, Ургамал, Яруу, Эрдэнэхайрхан, Увс аймгийн Завхан, Ховдын Чандмань сумынхан (3, 5, 7) ярилцдаг. Сартуулууд монголын янз бүрийн нутгаас нүүдэллэн очиж нутагласан хүмүүс боловч тэдний дунд Чингэсийн «алтан ураг» гэдэг боржгин овгийнхон олон байсан бөгөөд сартуул гэдэг нь ястны нэр биш газрын нэр юм гэж тэдний гарал нэрийн талаар эрдэмтэн Э. Вандуй (5) бичсэн билээ. Сартуулын салбар аман аялгуунд бичиг зохиолын хэлэнд тохиолдохгүй өвөрмөц үг олон бий. Агатар, агтар-ахар богинохон, агтардах-богинодох, аймаагүй-а. их олон, б. замбараагүй, овилгогүй, багзаг-борлон, боолтрог-бяруу, зүлд-хэсэглэн боосон мах (хувь мах), зүймэн-модны үртэс, элэглэх-дооглох, шоолох, гударган, гудархай-сүү ихтэй мал, хөцөр-тачирхан, ахархан найтаг-мөчир шиндүүл гэх мэт.

6. Мянгадын салбар аман аялгуугаар одоогийн Ховд аймгийн Мянгад сумынхан ярина. Мянгадыг хотгойдтой гарал нэг гэж эрдэмтэд (3) үздэг. Манжийн эсрэг тэмцэгч ардын бослогын удирдагч хотгойдын Чингүнжавын харъяат албат бөгөөд 1754 онд уул нутгаасаа гарч нүүдэллэн нутагласаар манжийн хааны зарлигаар Ховдод очиж нэгэн хошуу болон суурьшсан хотгойдын зургаан отгийн нэг болох мянгад нь Ховд руу очсон халх хотгойд удамтай хүмүүс юм гэж эрдэмтэн Д. Гонгор (6) бичсэн билээ. Нэгэнт хотгойдтой гарал нэгтэй учраас мянгадыг баруун халхын аман аялгуунд багтаадаг. Бичиг зохиолын хэлнээс эрс ялгаатай үгсийн сангийн өвөрмөц үгс бий. Зилдах-гүйх, бөгөг-бэлтрэг, бухах-аашлах, загнах, голжуухай-бяззуухай, гүвдэлдэх-зодолдох, гөгөлзөргөнө-тагтаа, хурмаш-навтас, манз-энгэрийн эмжээр, өрүүвчзуухны тосгуур, үгтээх-зулгаах, татах гэх мэт.

7. Халхажсан өөлдийн салбар аман аялгуугаар Архангай аймгийн Батцэнгэл, Өлзийт, Хотонт, Говь-Алтай аймгийн Шарга сумын хойдууд (10) ярилцдаг. Халх нарын дунд цөөн өөлдүүд орж суурьшаад тэдний яриа нь халхтай адил болсон тухай мөн тэднийг ойрд аялгуутанд хамааруулж болохгүй талаар монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов (7) бичсэн байдаг. Халхажсан хойд өөлдийн салбар аман аялгуунд бичиг зохиолын хэлэнд ховор тохиолдох үгс нэлээд байна. Асган-орой, үдэш, бух-шуудуу, зусан-цавуу, эдрэн-хэдрэг, гараац-тооно, маяг-өмд, наар-наашаа ир, нийлэнхүү-тогооны таг, оваарах-анзаарах, өрөвлөг-хүүхдийн даахь, панжиг-шоон тоглоом, шигших-гиншиж уйлах, мэгших, үрэн-охин гэх мэт.

8. Элжгэн халхын салбар аман аялгуугаар Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан сумынхан, Баруун-

турууны сангийн аж ахуйнхны хагас ярилцана. Элжгэн халхуудын гарал, түүх тэдний аялгууны талаар гадаад дотоодын эрдэмтэд (3. 13. 16) бичсэн. Энэ халхууд нь эртний монголын элжгэн овгоос гаралтай гэсэн мэдээ байдгийг доктор Н. Иш-жамц (8) «Элжгэн халхууд монголын хонхирад аймгаас гаралтай тэд угаас монгол угсааны аймаг гэлтэй» гэж тэмдэглэсэн байдаг.

Элжгэн хошуу олон зуун жил монголын олон аймагтай зэрэгцэн оршсоор Манжийн хааны зарлигаар халхын хаяа мануулахаар Ханхөхийд суурьшуулжээ. 1691 онд халх долоон хошууны нэг ноёнтон Хатанбаатарын хошуунаас тасран халхын өрнө замын зүүн гарын өмнөд хошуу гэж тасраад 1912 он хүртэл уул нэрээр явсаар 1912—1923 он хүртэл Чин Ачит вангийн хошуу гэж нэрлэгдсээр 1924 онд Хан хөхий уулын хошуу нэртэй болсон тухай Ц. Сономдагвын (9) судалгаанд бий. Мөн Ховд аймгийн Мянгад, Эрдэнэбүрэн, Хөвсгөлийн Баянзүрх, Улаан-Уул, Ринчинлхүмбэ сумуудад ч элжгэн хүмүүс суудаг тухай (10) тэмдэглэгдсэн байдаг. Элжгэн халхын салбар аялгуунд бичиг зохиолын хэлэнд байхгүй үгсийн сангийн өвөрмөц ялгаатай үгс нэлээд тохиолддог. Ангиондоо өөр, айнаахан-бас л, дахиад, жимаагуул-нарийн мөчир, заргаг-үсий нь хайчилсан сармай арьс, завхай-даалууг давхарлуулан өрснийг, зувцаа-нэмгэн үстэй дээл, зууравч-цөөн толгойтой нэмэлт хана, гундуухан-томоотой, төлөвхөн, гэтэвч-мөнгөний түрийвч, гэтээсээ-ер нь, күм-бодын шир, ижий ахай-дотночлох, түнш найз болох, нээх-их том, их юм, паартаг-дэгтий, шартай-жирэмсэн, тарихгүй-сахилгагүй, гувч-жижиг ташуур, үүрүүлэх-задлах, бутаргах, шүргүү-хоёр авдрын буюу ор авдрын хоорондох зай, шилээтэй-шившигтэй, шогшоо-ханиад гэх мэтчилэн олон үгийг дурдаж болно.

Дээрх онцлогуудаас үүдэн товч дүгнэлт хийхэд:

1. Баруун халхын аман аялгуунд багтаж байгаа эдгээр салбар аман аялгууны үгсийн сангийн гол зөрөө нь ард түмний өдөр тутмын ахуй амьдралын, байгалийн элдэв зүйлс, гэр орны эд агуурс бусад хэрэглэгдэхүүний нэр дээр нэлээд ажиглагдаж байна.

2. Өөр нэг онцлог нь эдлэж хэрэглэдэг эд юмс, хүний гоёл чимэглэл, хувцасны нэр дээр тохиолдож байна.

3. Нийт халхын аялгууг харьцуулан үзэхэд халхын дээрх салбар аман аялгууны ярианы үгс нь халхын бусад салбар аман аялгуунаас зөрөөтэй үгээр харьцангуй илүү байна гэдэг дүгнэлт хийж болно.

4. Баруун халхын аман аялгуунд багтах зарим салбар аман аялгууны үгс нь сонгодог бичгийн хэлний онцлогийг илүү хадгалж байгаа Ойрадын салбар аман аялгууны зарим үгтэй дүйж буй юм. Иймээс эл аялгуу нь зарим талаараа ойрд, халхын аялгуунд завсрын байдлыг хадгалж үлджээ гэсэн дүгнэлт хийж болохуйц санагдана. Жишээ нь: ариг урианхайд хүүхдийн даахийг сэвлэг гэж байхад баядын салбар аялгуунд мөн адил хэлдэг. Архангай, Говь-Алтайн халхажсан өөлдөд орой үдшийг асган, асхан, нааш ир гэхийг наар гэж тус тус хэлж байхад дөрвөд, баяд салбар аман аялгуунд бас ийнхүү хэлдэг байна. Иймэрхүү жишээ олныг дурдаж болно.

5. Салбар аман аялгуу тус бүрээс маш цөөн үгийг авч үзсэн боловч ийм зөрөө төв халхын аялгууг бодвол зүүн ба баруун халхын аман аялгуунд нэлээд тохиолдож байгаа учраас энэ талаар цаашид гүнзгийрүүлэн судалгаа хийхэд сонирхолтой дүгнэлт гарч болох юм.

НОМЗҮЙ

1. Д. Төмөртоогоо. Дархадын аман аялгууны урт эгшиг, тэдгээрийн үүслийн тухай товч тэмдэглэл. Хэл зохиол. 4-р боть. УБ. 1967. 196-р тал
2. С. Бадамхатан. Хөвсгөлийн дархад ястан. УБ. 1965. 14-р тал
3. Ж. Цолоо. БНМАУ-ын нутгийн аялгуу. УБ. 1982. Хэл зохиол. 18-р боть, 1—2. 53-р тал.
4. Мөн зохиол. 49-р тал.
5. Э. Вандуй. Завханы сартуул ба түүний аман аялгуу. Эрдэм шинжилгээний өгүүллэгүүд. 1964. 2-р боть. 18—19. 198-р тал.
6. Д. Гонгор нар. Ховдын хураангуй түүх. УБ. 1964. 53-р тал
7. Б. Я. Владимирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Л. 1929. стр.9. 10
8. Н. Ишжамц, С. Бадамхатан. Хөвсгөлийн дархад ястан номын тухай шүүмж. УБ. 1965. ШУА-ийн мэдээ. № 4. 72-р тал
9. Ц. Сономдагва. Халхын дөрвөн аймгийн олон хошууд, тэдгээрийн гарал нэрсийн өөрчлөлт (1691—1924) Түүхийн судлал. 8-р боть. 8-р дэвтэр. УБ. 1969. 174-р тал
10. БНМАУ-ын угсаатны зүй. I боть. УБ. 1987. 45-р тал.
11. Б. Амаржаргал. БНМАУ-ын нутаг дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг. I. Халх аялгуу. УБ. 1983.
12. Ш. Барайшир. Халхын алгууны зарим хэсгийг судалсан тухай тэмдэглэл. УБ. 1957.
13. Ц. Баярсүрэн. Элжгэн халхын салбар аман аялгууны зарим онцлогоос. Хэл зохиол судлал. 24-р боть. 1988.
14. Э. Вандуй. Зарим нутгийн аялгууны үгсийн сангийн тухай. УБ. 1957.
15. Г. Д. Санжеев. Дархатский говор и фольклор. Л. 1931
16. Ж. Цолоо. Архангай аймгийн хойд сумын халхын аман аялгуу аман зохиол судалсан нь. Монголын судлал. УБ. 1967. 7-р боть. 17-р дэвтэр. тал 219—242
18. Ж. Цолоо. Баруун халхын аман аялгуу. Халх аялгуу. УБ. 1970. тал 138—158
19. Ц. Шархүү. Дархад аман аялгуу (гар бичмэл) 1984

Э. Пүрэвжав

**МОНГОЛ ХЭЛ ЗҮЙН БИЧГҮҮДЭД ЗӨВ БИЧИХ,
ЗӨВ ДУУДАХ АСУУДЛЫГ ТУСГАСАН НЬ**

Монгол хэл зүйн бичгүүдийг тун нарийвчлан үзэж, олон талаас нь судлаж тайлбарлах явдал бол уламжлалт монгол хэл бичгийн ухааны түүхэн хөгжил, тоймыг гүнзгий танин мэдэхэд онцгой ач холбогдолтой. Монгол хэл шинжлэлийн уламжлалт зохиол бүтээлүүдийг орчин үеийн хэл шинжлэлийн үүднээс судлан шинжилж, түүний онолын сэтгэлгээний үндсийг тогтоон гаргах нь эдүгээгийн монгол хэлний судлалын анхаарлын төвд байвал зохих чухал асуудал (12, 76)-ын нэг мөн билээ. Бид энэхүү өгүүлэлдээ монголын уламжлалт хэл зүйн бичгүүдэд байгаа сонгодог монгол бичгийн хэлний зөв бичих ёс болон зөв дуудах ёсны талаарх дүгнэлт, тайлбарыг тоймлон гаргахыг зорилгоо болгов.

«Зүрхний толтын тайлбар, үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч Огторгуйн маань» хэмээх хэл зүйн бичиг нь монгол хэл шинжлэлийн түүхэнд чухал байр суурийг эзэлдэг. Алшаагийн равжамба Данзандагвын 1723—1735 оны хооронд бичсэн энэхүү хэл зүйн бичиг нь эдүгээ бидний үед уламжлан үлдсэн монгол хэл шинжлэлийн бүтээлүүдийн дотроос урьд Чойжи-Одсэр бандидын зохиосон «Зүрхэн толтын тайлбар»-т зориулан хийсэн хамгийн эртний бөгөөд хамгийн дэлгэрэнгүй тайлбар юм. «Зүрхний толтын тайлбар»-т монгол хэлний зөв бичлэгийн дүрэм хийгээд зөв дуудах ёсны талаар хуучин бичиг судруудад дайралдах эндүүтэй мадагтай зүйлсийг хянан шүүмжилж, зөв бичиж уншсаны ашиг тус; буруу бичиж уншсаны гэм хорын тухай олон зохиолоос ишлэл аван тайлбарласныг хэл судлаачид (7, 16) тэмдэглэсэн нь буй.

Данзандагвын «Зүрхний толтын тайлбар, Огторгуйн маань»-д: *sesig* гэдгийг эдүгээ *sejig* хэмээх ба *lingqu-a* *secig* гэдгийг эдүгээ *lingqu-a* *secseg* хэмээх мэт бөгөөд *usug* (үсэг) гэдгийг эдүгээ *ujug* хэмээх хийгээд *susug* гэдгийг *sujug* хэмээх мэт ба *secen* гэдгийг эдүгээ *secen* хэмээх мэт. Эдүгээ

хар үг хольсон нь олон байна. Үлгэрлэвээс: хулсан үзгээр монгол үсгийг бичвээс гэхэд үзэг хэмээсэн нь төмөр үзэг хэмээх мэт бөлгөө. Энэ мэт номын үгтэй хар үг ялгал үгүй номд бичсэн нь үл зохих болой» (4, 15) гэж бичгийн болон аман ярианы үг хэллэгийг хольж хэрэглэх нь зүйд нийцэхгүйг баримтаар ийнхүү шүүмжилсэн байна. Дээр өгүүлсэн монгол үсэг гэхийн **үсгийг** тод үсгээр *uzug* (14, 58) гэдэг. Ойрдын Зая бандидын (1599—1661) зохиосон «*uzugiyin nayiralya*» хэл зүйн бичгийг «үсгийн найрлага» гэж ойлгож болох юм. Дандзандагвын хэл зүйн бичигт дурдсан номын үг, хар үг зэрэг нэр томьёо нь орчин үеийн хэл шинжлэлийн бичгийн хэл, ярианы хэл гэсэн ойлголттой дүйнэ. Эл «хар үг» гэсэн нэрийг профессор Ш. Лувсанвандан (1910—1983) «бор хэлний үгс» (3, 487) хэмээн томьёолжээ.

XIX зууны үед гарсан монгол хэл зүйн бичгүүдийн дотор Агваандандар (1758—1838)-ын туурвисан «Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг» (1828) гэдэг хэл зүйн бичиг нь нэлээд өвөрмөц бүтээл ажээ. Одоогоос мянга гаруй жилийн тэртээ үүсэн хөгжиж, хэвшин тогтсон монгол бичгийн хэлний олон тооны үгс бичлэгийнхээ талаар аман ярианыхаа хэлний хувьсал хөгжлөөс яваандаа хоцорч улмаар тэдгээрийн бичлэг, дуудлага хоёр нь зөрөөтэй болсон үзэгдлийг Дандар лхарамба олж ажиглаад, «ийн бичээд тийн унших ёс» хэмээн нэрийдсэн байна. Агваандандар энэ хэсэгтээ: «*ᠲᠠᠩᠭᠢ* хэмээн бичээд *tengeri* хэмээн уншина. Түүнчлэн *nigen gsan*, *laqsan*, *okin*, *umartaqu*, *nauman*, *kkiri*, *molsu*, *solsu*, *sasin*, *susug*, *usug*, *qoyaduᠤᠭ* тэргүүтнийг энэ ёсоор бичээд уншихуй цагтаа өөр өөрийн заншсан хэлээр өгүүлнэ» (4, 28) гэж дүгнэсэн нь тэр үед үгийн бичлэг, дуудлага хоёр ондоо байсны гэрч гэж үзэж байна. Профессор Ш. Лувсанвандангийн тэмдэглэсэнчлэн, нэгэн адил бичээд ярих хэлэлцэхдээ нутаг нутгийн аман аялгуугаар хэлэлцдэг (3, 90) байсан бололтой.

«Хэлний чимэг»-т *qudduᠣ*-ийг *quddug* (4, 28) хэмээн бичсэн нь монгол үсгийн ёсон бус боловч цаг улирлын тооны бичигт алдаршсан нь юм гэж дурдсан явдал бол зөв бичлэгийн уламжлалын зарчимтай шууд холбоотой үзэгдэл. «Монгол бичгийн хэлэнд давхарласан урт гийгүүлэгч байгаагүй. Гэвч зарим үгэнд нэг авиаг хоёр адилхан гийгүүлэгчээр тэмдэглэн *kkir*, *odduᠣsan*, *oggugsen*, *oddur*, *qudduᠣ* хэмээн бичдэг боловч, учир тайлбар нь ондоо бололтой. Тухайлбал: *oggugsen* гэж *ukugsen* гэдгээс, *kkir* гэж *kira* гэдгээс, *oddur* гэж *edur* гэдгээс, *qudduᠣ* гэж *qutuᠣ* гэдгээс л ялгасан хэрэг» (8, 163) хэмээн финляндын нэрт монголч эрдэмтэн Г. И. Рамстедт

(1873—1956) гярхай ажиглан, дүгнэлт гаргасан байдгийг дурдууштай юм.

Түмэдийн Галсан «Монгол үсгийн бүгд тайлбар бичиг» гэдэг нэлээд дэлгэрэнгүй хэл зүйн бүтээлийг Төр гэрэлтийн 15 дугаар (1835) онд бичиж нийтлүүлсэн. Галсан «Монгол үсгийн бүгд тайлбар бичиг»-ийн тавдугаар дэвтрийн төгсгөлд тухайн үеийнхээ монгол хэлний дуудлагын баримжааны талаар нэн сонирхолтой жишээ баримтыг галиглан оруулжээ. Монгол бичгийн хэлээр *paɣuɣ*, *baɣudal*, *maɣu*, *negudel*, *qoyar*, *temur*, *boɣoni*, *man-u*, *tan-u* хэмээн бичээд, эдгээрийг дуудах цагтаа *nuur*, *buudal*, *muu*, *nuudel*, *qoyor*, *tomor*, *boɣini*, *manai*, *tanai* (2, 609—611) гэх мэтээр ярьж хэлж байсныг тэмдэглэсэн нь одоогийн монгол хэлний дуудлагатай тун ойрхон байна.

Монгол бичгийн хэлэнд *ogumui* (оргоно), *ugumui* (ургана); *toru* (төр), *Doru* (дөр); *qajayar* (хазаар, хазгар) (2, 732) зэрэг адил дүрс хэлбэртэй үгс маш олон байдаг. Эдгээрийг дуудахдаа үг хэллэгийг хэрэглэсэн байдал, мөн байрлалыг нь нягтлан үзэж, дээр доорх үг аягийг нь мэдэж ялган таньж дуудахыг Галсан онцлон заагаад, аливаа адил дүрс-тэй үгсийг дэмий зоригоор хувилган бичиж болдоггүй, дэлгэрэнгүйгээр үл санагч хүмүүс үгсийг дэмий хувилгаж бичдэг. Дэлгэрүүлэн зохион гэсээр харин ч уг утгыг эвдэхэд хүргэдэг (2, 733)-ийг дурдсан нь сонгодог монгол бичгийн хэлний үгийн бичлэгийн ёс горим үнэхээр нарийн чандыг гэрчилнэ. Монгол бичгийн хэлний үгийн бичлэг нь үгийн язгуур, гарлыг мөшгөн тайлбарлахад чухал эх хэрэглэгдэхүүн шууд болж өгдгөөрөө нэн онцлогтой. Орчин цагийн кирил үсгээр байгаа үгийн бичлэгийн уг дүрсээр үгийн язгуур, гарлыг магадлан гаргахад бэрхшээлтэй байдаг.

Тогтохтөр (1797—1887)-ийн бичсэн «Лам өгүүлэхийн арслан манзшир эгшигт эхэд мөргөж, монголын зуун хорин гурван цагаан толгой үсгийг туурвисан Оюун билгийн соёорхол» (1864) хэл зүйн бичиг нь сонгодог монгол бичгийн хэлний зөв бичлэгийн дүрэм зүйг улам нарийвчлан боловсруулснаараа (12, 59) өвөрмөц бүтээл. То ван «Оюун билгийн соёорхол»-доо: «өөрсдийн дуудах аялга нь тэнгэр боловч *tingri* хэмээн бичдэг лүгээ адилаар агшныг *ɣsan*, мөсийг *molsu*, мартахыг *umartaqu*, дорыг *door-a*, чоныг *cinu-a*, нүүд (олон тооны дагавар)-ийг *nugud*, лүгээ дагаврыг *luge*, наймын тоог *пауман* зэргээр бичдэг журим» (10, 4/6)-тай хэмээн дүгнэсэн явдал нь монгол бичгийн хэлний үгийн уламжлалт бичлэгийг ярианы хэлний дуудлагатай жишин харьцуулсан судалгаа болжээ.

Дэлэгжунайн зохиосон «Монгол үсгийн гол ёсыг тодотгогч толь» хэл зүйн бичгийн «эндүүрэлт нэр» хэмээх наймдугаар бүлэгт дуудлага нжил төсөөтэй бөгөөд бичлэгийн хувьд дүрс хэлбэр ойролцоо үгсийг хэрхэн салган тэмдэглэсэн учир начрын талаар сонирхолтой ажиглалтууд хийсэн байна. Жишээлбэл: эд юмын эдийг (ed) гэж бичихийн оронд (ed) хэмээвээс жилийн нэртэй адилхан болж андуурах тул ийнхүү өөрөөр бичдэг гэж тайлбарласан байна. Өлзий хутаг гэхэд qutuү гэдэг бөгөөд усны худаг гэхэд qudduү гэдэг. Харин усны худаг гэхийг хуанлийн дотор quddug хэмээн бичдэг. Төгс оюутан (судлаач) шинжилбээс урдахь нь сайныг мэднэ (4,62) гэснээс үзвэл эр, эмийн зохицлыг баримтлах нь зүйтэй гэсэн санаа бололтой.

«Монгол үсгийн гол ёсыг Тодотгогч толь»-ийн нэрний ялгал хэсэгт «гэм хор (qoor), борооны хур (qur-a); насан егүүтгэн үхэх (ukuku), юм өгөх (ogku); бүхний хотол (qotala), хөлийн гутал (yutul), үнэн бус худал (qidal); ухааны билиг (bilig), ерийн бэлэг (beleg), тэмдэг бэлгэ (belge); эм туулга (tuuly-a), хуяг дуулга (duuly-a); үр садан (ur-e), өр төлөөс (ori), үүр цайх (ur), шувууны үүр (egur), ар өвөр (obur), өөр бусад (ober); тооны дал (dala), газрын тал (tal-a); учир шалтгаан (ucir), очир хонх (vcir); улс иргэн (ulus), дээс олс (olusu)» (4,63) гэх мэтчилэн үгсийг зөв бичиж байхын чухлыг тусгайлан өгүүлсэн байна. Дээр дурдсан үгсийг нөхөр үгний хүч болон алдаршсаны хүчээр таньж мэддэг. «Нөхрөөр мэдэх» гэснийг Банины хэл зүйд «Ханиар таних» хэмээн нэрлэсэн (11,57) байдаг. «Нөхрөөр мэдэх» гэсэн үг хэллэг нь одоогийн хам бүтцийн төвшинд мэдэх гэсэн утгатай дүйнэ. Алдаршсаны хүч гэдэг нь уламжлалт заншлаар бичнэ гэсэн санаа юм. Үүнийг эдүгээ өвөр Монголын хэл судлаачид «тогтсон үсэг» хэмээн нэрлэдэг.

XIX зууны сүүлчээр Цэцэнхан аймгийн Нанзаддоржийн туурвисан «Монгол үсгийг төвд үсэгт шүтэж, төвөг багатай мэдүүлэгч түлхүүр, харанхуйг арилгагч зул» хэмээх хэл зүйн бичгийн «унших ёсыг мэдэх» гэсэн төгсгөлийн бүлэгт: «blam-a хэмээх хүндлэх үг, үл хүндлэхийн зүйлд lam-a хэмээх хийгээд, хүндэтгэл их бөгөөс qaγan, gegegen, бага бөгөөс qan, gegen гэдэг ялгааг мэдэж хэрэглэх» (6,22)-ийн чухлыг тэмдэглэсэн нь үгийн хоёр өөр бичлэгийн учрыг тайлахыг оролдсон оролдлого болжээ. Дундад зууны монгол бичгийн хэлэнд хүндэтгэлийн орноос шууд хамаарч үг хэллэгийг хоёр хувилбараар бичдэг байсныг тусгайлан авч үзэж өгүүлэл бичсэнээ энэ ялдамд тэмдэглэе.

XIX зууны сүүлч XX зууны эхэн үед амьдарч байсан түмэд Дугаржав монгол бичгийн хэлний зөв бичих болон зөв дуудах ёсны тухай зүйлсийг анги бүлэг болгон хуваагаад, бүлэг бүртээ өвөрмөц нэр өгч тайлбарлан зохиосон «Монгол үсгийн чухлыг цуглуулсан бичиг» (1909)-ийг туурвижээ. Энэхүү бүтээлийн «Монгол үсэгт дөрвөн гайхал буй хэмээгч» (5, 50) хэсгээс жишээлэн авч үзүүлье. Эл дөрвөн гайхал гэдэгтээ хүндэлсэн үсэг, цээрлэсэн үсэг, буруу хандсан үсэг, хавсарсан үсгийг оруулсан байна.

Хүндэлсэн үсэгт дахин дээш хүндэлж үл чадахыг оруулах бөгөөд лам гурван эрдэнийн ламыг бичихдээ *blam*-а гэх ба унших цагтаа *lama* гэдэг хэмээн тайлбарласан нь Нанзаддоржийн дүгнэлтээс арай ондоо болжээ.

Цээрлэсэн үсгээ дотор нь хоёр хуваажээ. Нэгдүгээрт, билиг үгүйгээс цээрлэнэ. Тухайлбал: *gsan* гэсэн үгийг агшан хэмээн бичдэггүйн учир бол агсан (үхсэн) гэдгээс зайлуулснаас л үүдэн гарсан байна. Хоёрдугаарт, бурхан номын нэртэй адилтган эндүүрэхээс цээрлэнэ. Өлзий хутаг бүрдсэн бурхны нэрээс усны худгийг холдуулж *quddug* гэж бичээд, *qudduy* хэмээн уншдаг ажээ.

Буруу хандсан үсэгт үгийн дуудлагыг өөрчлөн гуйвуулж ондоо болгосон үгсийг хамааруулаад, үсэг гэдэг үгийг *ujug*, сүсэг гэдэг үгийг *sujug*, шашин гэдэг үгийг *sajin* (5, 105) хэмээн уншиж дуудахыг эрс шүүмжилсэн байна.

Хавсарсан үсэгтээ хоёроос гурван үсэг (тийгүүлэгч)-ийг хамт «*lgrgi*» (тэнгэр) лүгээ адил бичихийг тусгайлан (5, 106) оруулсан юм. Ийнхүү Дугаржав «Монгол үсгийн дөрвөн чухал», «Монгол үсгийн дөрвөн зүйл нарийн», «Монгол үсгийн дөрвөн зүйл уран», «Монгол үсгийн дөрвөн зүйл нягт», «Монгол үсгийн хоёр зүйл эрхбиш», «Монгол үсгийн нэг зүйл гайхамшиг» гэх мэтчилэн гүн утга бүхүй гарчиг өгч; монгол бичгийн хэлний зөв бичих болон зөв дуудах ёсны нэлээд ээдрээтэй асуудлуудыг товч авсаархан атлаа ойлгоход хялбар аргаар тайлбарласан.

Ард Тоогүйн XX зууны эхэн үед бичсэн «Зүрхний толт хэмээх судар»-т монгол бичгийн хэлний бичлэгийн хувьд ижил төсөөтэй боловч дуудлага нь өөр үгсийг андуурч эндүүрэх явдал олонтоо гардгийг дурдсан нь буй. Тухайлбал: огторгуйн нар (нага) ба хүний нэр (нег-е); газрын гүвээ (gubege) ба байшингийн хөвөө (kobuge); сүмбэр уул (ayula) ба гичгэнийн уул (uul); хүний сайн зарлиг (jarliy) ба зэрлэг (jerlig) гөрөөс; бат мөнх (mongke) ба алт мөнгө (monggu); тэмээний ботго (botuyu) ба будаа (budaya) тариа; цас хур (qur-

а) ба хорт (qoora) могой (4,68) тэргүүтэн үгсийн утгын ялгамжааг мэдэхийн чухлыг зөвлөжээ. Мөн «оюун билиг бясалган бичсэн үсэг (usug) ба ном бичих үзэг (ujug); цас (casu) мөс ба цус (cisu) тусах; уух дарс (darasu) ба ургасан дэрс (deresu), ёслолын шүхэр (sikur) ба шүүрдэх шүүр (sugur), сарын шинэ (sin-e) ба хүн амьтны шанаа (sina), мод цавчих ооль (oüli) ба ууль (uüli) шувуу зэрэг (4,69) ижил хэлбэртэй үгс (омоформа) байдаг. Орчин цагийн монгол хэлэнд монгол бичгийн хэлнийхээс харьцангуй олон тооны ижил бичлэгтэй үг байдгийг онцлон дурдмаар байна. Бид уламжлалт монгол хэл зүйн бичгүүдээс авч тайлбарласан бичгийн хэлний зөв бичих, зөв дуудах ёсны асуудалтай холбогдол бүхий дүгнэлт, жишээ хэрэглэгдэхүүнийг аль болохоор давхардуулахгүйг хичээлээ.

Монгол бичгийн зөв бичих дүрэм жигдрэн цэгцрэхэд XIII зуунаас эхлэн удаа дараа туурвиж ирсэн олон арван хэл зүйн бичиг нэн чухаг үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой билээ. Эдгээр бүтээлүүд нь цагаан толгой, зөв бичих дүрмийг хамаарсан төдийгүй хэл шинжлэлийн ухааны олон талыг багтааж (13) байсныг онцлон дурдалтай. Ерөөс монгол бичгийн хэлний зөв бичих дүрмийг үнэн зөвөөр үнэлэн цэгнэх явдал бол монгол хэлний өөрийнх нь дотоод хууль зүй, хэм хэмжээний учрыг нээн олоход үлэмж их зүйлийг өгөх (1,89) нь дамжиггүй.

АШИГЛАСАН ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:

1. Владимирцов Б. Я. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика. Издание второе. -М., 1989
2. Галсан. Монгол үсгийн бүгд тайлбар бичиг. -Хөх хот., 1981
3. Лувсанвандан III. Орчин цагийн монгол хэл. -Бээжин., 1961
4. Монгол хэлний шинжлэлийн дурсгал бичиг. -Хөх хот., 1983
5. Монгол хэлний шинжлэлийн дурсгал бичиг, хоёр. -Хөх хот., 1985
6. Нанзаддорж. Монгол үсгийг төвд үсэгт шүтэж төвөг багатай мэдүүлэгч түлхүүр, харанхуйг арилгагч зул хэмээх оршвай. Бичмэл ном, 25 хуудас
7. Пагба Т. «Зүрхний толтын тайлбар»-ыг судалсан тухай тэмдэглэл. -УБ., 1957
8. Рамседт Г. И. Монгол ном бичгийн хэл, хүрээний аман аялгуу хоёрыг авиан зүйгээр харшуулсан нь. -«Хэл зохиол», IV боть. УБ., 1966
9. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй, удиртгал. -УБ., 1964
10. Тогтохтор. Оюун билгийн соёорхол. Модон бар, 14 хуудас
11. Төмөртоого Д. «Монгол үсгийн гол ёсыг Тодотгогч толь» хэмээх хэл зүйн бичиг. -«Монгол хэл уран зохиолын зарим асуудал», -УБ., 1966
12. Төмөртоого Д. Монгол хэл шинжлэлийн түүхэн уламжлал ба онолын үндэс. -«Хэл зохиол судлал», XVII боть. -УБ., 1986
13. Чоймаа III. Монгол бичиг. -«Үнэн» сонин, № 72. 1990
14. Шагдарсүрэн Ц. Монгол үсэг зүй. -УБ., 1981

Г. Сүхбаатар

НИРУН (ЖУЖАНЬ) НАРЫН БИЧГИЙН ТУХАЙ АСУУДЛААС

Хятад сурвалж бичигт хятад утга үсгээр «жужань» гэж галиглан тэмдэглэсэн угсаатны нэрийг тэр үеийн хятад утга үсгийн дуудлага, хятад сурвалжид далимд тэмдэглэсэн уг нэрийн утгыг монголчуудын түүхийн мэдээтэй тал бүрээс харьцуулан нягталбал тэр нэр нь персийн түүхчин Рашид-ад-дин «Судрын чуулга» зохиолдоо дурдсан «нирун» (нуруу) гэдэг язгуур монгол аймгийн нэр мөн болох нь ямар нэг эргэлзээгүй нотлогдож байна. Энэ талаар тусгай өгүүлэл нийтлэгджээ. Нирун улс 402—555 онд БНМАУ-ын нутгаар төвлөн тогтнож байхдаа Дундад Азийн орнууд Солонгос, мөн БНХАУ-ын нутагт байсан Табгачийн Вэй улс, Ци улс зэрэг хөрш оронтой цэрэг, улс төр, эдийн засаг, соёлын өргөн харилцаатай байсан юм. Иймд нирун нарын хувьд түүхэн тэгшрэлийн хууль (закон исторической корреляции) зайлшгүй үйлчилж, дорно, өрнө дахины иргэншлийн нөлөөгөөр тэдний нийгэм-эдийн засаг, соёлын хөгжилд ахиц гарсаар байжээ. Нирун улс монгол, зөвлөлтийн эрдэмтдийн хамтын бүтээлд дурдсанаар түрүү феодалын байгуулалтай хүчирхэг улс байв (1: 121—124). Нирун нар нийгмийн хөгжлийн хувьд бичиг хэрэглэх шатнаа хүрчээ.

Хятад сурвалж бичигт нирун нарын бичгийн талаар дурдсан мэдээг нягталбал: «Вэй шу» (Табгачийн Вэй улсын түүх)-ийн 103-р бүлэг, «Бэй ши» (Умард төрийн түүх)-ийн 98-р бүлэгт нирун нар «Бичиг тэмдэглэл (вэнь цзи) мэддэггүй. Цэргийн жанжин нь хонины хорголоор цэргийн тоог бүдүүвчлэн тэмдэглэдэг байв. Хожим мод сийлэн тэмдэглэл хийхийг (кэ-му вэй цзи) сайн мэддэг болсон» гэжээ. «Суншу» (Сун улсын түүх)-ийн 95-р бүлэгт Нирун «улсын засгийн явдал эгэл жирийн, ном зохиол (вэнь шу) мэддэггүй, мод сийлэглэн хэрэг явдлыг тэмдэглэдэг байв. Харин хожим яваандаа бичиг (шүци) мэддэг болсон. Эдүгээ эрдэмтэй хүмүүс олон бий»

гэжээ. Цаашилбал, «Нань Ци шу» (Өмнөд Ци улсын түүх)-ийн 59-р бүлэгт нирун нар «Мод сийлэн хэрэг явдлыг тэмдэглэдэг, ном зохиол мэддэггүй» гэжээ.

Хятад сурвалж бичгийн эдгээр мэдээнээс үзэхэд нирун нар ямар нэг бичиг хэрэглэж, хэрэг явдлаа тэмдэглэж байсан нь тов тодорхой байна. Яагаад гэвэл:

1. Хятад сурвалж бичгийн мэдээнд нирун нар бичиг хэрэглэж байсныг шууд заасан «шуци» гэдэг нэг гол үг байна. Хятад-орос толинд уг үгийн нэг гол утгыг «письменность» (бичиг) гэж заажээ 5: 544, № 2419). Хятадын орчин үеийн нэвтэрхий тайлбар толь «Цыхай» (Үгсийн далай)-д «шуци» гэдгийг тайлбарлахдаа: «шуци» гэж бичгийг (вэнь цзы) хэлнэ, «ци» нь сийлэх (кэ) гэсэн утгатай, эрт үед гол төлөв хутга хэрэглэн бичиг сийлдэг байсан учир ийнхүү нэрлэжээ» гэжээ.

2. «Кэму вэй цзи» (мод сийлэн тэмдэглэл хийхийг) сайн мэддэг болсон гэсэн нь модон дээр ерийн дүрс, зураас сийлэхийг хэлээгүй, чухам бичгийг заасан нь «сайн мэддэг болсон» гэснээс тодорхой байна. Нирун нарын дараахан үед түрэгчүүд рүн бичгийг модон дээр сийлж байсны дурсгал Киргизийн нурууны Ачигташ гэдэг газраас 1932 онд олджээ (3: 108—109).

Хятад сурвалжийн эдгээр мэдээг нанхиадач нар судалсныг үзэхэд нирун нар бичигтэй байсан нь бас нотлогдож байна. Үүнд:

1. Зөвлөлтийн эрдэмтэн В. С. Таскин хятад сурвалжийн «кэму вэй цзи» гэдгийг «делать записи с помощью зарубок на дереве» (мод сийлэн тэмдэглэл хийх) гэж, харин «шуци» гэдгийг «письменность» (бичиг) гэж орчуулжээ (10: 269, 298).

2. А. Коллауц, Х. Миякава нар «кэму вэй цзи» гэдгийг «kerbschrift» (сийлбэр бичиг) гэж, «шуци» гэдгийг «Schreibkunst» (бичиг соёл) гэж орчуулжээ (14: 89).

3. Ц. Хандсүрэн «кэму вэй цзи» гэдгийг «мод хэрчин хэрэг явдлыг тэмдэглэдэг» гэж, «шуци» гэдгийг «бичиг тэмдэг» гэж орчуулсан байна (4-ийн 74, 75).

Нирун улсын ноёрхогч ангийн дотор бурхны шашин нэвтэрч, Дармаприя (Фаай) гэдэг ламыг төрийн багшаар томилон, 3000 өрх соёрхож байжээ. Нирун улсын дотор бичгийн соёл нэлээд хөгжиж, бичгийн сайд, эрдэмтэй хүмүүс бий болсон байна. 420—478 оны үед Нирун улсын төрийн сайд Силинь но зурхайн тоо мэддэг, харь хэл, хятад хэлээр хэлэлцдэг байжээ (14: 89). Нирун улсын хаан Анагуй 534 оны үеэс хүчирхэг болж, бичгийн түшмэл зэрэг цол бий болгож байснаас гадна хятадын элчин Чунь Юйтань гэгчийг үлдээж би-

чиг хэрэг эрхлүүлж байжээ. Хятадын Лоян хотын нэг сүмд сууж байсан энэтхэг лам Ратнаматти (Ленаманьти) тэр хотод аялан очсон нэг нирун хүнийг түмэн хуйлаас ном мэдэх эрдэмтэй хүн гэж ихэд хүндэтгэн харь (хятад биш) хэлээр өдөржин ярилцдаг байжээ. Тэр нирун хүн бүснийхээ ширэн хавтганаас таван өнгийн утастай дэнсэрхүү юм гарган чавганы модыг хэмжээд чавганы үрийн тоог яг онож таан нэг бардам хятад түшмэлийн морийг мөрийд дийлэн авч байжээ. Тэр нирун хүн Ратнаматит Баруун хязгаарын (Дундад Азийн) оронд байхдаа танилцсан байна. Бодвол тэр нирун хүн Ратнаматитай самгард хэлээр ярилцаж байсан байх. Дээр дурдсан бүхнээс үзэхэд нирун нарт бичиг байснаар барахгүй, боловсорсон бичгийн хэлтэй байсан гэж хэлж болмоор байна.

Нирун нарын бичиг нь хожуу үеийн монголчуудад уламжлагдсан байх ёстой. Монголчдын судалгааг үзэхэд үнэхээр уламжлагдсан байна. Худам монгол бичгийн хэл нь үүнийг нотолж байна. Үүнд:

1. Б. Я. Владимирцов 1929 онд нийтлүүлсэн зохиолдоо бичихдээ: «Гэвч тиймэрхүү нийт монголын бичгийн хэл бол орчин үеийн монголын бүх аялгуу, ярианаас онц ялгаатай бөгөөд ихэнх монгол аймагт дэлгэрсэн монгол бичгийн хэл юм... Энэ бичгийн хэлний байдал нь олон талаар хувирсан боловч хамгийн хуучны монгол аялгуунаас нэлээд эрт үеийн монгол хэлний хөгжлийг төлөөлж байна... Энэ бичгийн хэл бол бүр тэр үед (Чингисийн үед Г.С) ч монголчуудын амьр ярианы хэлнээс ялгаатай уламжлалт хэл байсан юм» гэжээ (6: 20).

2. Н. Поппе бичихдээ: «Монгол бичгийн хэл бол бүх монгол ярианы хэл, аялгуунаас үндсээрээ ялгаатай бөгөөд бидний мэдэж байгаагаар, энэ хэл нь тэр ч байтугай XIII зууны үеийн монгол аялгуунаас ялгаатай байв... Энэ хэлний ба янз бүрийн монгол ястны хэлэлцдэг олон аялгууны хоорондын ялгаа нь европын ихэнх ард түмний бичгийн ба ярианы хэлний хоорондын ялгаанаас илүү байна» гэжээ (16: 1).

3. М. Н. Орловская бичихдээ: «Эртний үеийн энэ бичгийн хэл нь Чингисийн үед хэрэглэгдэхээс бүр өмнө амьд ярианы хэлнээс ялгаатай бүрэлдэн тогтсон бичгийн хэл байсан юм» гэжээ (15: 84). Дээр дурдсанаас үзэхэд, XIII зууны үед ч ярианы хэлнээс ялгаатай байсан худам монгол бичгийн хэл Нирун улсын үед байсан гэж үзэж бүрэн болмоор байна. Учир нь:

1. XIII зууны үед бичгийн хэл ярианы хэлнээс ялгаатай байсан нь хэдэн арван жилийн биш, хэдэн зуун жилийн хөгжлийн үр дүн байх ёстой.

2. Нирун, хожмын монголчуудын хоорондын түүх, эдийн засаг, соёл, угсаатны холбоос нь үүнийг нотолж байна.

3. Орхон түрэг бичгийн хэл, худам монгол бичгийн хэлний зэрэгцээ (ижил) үгсийн бүтэц-авиан зүйн зөрөө нь худам монгол бичгийн хэлийг эртний түрэгийн өмнөх үед, тухайлбал Нирун улсын үед холбогдуулж байна. Орхон түрэг бичгийн хэлний «erke, berke, bog» зэрэг үг нь худам монгол бичгийн хэлэнд «ere, berke, bogu» гэх мэтээр төгсгөлийн «илүү» эгшигтэй байна. Г.Рамстедт, Б.Я.Владимирцов, В.Банг, С.Мураяма, У.Пош, Н.Поппе, зэрэг алтайчдын үзэж байгаагаар худам монгол бичгийн энэ илүү эгшиг нь эртний түрэг хэлнээс өмнөх хэлбэр мөн байна (6: 323; 13: 341). Энэ бол түүхийн баримтаар нотлогдож байна. Нирун улс (402-555 он) хятад сурвалж бичгийн мэдээгээр нэлээд өндөр бичгийн соёлтой улс байсныг дээр дурдсан. Эртний түрэгчүүд Нирун улсын эрхшээлд байж байгаад 555 онд түүнийг довтлон унагаад, монгол оронд ноёрхсон билээ. Ингэхлээр эрдэмтдийн санал нэгтэй ангилсан монголын бичгийн хэлний, XIV зууны эхнээс цааш үл мэдэгдэх үе хүртэлх эртний үед (15; 83—84) нирун нарын бичгийн хэл хамаарагдах нь түүх, хэл шинжлэлийн талаар бүрэн нотлогдож байна гэж үзэж болмоор байна.

Эцэст нь «бичиг» гэдэг үгийн гарлын тухай эрдэмтдийн саналыг дурдвал:

1. Түрэгчид хятадын «бийр» гэдэг үгийн эртний дуудлага «biti»-гээс гаралтай нь эргэлзээгүй мэтээр үзэж байна (9: 162, 182, 183, 8: 103).

Монголч П.Поуха ч тэдний саналыг дагажээ (2: 18). «Бичээч» гэдэг үг анх III зууны үед сяньби угсааны табгач хэлэнд гарсан юм (3: 114). «Бичиг» гэдэг үг бичгийн хэрэгсэл «бийр» гэдэг үгнээс гарсан гэхэд үнэмшил багатай, учир нь бийрнээс өмнө, бичсэн бичгийг хүн үзэх ёстой.

2. К.Сиратори зэрэг эрдэмтэн «бичиг» гэдгийг монгол хэлний үгнээс гарсан гэж үзэж байна (3: 115). Монгол орны монгол, түрэг угсааны нүүдэлчдээс бүр урьд өрнө, дорно дахинд бичгийн өндөр соёл бий болсон болохоор уг үг зээлдмэл үг байх нь эргэлзээгүй мэт. Монгол орны эртний нүүдэлчдийн хувьд хятадын иргэншлийн нөлөөг бодвол энэтхэг-европын зүгийн иргэншлийнх нь илт давамгайл байгаа учир «бичиг» гэдэг үг нь орос хэлний «писать» (бичих), «письмо» (бичиг) гэдгийн «пис-» язгууртай гарал нэгтэй гэж үзэх нь түүх, хэлний талаар бүрэн нотлогдож болмоор байна. Орос хэлний «пис-» язгуур нь нийт энэтхэг-европ хэлний «pimsati», «pin-

gere», «pesa», «preisai» мэтийн «зурах, эрээчих, гоёх» гэх утгатай үгнээс үүссэн гэж эрдэмтэд санал нэгтэй үзэж байна (7: 110; 12: 336, 339). Д.Д. Доржиевын бичсэнээр буриадууд Октябрийн хувьсгалаас өмнө худам монгол бичиг хэрэглэж байхдаа «бичих» гэхийг «зурах», «бэшэх» гэж хоёр янзаар хэлж байжээ (11: 107). Эдүгээ ч монголчууд «гарын үсэг зурах» гэж хэлсээр байна. Киргиз, якут мэтийн түрэг хэлэнд бичихийг мөн зурах гэж хэлдэг байна (6: 188).

Энэ нь уг үгийн эртний утга хадгалагдсаар байгаагийн гэрч мөн байх.

НОМЗҮЙ

1. БНМАУ-ын түүх (нэмж засварласан гурав дахь хэвлэл). УБ. 1984.
2. П. Поуха. Монголын нууц товчоо бол түүх ба уран зохиолын дурсгалт бичиг мөн. УБ. 1957.
3. Г. Сүхбаатар. Сяньби. УБ. 1971.
4. Ц. Хандсүрэн. Жужаны аж байдал, соёл, зан заншлын тухай. Түүхийн судлал, т. VIII, f. 1—12. УБ. 1969. 67—80-р тал.
5. Большой китайско-русский словарь. т. 2. М., 1983.
6. Б. Я. Владимирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия. Л. 1929.
7. Т. В. Гамкрелидзе, Вяч. Вс. Иванов. Индоевропейский язык и индоевропейцы. I, II. Тбилиси. 1984.
8. Древнетюркский словарь. Л. 1969.
9. Зарубежная тюркология. Выпуск I. М. 1986.
10. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Введение, перевод и комментарии В. С. Таскина, М. 1984.
11. Материалы по истории и филологии Центральной Азии. Выпуск. 4. Улан-Удэ, 1970.
12. Н. М. Шанский, В. В. Иванов, Т. В. Шанская. Краткий этимологический словарь русского языка. М. 1971.
13. А. М. Щербак. О причинах структурно-фонетических расхождений в тюрко-монгольских языковых параллелях-Исследования по восточной филологии (к семидесятилетию профессора Г. Д. Санжеева). М. 1974. с. 340—350.
14. Arnuff Kollautz, Hisayuki Miyakawa. Geschichte und Kultur eines Völker-Wanderungszeitlichen Nomadenvolkes. Die Joujan der Mongolei und die Awaren in Mitteleuropa. I Teil. Die Geschichte BONN 1970.
15. Mongolica. Памяти академика Бориса Яковлевича Владимирцова. 1888—1931. М., 1986.
16. Nicholas Poppe. Grammer of Written Mongolian. Wiesbaden. 1964.

Д. Төмөртоогоо

УРАД ГҮҮШ БИЛГИЙНДАЛАЙН БҮТЭЭЛИЙН ТУХАЙ

Хуучин бичиг зохиолд Урад гүүш Билгийндалай хэмээн алдаршсан Шаравжамц бол XVIII зууны үед байсан нэрт орчуулагч, хэл бичгийн эрдэмтэн хүн юм. Бээжин хотын төвд сургуулийн багш, Сүн-жү-сэ («Ариун суурин») сүмийн тэргүүн лам байсан тэр хүн монгол, төвд, хятад хэлийг тэгш сайн мэддэг эрдэм боловсролтой сэхээтний нэг байжээ. Гүүш Билгийндалайн тухай тусгайлан дурдсан намтар түүхийн зүйл уламжлан үлдээгүй учир түүний амьдрал, бүтээлийн талаар дэлгэрэнгүй мэдэх боломжгүй байна. Хэдий тийн боловч эдүгээ бидний гарт дамжин хүрч ирсэн түүний зарим ном зохиолд тулгуурлан ажил бүтээлийнх нь талаар товч дурдъя.

Гүүш Билгийндалай монгол, төвд хэлийг зааж сургахынхаа зэрэгцээ Манжийн Найралт Төвийн хааны үеэс аваад Тэнгэрийн Тэтгэсэн хааны үеийг гартал Ганжуур, Данжуурын монгол орчуулгыг ариутган шүүж, эртний Энэтхэгийн үлгэр домог, яруу найраг, гүн ухаан, эм засал, шашны сургаал зэрэг мэдлэг ухааны олон салбарыг хамарсан өдий төдий зохиол орчуулжээ. Түүний хянан засаж орчуулсан нэлээд бүтээл монгол Данжуурын 66, 114, 131, 179, 206 дугаар ботиудад орсон байна. Тэдгээрээс тоймтой заримыг дурдвал, Жаруудын гүүш Чойжамц, Цахар гүүш Лувсанбалдан, маарамба Ишлуvsан нарын орчуулсан «Хутагт ланкад одсон хэмээх их хөлгөн судрын тайлбар, түүнчлэн ирсний зүрхний чимэг», «Бирозана илт туулсан Бодийн дандрагийн хураангуй утга», «Найман гишүүтийн зүрхэн хэмээгдэх эм заслын номлолгоо» зэрэг болно. Түүний шинэчлэн зассан бас нэг томоохон бүтээл бол «Бодисад нарын явдалд орохуй» хэмээх 913 бадаг шүлэг бүхий гүн ухааны яруу найраг юм. Энэ зохиолыг манай эриний долдугаар зууны үед эртний Энэтхэгийн гүн ухаантан Шантидева (Шиваанлха) самгард хэлээр туурвижээ. Түүнийг анх тавдугаар жарны хөхөгчин могой жил

(1305) монголын нэрт орчуулагч Чойжи-Одсэр орчуулсныг хожим XIII жарны шар луу (1748) гүүш Билгийндалай дахин хянан засварласан ажээ. Энэ тухай уг орчуулгын төгсгөлийн үгэнд тодорхой дурдсан бий (1).

Гүүш Билгийндалайн хянан зассан энэ орчуулга бидэнд хоёр өөр хувилбараар уламжлан иржээ. Түүний нэг нь Бээжингээс монголч эрдэмтэн О. М. Ковалевскийн олж авчирсан гар бичмэл эх юм. Хожим түүнийг академич Б. Я. Владимирцов BIBLIOTHECA BUDDHICA (Буддын судлалын номын сан) цувралын нэгэн дэвтэр болгон тусгайд нь нийтлүүлсэн билээ (2). Гүүш Билгийндалайн хянан зассан энэ орчуулга Чойжи-Одсэрийн анхны орчуулгаас аль хэр зөрөөтэй болсон тухайд эрдэмтдийн санал өөр өөр байна. Тухайлбал, нэрт монголч О. М. Ковалевский, Б. Лауфер нар Билгийндалайн орчуулгыг Чойжи-Одсэрийн анхны орчуулгаас нэлээд өөр болсон гэж тэмдэглэжээ (3). Гэтэл академич Б. Я. Владимирцов энэ талаар: «...Урад гүүш Билгийндалайн хянан зассан орчуулга нь Чойжи-Одсэрийн анхны эх орчуулгаас аль хэр зөрөөтэй болсныг батлах ямар ч баримт бидэнд алга» гэж дурдсан байна (4, 3). Үнэхээр ч дурдсан хоёр орчуулгыг харьцуулан үзэх бодит баримт сэлт олдоогүй байсан тэр үед тэдгээрийн хоорондын ялгаа зөрөөний тухай тодорхой мэдэх ямар ч аргагүй байсан билээ. Харин 1312 онд Чойжи-Одсэрийн зохиосон «Бодисад нарын явдалд орохуйн тайлбар»-ын сүүлчийн арван хуудас XX зууны эхээр Турфанаас олдсоныг хожим академич Ц. Дамдинсүрэн, профессор Ф. В. Кливез, Э. Хениш нар тус судлан нийтлүүлсэн нь (5) Чойжи-Одсэрийн жинхэнэ эх орчуулгын зарим хэсгийг гүүш Билгийндалайн хянан зассан орчуулгатай харьцуулан үзэх таатай боломж бий болгосон байна. Учир нь Турфанаас олдсон тэр тайлбарын дотор Чойжи-Одсэрийн анхны орчуулгын гучин бадаг шүлэг уламжлагдан үлджээ.

Бид энд дурдсан хоёр орчуулгын хоорондын ялгааг тодруулахын тулд зарим бадгийг харьцуулан үзье.

А. 1305 онд Чойжи-Одсэрийн орчуулсан анхны эхээс:

28. Oqtarqui-yin sang metu bugude
Daqusqali-ugei ed tavar-tan boltuqai
Temeceldukui konugegci ugegui-e
Ober-un durabar edlekui boltuqai
29. Ocuguken coq-tan amitan
Yeke coq-tu boltuqai
Qataqujiqci maqui beye-ten
Boltuqai tegus sayin beye-tu

Б. 1748 онд Билгийндалайн хянан зассан орчуулгаас:

28. Oqtarqu-yin sang metu buguden-de:

Barasi-ugei ed tavar-tan boltuqai:

Temeceldukui konugegci ugegui-e:

Ober-un dur-a-bar edleku boltuqai:

29. Ocuguken coq-tan amitan:

Yeke coq-tu boltuqai:

Qataqujiqci maqu bey-e-ten:

Tegus sayin bey-e-tu boltuqai:

Дээрх харьцуулсан жишээнээс үзвэл, гүүш Билгийндалайн хянан зассан орчуулга нь Чойжи-Одсэрийн анхны орчуулгаас шүлгийн хэм хэмжээ, үг сонголт, хэл найруулгынхаа талаар төдий л зөрөөгүй болсон байна. Ер гүүш Билгийндалайн орчуулгын төгсгөлийн үгэнд дурдсанаас авч үзвэл, тэр Чойжи-Одсэрийн анхны эх орчуулгын чанар чансааг голсондоо бус, харин XIV зууны монгол бичгийн хэлээр бичигдсэн хуучин эхийг XVIII зууны монгол бичгийн хэлний онцлогт тохируулж бага зэрэг хянан зассан гэдэг нь тодорхой мэдэгдэж байна.

Гүүш Билгийндалайн хянан зассан орчуулгын нөгөө нэг хувилбар нь монгол Данжуурын 114-р ботид бий билээ. Галдан ширээт Лувсандамбийнямын дараагаар Данжуурын монгол орчуулгыг эрхлэн хийлгэж байсан хоёрдугаар Жанжаа хутагт Ролбидорж (1717—1786) түүнийг Данжуурын орчуулгын тогтсон загварт тохируулан дахин зассан нь тэр билээ (6). Академич Б.Я. Владимирцов дээр дурдсан хоёр хувилбарыг бие биетэйгээ маш адил, тун ялимгүй ялгаатай боловч О.М. Ковалевскийн олсон гар бичмэл эх (Билгийндалайн хянан зассан эх) нь Данжуурт байгаа орчуулгаасаа илүү зөв юм гэж тэмдэглэсэн байна. Гэвч уг хоёр хувилбарыг өөр хооронд нь харьцуулан үзвэл, бие биеэсээ ялимгүй ялгаатай гэдэг нь үнэн боловч олон хянагчийн гар дамжин сайтар засагдан Данжуур дахь орчуулга нь бичлэгийн дүрэм, нэр томъёо, хэл найруулгынхаа талаар нөгөө гар бичмэл эхээсээ илүү зөв, оновчтой болсныг хялбархан ажиглаж болно.

Гүүш Билгийндалайн орчуулсан томоохон зохиолуудын нэг нь эртний Энэтхэгийн нэрт гүн ухаантаг Арья Шура (Ловон Бавуу)-гийн зохиосон «Төрлийн цадиг» хэмээх бүтээл юм. Бурхан багшийн үйл явдлын тухай бүгд гучин дөрвөн үлгэрээс бүрдсэн энэхүү зохиолыг зөвлөлтийн самгардач эрдэмтэн А.П. Баранников, О.Ф. Волкова нар орос хэлээр орчуулан хэвлүүлснийг энэ ташрамд дурдъя (8).

Гүүш Билгийндалай зөвхөн орчуулагч төдийгүй, хэлбичгийн эрдэмтэн байсан гэдгийг өмнө дурдсан билээ. Тэрээр

«Монгол үсгийн тольтоос өчүүхэн заавар», «Монгол үсгийн ялгал ба махбодын өчүүхэн товчнууд», «Монгол үсгийн хүртээл, зүрхний тольт», «Монгол үсгийн зүрхний тольт, огторгуйн маань хэмээхээс махбодгүйгээр өчүүхэн хурааж бичсэн сургуулийн эх үсэг» зэрэг хэлзүйн бичгүүд зохиожээ. Эдгээр зохиолуудад монгол хэлний авианы бүрэлдэхүүн, тэдгээрийн хэлэгдэх шинж хийгээд тохиолдох байрлал, үгийн бүтэц, тэдгээрийн нөхцөлдөх ёс хийгээд дагаврын байрлалын тухай олон чухал асуудлыг багтаажээ.

XIV зууны үеийн нэрт хэлзүйч эрдэмтэн Чойжи-Одсэрийн зохиосон «Зүрхний тольтын тайлбар» хэмээх алдарт хэлзүйн бичгийн үндсэн бөлгүүдийг хэсэгчлэн тайлбарласан шинжтэй дээрх зохиолууд нь XVIII зууны хэлзүйч равжамба Данзандагвын «Огторгуйн маань»-тай мөр зэрэгцэхүйц үнэ цэнтэй бүтээлүүд юм.

НОМ ЗҮЙ

1. Cari-a Avadar-a nere-tu sastir egüni erten-ü mergen Coski Odser masi sayitur mongqolcilan orciquluqsan-i inu edüge kürtele olan-ta salqaju biciküi-dür öcuguken uleku dutaqu boluqsan-i-inu jing juse sume-yin Da blam-a Urad güsi Bilig-ün Dalai qaqucin qurban mongqol sastir-i qurban töbed darumal sastir kiged qurban yeke tayilburi-luq-a tokiyal-duqulun öcügüken ese neyileldugsen-i inu ICang skya qutuq-tu ekilen olan merged-ece asaqu ariqudqa jasaqad arban qutagar Bjbau-a-yin doturan Bibau-a kemekü jil-ün.
2. Б. Я. Владимирцов, Bodhicaryavatara santideva, Chos-kyi hod-zer'a, (Bibliotheca Buddhica XXVIII)
3. О. М. Ковалевский, Монгольская Хрестоматия, т. II, Казань, 1837, стр. 459; Б. Лауфер, Очерк Монгольской Литературы, Л., 1927, стр. 52.
4. Б. Я. Владимирцов. Bodhicaryavatara santideva.
5. Ц. Дамдинсүрэн. Ардчилсан Германы Шинжлэх Ухааны Академиар очсон тухай тэмдэглэл. «Шинжлэх ухаан», 1954. № 3.
E. Haenisch, Mongolica der Berliner Turfansammlung I, Ein Buddhistisches Druckfragment vom Jahre 1312, (-Abhdl. d. Dtsch. Acad. d. Wsschft. zu Berlin. No 3) Berlin, 1954; F. W. Cleaves, The Bodistw-a cari-a avatara-yin tayilbur hy Cosgi Odsir, -HJAS XVII, 1954, pp. 1—129.
6. W. Heissig, Die Pekinger lamaistischen Blödrucke in Mongolischer Sprache, (-GAF 2), Wiesbaden, 1954, s. 96.
7. Б. Я. Владимирцов Bodhicaryavatara Santideva, s. I.
8. Арья-Шура, Гирлянда джатака или сказания о подвигах бодхисатвы, Перевод с санскрита А. П. Баранникова, О. Ф. Волковой, М., 1962.

Э. Пүрэвжав
Б. Баярсайхан

«ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГСИЙН САНГИЙН СУДЛАЛЫН ҮНДЭС» НОМЫН ТУХАЙ

Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалаар сүүлийн үед гарсан томоохон бүтээлийн нэг нь «Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс» (1986) бүтээл юм.

Их дээд сургуулийн оюутан, багш нарын гарын авлага болгон хэвлүүлсэн уг хамтын бүтээлд оршил хэсгээс гадна «Орчин цагийн монгол хэлний үгсийн сан», «Утгын судлал», «Толь бичгийн судлал» гэсэн үндсэн гурван бүлгийг зүүлт тайлбарын хамт оруулсны зэрэгцээ монгол-орос нэр томъёоны хэлхээ, номзүйг багтаажээ. Энэхүү хамтын бүтээлийн I бүлгийн — «Үг», «Үгсийн сангийн бүрэлдэхүүн» хэсэг болон II бүлгийн «Хэлц үгийн» хэсгийг Ч. Догсүрэн, I бүлгийн «Үгсийн сангийн арвижин баяжих арга зам» хэсгийг Л. Болд, II бүлгийн «Хэлний утга», «Ойролцоо үгийн» хэсгийг Б. Сумъяабаатар, II бүлгийн «Ижил үгсийн» хэсгийг Ж. Сэржээ, II бүлгийн «Эсрэг үгсийн» хэсгийг Ц. Баярсүрэн, III бүлгийг бүхэлд нь Ц. Шагдарсүрэн нар бичжээ. Уг бүтээлийг Зөвлөлтийн монголч эрдэмтэн У. Ж. Дондуков, хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Г. Жамбалсүрэн, Б. Сумъяабаатар нар редакторласан байна.

Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалаар үүний өмнө ганц сэдэвт бүтээлүүд (1, 4, 5) гарсныг тэмдэглэе.

Оршил хэсэгтээ ардын хувьсгал дөнгөж мандаад байсан үед МАХН, Ардын засгийн газар улс орныхоо ирээдүйн хөгжлийн төлөвийг гаргахдаа шинжлэх ухааныг хөгжүүлэхийн зайлшгүй чухлыг бодож, Судар бичгийн хүрээлэнг 1921 оны 11-р сард байгуулсан бөгөөд монголын түүхнээ шинэ тутам байгуулагдсан шинжлэх ухааны байгууллагын эрдэм шинжилгээний гол ажил нь монгол хэл зохиол судлах явдал байсныг тэмдэглээд, БНМАУ-ын хэл зохиол судлалын чиглэлийг найман үндсэн зүйлээр тодорхойлж гаргасан байна.

Нэгдүгээр бүлэгтээ орчин цагийн монгол хэлний үг, үгсийн сангийн бүрэлдэхүүн, үгсийн сангийн арвижин баяжих арга замын талаар нэлээд дэлгэрэнгүй өгүүлжээ.

Монгол хэлний бүтцийг нарийвчлан судлахад юуны өмнө монгол хэлний үгсийг аймаглах асуудлыг нарийн боловсруулах хэрэгтэй юм (3. 225). Монгол хэлний үгсийг аймаглах талаар судлаачдын санал зөрөөтэй байдаг билээ. Уг бүтээлд монгол үгийг үгзүйн үүднээс нэр үг, хавсрал нэр, төлөөний үг, тооны үг, үйл үг, дайвар үг, дагавар үг, сул үг, холбоос, аялга үг гэж арван айд хуваасан байна. Ер нь аль ч хэлний үгсийг аймаглахад утгазүй, үгзүй, өгүүлбэрзүйн гэсэн гурван үндсэн зарчмыг баримталдаг.

Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн бүрэлдэхүүний 90 орчим хувийг монгол хэлний уугал үгс эзэлж байна.

Эл зохиолд орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн бүрэлдэхүүнийг найруулгын нь үүргийн талаас ангилахдаа: 1) аман ярианы; 2) бичиг зохиолын; 3) найруулга дундын гэж гурав ангилаад, бичиг-зохиолын гэсэн хэсэгтээ **зооглох, нойрсох, мөрдөх** гэх мэт жишээг, найруулга дундын гэсэн хэсэгтээ **идэх, унтах, одох** гэсэн жишээг авсан мөртлөө аман-ярианы найруулгын жишээнд **гудрах, чихэх, хонхойх, ширгэх, тонилох** гэх мэт үгийг авсан нь учир дутагдалтай байна. Энд жишээ татахдаа үгийг зөв сонгоогүйгээс найруулгын өнгө аяс нь баахан өөрчлөгдөхөд хүрчээ.

Монгол хэлний үгсийн сангийн хөгжин баяжих аргад: нэгдүгээрт, авианы хувирал; хоёрдугаарт, үг бүтээх дагавар; гуравдугаарт, нийлэмж үг; дөрөвдүгээрт, харь хэлний болон хуулбар үгсийг оруулжээ. «Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс» хамтын бүтээлд харь хэлний үгсийн тухай өгүүлэхдээ түрэг хэлнээс орсон үг, төвд хэлнээс орсон үг, европын хэлнээс орсон үгсийн тухай онцлон өгүүлсэн бол Ж. Төмөрцэрэн (5. 49—58) монгол хэлэнд орсон харь үгийг: а) самгарди, уйгур гаралтай үг; б) перс, араб гаралтай үг; в) хятад, манж гаралтай үг; г) төвд гаралтай үг; д) европын хэлний үг гэж тав хуваасан байна. Орчин цагийн монгол хэлэнд орсон зээлдсэн үгийн толь зайлшгүй хэрэгтэй байна.

Хоёрдугаар бүлэгтээ хэлний утга, ижил үгс, ойролцоо үгс, эсрэг үгс, хэлц үгийн талаар өгүүлжээ.

Хэлэхүйн төвшинд хэлний утгыг: хэлний доторх утга, гаднах утга гэж хоёр хуваадгийг дурдаад монгол хэлний үгсийн сангийн утгыг нэрлэсэн утга, дохиолсон утга, тодорхой утга, хийсвэр утга, шууд утга, нэр томьёоны утга, ерөнхий утга,

дүрсэлмэл утга, жир утга, догдлонгуйн утга, энгүүн утга, дан утга, ижил утга, цохолсон утга, дашилсан утга, ойролцоо утга, эсрэг утга, шилжмэл утга гэж арван найм хуваан үзсэн байна.

Уг бүтээлд ижил үг, олон утгатай үг хоёрын ялгааг гаргахыг оролдсон байна. Тухайлбал ижил үг болж байгаа үгс нь утгазүйн янз бүрийн талбайтай үгс байдаг бол олон утгат үг нь утгазүйн нэг талбай бүхий үгс байдаг гэж үзжээ.

Гуравдугаар бүлэгтээ толь бичгийн тухай ерөнхий зүйл, монгол хэлний тользүйн уламжлал, орчин цагийн монгол тользүйн талаар баримт хэрэглэгдэхүүнийг нэлээд хэмжээгээр оруулж, ултай тайлбарласан байна.

Эл бүтээлд зохиогч тользүйг уламжлал болон шинэчлэлийн хүрээнд харьцуулан авч үзсэний зэрэгцээ тользүйн талаар зохих дүн шинжилгээг хийж, цаашид тользүйн судлалыг улам боловсронгуй болгох асуудлыг ч дэвшүүлэн тавьсан байна.

Толь бичгийг доторх үгийн багтаамж, байдлаар нь өрнөдөд dictionary, lexicon, vocabulary, glossary гэж ялгаж нэрлэдгийг монгол хэлний толь бичигтэй зэрэгцүүлэн үзэж, монгол хэлний чухам ямар тольтой дүйхийг нь гаргаж өгсөн байна.

Толь бичгүүдийг нэвтэрхий толь, хэл шинжлэлийн толь гэж хуваадаг ерөнхий ангиллыг дурдаад, орчин цагийн монгол хэлний толийг монгол толь бичгийн уламжлалтай нягт хослуулж их амжилт олсныг, тэрчлэн толийн шинэ хэлбэрүүд бүрэлдэн тогтсоныг жишээ баримтаар өгүүлжээ.

Монгол хэлний үгс орчуулгын болон тайлбар толь бичгийн толгой үг болон орохдоо хэлнийхээ нэгж болох үндсэн болон үүсмэл хэлбэрээ хадгалж явдаг гэсэн нь тользүйн онолын асуудлын хүрээнд монгол хэлний үйл үгийг толь бичигт толгой үг болгон оруулахдаа үндсээр нь оруулах уу, харин үйлт нэрийн ирээдүй цагийн хэлбэрээр (одоо нэгэнт тогтсон) оруулах уу гэдэг асуудлыг нэг тийш нь болгоход хариу болж байна.

Энэхүү хамтын бүтээлд монгол хэлний үгсийн сангийн холбогдолтой монгол-орос нэр томъёоны хэлхээг хавсаргасан нь нэр томъёог жигдлэх, ерөнхий хэл шинжлэлийн онол, бүтээлтэй танилцах явдалд хүмүүст тус дөхөм болжээ.

«Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс» хамтын бүтээл нь монгол хэл шинжлэлийн үгсийн сангийн судлалын асуудлыг ерөнхий хэл шинжлэлийн онолтой холбож үзүүлэхийг оролдсоноороо ач холбогдолтой бүтээл болжээ гэж үзэж байна.

Харин эл номыг дөнгөж нэг мянгахан хувь хэвлэсэн нь учир дутагдалтай байна. Их дээд сургуулийн багш, оюутнуудын болон нийт хэрэглэгчдийн хүрээг харгалзан үзэхгүйгээр уг номыг цөөн тоотой хэвлэснээс хэвлэгдэж гараад төдий л удаагүй боловч одооноос олдохуйяа бэрх болсныг тэмдэглэж хэлмээр байна.

НОМЗҮЙ

1. Т. А. Бертагасв. Лексика современных монгольских литературных языков. М., 1974.
2. Ш. Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн зарим асуудалд. МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. VI боть. № 2 (13) УБ. 1962.
3. Ш. Лувсанвандан. Монгол хэл шинжлэлийн асуудлууд. УБ., 1981.
4. Ж. Төмөрцэрэн. Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлал. УБ. 1964.
5. Ж. Төмөрцэрэн. Монгол хэлний үгсийн сангийн судлал. УБ., 1974.

ГАРЧИГ

I ҮГ ЗҮЙ

1. Л. Балдан. Тодотгон холбох нөхцөлийн байрлалын тогтолцоо, найруулгын үүрэг 3
2. Л. Болд. Үгсийн аймгийн системд төлөөний үгийн эзлэх байр 14
3. Д. Цэрэнпил. Монгол хэлний залгавар бүтээврийн ерөнхий ангиллын асуудалд 24

II ӨГҮҮЛБЭР ЗҮЙ

1. Г. Ц. Пюрбеев. Типы словосочетаний с повтором деепричастных форм в монгольских языках 34
2. О. Самбуудорж. Өгүүлбэрийн гишүүн тэгээр илрэх нь 39
3. Б. Пүрэв-Очир. Монгол хэлний «харин» гэдэг холбох үгийн утга, үүрэг, найруулгад хийсэн зарим ажиглалт 45

III ҮГСИЙН САНГИЙН СУДЛАЛ

1. Н. Батжаргал. МНТ дахь «арбуха» ба «цоорха» гэдэг нэрийн тухай шинэ судалгаа 51
2. Б. Намжилов. К вопросу о военной терминологической лексике в «Сокровенном сказании» 65
3. В. И. Рассадин. Охотничья терминология в языке «Сокровенного сказания» 73
4. Ж. Сэржээ. Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн зарим онцлог 80

IV НУТГИЙН АЯЛГУУ СУДЛАЛ

1. Б. Амаржаргал. Баруун халхын аман аялгууны үгсийн сангийн харьцуулсан онцлогоос 86

V БИЧИГ ҮСГИЙН СУДАЛГАА

1. Э. Пүрэвжав. Монгол хэл зүйн бичгүүдэд зөв бичих, зөв дуудах асуудлыг тусгасан нь 92
2. Г. Сүхбаатар. Нирун нарын бичгийн тухай асуудлаас 98
3. Д. Төмөртоогоо. Урад гүүш Билгийн далайн бүтээлийн тухай 103

VI ШҮҮМЖ

1. Э. Пүрэвжав, Е. Баярсайхан. «Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс» номын тухай 107

Хамтын бүтээл
Монгол хэл шинжлэл

Техник редактор Ө. Жадар
Хянагч Д. Сугар

Өрөлтөнд 1992 оны 5-р /сард орж
Хэвлэлтэнд 1992 оны 6-р сард 500 хувь хэвлэв.

Цаасны хэмжээ 60x84/16

Утга зохиолын үсэг

Хэвлэлийн хуудас 7.0 За № 22

ШУХЭвлэлийн «Эрдэм» пүүст хэвлэв.
Нэгдсэн үндэстний гудамж-19, Улаанбаатар.